



# 4 ЦАГДАА БА ХҮНИЙ ЭРХ ААНЫ САН ХАМГААЛАГЧИД

НИДЕРЛАНДЫН ЭМНЕСТИ ИНТЕРНЭШНЛ

– Гарын авлагын цуврал #4

ЭМНЕСТИ  
ИНТЕРНЭШНЛ



## Агуулга

<b>Өмнөтгөл</b>	<b>3</b>
<b>1. Удиртгал</b>	<b>5</b>
<b>2. Олон улсын хэм хэмжээ</b>	<b>7</b>
<b>3. Хүний эрх хамгаалагчид ба цагдаа хууль хэрэгжүүлэх нь</b>	<b>9</b>
3.1. Удиртгал	9
3.2. Эрх зүйн орчныг танин мэдэх нь	10
3.3. Хандлагыг ойлгох нь	16
3.4. Хэрхэн харилцах вэ?	18
3.5. Дүгнэлт ба зөвлөмж	22
<b>4. Цагдаа хүний эрхийг зөрчигч болох нь</b>	<b>23</b>
4.1. Удиртгал	23
4.2. Эрх зүйн орчныг танин мэдэх нь	23
4.3. Хандлагыг ойлгох нь	25
4.4. Хэрхэн харилцах вэ?	26
4.5. Дүгнэлт ба зөвлөмж	28
<b>5. Цагдаа хамгаалагч болох нь</b>	<b>29</b>
5.1. Удиртгал	29
5.2. Эрх зүйн орчныг танин мэдэх нь	30
5.3. Хандлагыг ойлгох нь	32
5.4. Хэрхэн харилцах вэ?	34
5.5. Дүгнэлт ба зөвлөмж	37
<b>6. Үр дүнтэй яриа хэлэлцээ хийх нь: Боломж ба Сорилтууд</b>	<b>39</b>
6.1. Удиртгал	39
6.2. Хэнтэй ярилцахаа шийдэх нь	40
6.3. Хандлагыг ойлгох нь	42
6.4. Хэрхэн харилцах болон урхинд орохоос сэргийлэх нь	44
6.5. Дүгнэлт ба зөвлөмж	48
<b>7. Төгсгөлийн үг болон зөвлөмжүүд</b>	<b>49</b>
<b>8. Хүний эрх хамгаалагчдын ашиглах баримт бичгүүд</b>	<b>51</b>

Нүүр зураг:

Өмнөд Солонгосын Эмнести Интернэшл байгууллагын ажилтан Сөүл хот дахь Туркийн Элчин Сайдын Яамны гадаа шоронгийн өрөөг дүрсэлсэн самбар барин эсэргүүцлээ илэрхийлж байгаа нь. 2018 он, © Эмнести Интернэшл

**«Өнгөрсөн 20 жилийн хугацаанд бид Хүний эрх хамгаалагчдын Тунхаглалыг баталж, чухал өөрчлөлтийн гэрч болсон билээ. Иймдээ ч Тунхаглал хүчин төгөлдөр үйлчилж байгаа гэсэн найдлага өсөн нэмэгдэж байна. Энэ нь сая сая хүний илүү эрх чөлөөтэй, илүү шударга, илүү тэгш боломжтой, хүн бүр эрхээ эдэлдэг нийгэмд амьдрах хууль ёсны хүсэл тэмүүлэл билээ. Үүнийг бодит үйл хэрэг болгохоор тэмцэж буй хүмүүсийг энэ цаг үеийн баатрууд гэж үзэх ёстой.»**

НҮБ-ын Ерөнхий Ассамблей, Хүний эрх хамгаалагчдын нөхцөл байдлын асуудлаарх Тусгай илтгэгчийн тайлан, A/HRC/34/52 (2017 оны 1 дүгээр сарын 23), 80 дугаар догол мөр.

**UIH.MN**  
**СУДАЛГААНЫ САН**

## Өмнөтгөл

Дэлхий даяар хүний эрх хамгаалагчид үйл ажиллагаагаа явуулахдаа хэв журам сахиулахтай холбоотой асуудалд анхаарал хандуулж, цагдаатай харилцах нь нэмэгдсээр байна. Тухайлбал, хүний эрх хамгаалагчид цагдаагийн ажиллагаанд өртсөн хүмүүсийн эрхийг хамгаалахын тулд цагдаагийн үйл ажиллагаанд хяналт тавих нь нэмэгджээ. Хэв журам сахиулах нь нарийн төвөгтэй ойлголт бөгөөд цагдаагийн үйл ажиллагаанд учрах хүндрэл бэрхшээл, эрсдэлийн талаарх хангалттай мэдлэг, ойлголтгүй байх нь хүний эрхийг хамгаалчдын нэр хүнд, үйл ажиллагааны үр нөлөөг бууруулж, өөрсдийнхөө аюулгүй байдал, түүнчлэн эрх зүйн хамгаалалт шаардлагатай байгаа бусад иргэдийн эрхэд хохирол учруулахыг үгүйсгэхгүй.

Энэхүү гарын авлагын зорилго нь хэв журмыг сахиулахтай холбоотой харилцаанд хэрхэн ажиллах талаарх шинэ, туршлага багатай хүний эрх хамгаалагчдын чадавхийг нэмэгдүүлэхэд оршино. Түүнчлэн өөрт болон бусдад тохиолдож болох аливаа эрсдэлийг бууруулах, түүнээс зайлсхийх, хэв журам сахиулахтай холбоотой хүний эрхийн асуудлыг хэрхэн үр дүнтэй гаргаж тавих вэ гэдгийг авч үзэв. Хүний эрхийн байгууллагууд хэв журам сахиулахтай холбоотой асуудлаар хамгаалагчдад сургалт явуулах, сургалтын агуулгаа боловсруулахдаа энэхүү гарын авлагыг удирдамж болгон хэрэглэх боломжтой бөгөөд туршлагатай хүний эрхийн хамгаалагчид ч шинэлэг, сонирхолтой мэдээллийг олж авна хэмээн итгэж байна.

Гэхдээ, тухайн асуудлын нарийн төвөгтэй байдал, улс орнууд хоорондын ялгаа, хүний эрх хамгаалагчдын үйл ажиллагаа явуулж байгаа орчин нөхцөл зэргээс хамааран энэ гарын авлагад дурдсан зүйлс нь цагдаатай харилцахдаа анхаарвал зохих бүрэн төгс зөвлөмж, шийдэл биш болохыг уншигч та анхаараарай. Түүнчлэн хүний эрх хамгаалагчид цагдаагийн хууль бус үйл ажиллагаанаас өөрсдийгөө хамгаалах аюулгүй байдлын гарын авлага биш болохыг онцлон тэмдэглэж байна.

**UIH.MN**  
СУДАЛГААНЫ САН



## Удиртгал

«Хүн бүр ганцаар болон бусадтай эвлэлдэн нэгдэж, үндэсний болон олон улсын түвшинд хүний эрх, үндсэн эрх чөлөөг хамгаалах, хүндэтгэн биелүүлэх явдлыг хөхиүлэн дэмжих, түүний төлөө тэмцэх эрхтэй.»

**Нийтээр хүлээн зөвшөөрсөн хүний эрх, үндсэн эрх чөлөөг хамгаалах, хөхиүлэн дэмжих хувь хүн, нийгмийн нэгж, байгууллагын эрх, үүргийн тухай НҮБ-ын тунхаглал (үүнээс хойш Хүний эрх хамгаалагчдын тунхаглал гэх) –ын нэгдүгээр зүйл.**

Хүний эрхийг хамгаалах, хэрэгжүүлэх нь Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал, бүс нутгийн болон олон улсын хүний эрхийн олон тооны гэрээ, баримт бичгүүдэд хүлээн зөвшөөрөгдөж, тусгалаа олсон хүн нэг бүрийн эдэлбэл зохих эрхийг баталгаажуулсан чухал үйл хэрэг юм. Сүүлийн жилүүдэд дэлхий нийтээр хүний эрхийг хамгаалах, эдлүүлэхэд анхаарлаа хандуулж, үүнд хүний эрх хамгаалагчдын гүйцэтгэж буй үүрэг оролцооны чухлыг хүлээн зөвшөөрөх нь нэмэгдэж байна.

НҮБ-ын Хүний эрх хамгаалагчдын тухай Тунхаглал болон НҮБ-ын Хүний эрх хамгаалагчдын талаар гаргасан баримт мэдээлэлд<sup>1</sup> тулгуурлан Эмнести Интернэшнл хүний эрх хамгаалагчдыг дараах байдлаар тодорхойлжээ.

Хүний эрх хамгаалагч гэх ойлголтод ялгаварлан гадуурхалт болон хүчирхийлэл, хүний эрхийн түгээмэл байдлыг үгүйсгэх, бусдын эрхийг дорд үзэх явдлын эсрэг хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалахын төлөө ажиллаж буй хэн бүхэн хамаарна.

Үүнд мэргэжлийн болон мэргэжлийн бус хүний эрхийн ажилтнууд, сайн дурынхан, сэтгүүлч, хуульч болон тэр ч байтугай хүний эрхийг хангах, хамгаалах үйл ажиллагаанд хааяа нэг гар бие оролцдог хэн бүхэн багтаж байгаа юм.



2006 оны 3 сарын 28-нд Филиппиний Нэгдсэн Эмнэлгийн гадаа эмнэлгийн ажилтнууд "Иргэний эрх чөлөөг хамгаал" гэсэн бичгийг биен дээрээ бичиж, засгийн газрын эсрэг эсэргүүцлээ илэрхийлж байгаа нь. © REUTERS/Romeo Ranoco

<sup>1</sup> НҮБ-ын Хүний Эрхийн Дээд Комиссарын газар, Мэдээллийн хуудас #29: Хүний эрх хамгаалагчид: Хүний эрхийг хамгаалах эрхийг хамгаалах нь (2004)

Хүний эрх хамгаалагчдын анхаарлаа хандуулж буй асуудал, хэрэглэж буй арга хэрэгсэл болон ажиллаж байгаа орчин нөхцөл зэрэг нь улс орон бүрт харилцан адилгүй байдаг. Гэхдээ хүний эрх хамгаалагчдын үйл ажиллагаа хууль сахиулах байгууллагын ажилтнуудын үйл ажиллагаатай огтлолцох нь түгээмэл.<sup>2</sup> Хүний эрх хамгаалагчдын ажиллаж байгаа хэргээс шалтгаалан хууль сахиулах байгууллагатай ямар асуудлаар харилцах нь ч мөн харилцан адилгүй байдаг. Зарим тохиолдолд цагдаагийн байгууллага нийгмийн тодорхой бүлгийг илт ялгаварлан гадуурхаж, хууль бусаар хүч албадлага хэрэглэх, эрүүдэн шүүх болон шүүхээс гадуур цаазлах гэх мэтээр хүний эрхийг ноцтой зөрчиж болзошгүй. Хэдийгээр цагдаа нар хүний эрхийг зөрчиж, түүнийхээ төлөө хариуцлага хүлээхгүй байж мэдэх хэдий ч хүний эрхийг хууль ёсны шаардлагад нийцүүлэн хамгаалах төрийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг. Ялангуяа, тодорхой төрлийн гэмт хэргийн эсрэг арга хэмжээ авах, хохирогчийг хамгаалах гэх мэт үйл ажиллагаагаар дамжуулан цагдаа нар тухайн тулгарч буй асуудлыг тодорхойлох, шийдэл боловсруулахад хувь нэмрээ оруулдаг. Энэ тохиолдолд хүний эрх хамгаалагчид тулгарч буй хүндрэл, бэрхшээлийг тодорхойлоход цагдаа нарт дэмжлэг үзүүлж, цагдаа болон эрх нь зөрчигдсөн иргэдийн дунд зуучлагчаар ажиллаж болох юм.

Ажиллаж буй хэрэг нь цагдаагийн үйл ажиллагаатай шууд хамааралгүй байсан ч олон нийтийг хамарсан жагсаалын үеэр болон хамгаалалт шаардлагатай болсон үед хүний эрх хамгаалагчид цагдаа нартай өдөр тутмын ажлын шаардлагаар харилцах боломжтой. Зарим тохиолдолд цагдаагийн байгууллага айлган сүрдүүлэх, цагдан хянах, баривчлах, хүч хэрэглэх зэргээр хүний эрх хамгаалагчдад саад бэрхшээл, аюул учруулж болзошгүй.

Хууль сахиулах байгууллагын ажилтнууд болон хүний эрх хамгаалагчид ямар нөхцөлд өөр хоорондоо харилцахаас үл хамааран хамгаалагчид хэнтэй, ямар асуудлыг, хэрхэн шийдвэрлэхээр ажиллаж байгаа вэ гэдгээ ойлгох нь чухал юм.

- Хүний эрх хамгаалагчид цагдаагийн эрх хэмжээ, үйл ажиллагаа явуулдаг дүрэм журмын талаар ойлголттой байх хэрэгтэй. Цагдаа чиг үүргээ гүйцэтгэхдээ хуулийн дагуу ямар тодорхой арга хэмжээ авах, ямар хүрээнд, ямар сонголт хийх талаар ойлголт мэдлэгтэй болох нь зүйтэй.
- Хүний эрх хамгаалагчид хууль сахиулах байгууллагын тогтолцоотой танилцаж, тухайн үеийн нөхцөл байдлын талаар таамаг дэвшүүлэх зэргээр цагдаагийн ажилтнууд шиг сэтгэж сурах хэрэгтэй.
- Хүний эрх хамгаалагчид цагдаагийн хэв журам сахиулсан ажиллагааны тухай ярих, олон нийтэд мэдээлэх, хэв журам сахиулагчидтай шууд харилцахдаа өөрсдийн шаардлага, шүүмжлэл, уриалгаа хэрхэн зөв аргаар илэрхийлэх талаар сайтар бодолцох хэрэгтэй. Энэ нь үйл ажиллагаа бүтэлгүйтэх, алдаанд хүрэхээс сэргийлэх зорилготой болохоос биш асуудал ээдрээтэй болох үед хүний эрхийн хамгаалагчид нь өөрсдийн үйл ажиллагаандаа хэт их цензур, хязгаарлалт тогтоо гэсэн үг огтоос биш. Хэрвээ мэдэгдэл гаргавал баримтад тулгуурласан, хуулинд нийцсэн байх бөгөөд ядаж л цагдаа нарт цагдаагийн мэргэжлийн бодит байдал, бэрхшээлийн талаар эргэцүүлэх, эргэн харах боломж олговол зохино.
- Хэрэв цагдаатай харилцахад амаргүй байгаа бол хүний эрх хамгаалагчид цагдаагийн ажлын өөрийнх нь эрсдэл, тэдний хувийн аюулгүй байдалтай холбоотой зэрэг цагдаатай шууд харилцахад гарах эрсдэлүүдийг бодолцож үзнэ. Үүнийг тооцох нь болзошгүй эрсдэлийг бууруулах, зайлсхийх боломжит арга замыг тодорхойлох, ухаалаг шийдвэр гаргах боломжийг олгоно.

Энэ гарын авлага хүний эрх хамгаалагчдын зүгээс бодит нөхцөл байдлыг харгалзан цагдаатай хэрхэн харилцах талаарх дээр дурьдсан хүчин зүйлүүдийг авч үзэх болно. Хүний эрх хамгаалагчдын эрхтэй холбоотой олон улсын хэм хэмжээг товч танилцуулсан 2 дугаар хэсгийн дараа 3-5 дугаар хэсгүүдэд цагдаа хүний эрх хамгаалагчтай харьцуулахад өөр чиг үүрэгтэй болохыг авч үзнэ. Цагдаа нь хууль сахиулах үүргээ гүйцэтгэж байхдаа нэг талаар хүний эрх зөрчих боломжтойн зэрэгцээ мөн эрсдэлд байгаа хүний эрх хамгаалагчдыг хамгаалах үүргийг гүйцэтгэдэг. 6 дугаар хэсэгт цагдаагийн байгууллагатай үр дүнтэй хамтын ажиллагаа явуулахад тулгардаг бэрхшээл, боломжуудын талаар авч үзэх бол 7 дугаар хэсэгт төгсгөлийн үг болон зөвлөмжүүдийг орууллаа.

<sup>2</sup> Хууль сахиулах байгууллагын ажилтан гэдэг нэр томъёо нь баривчлан саатуулах бүрэн эрх бүхий цагдаагийн хүчин болон бүхий л цэргийн хүчнийг багтаасан ойлголт юм. Ойлгомжтой байлгах үүднээс “цагдаа” гэдэг нэр томъёог бас хэрэглэсэн бөгөөд энэ нь цагдаагийн бүрэн эрхийг хэрэгжүүлдэг хууль сахиулах бусад албан хаагчдыг багтаасан өргөн ойлголт болно.

## Олон улсын хэм хэмжээ

1998 оноос хойш хүний эрх хамгаалагчдыг хамгаалах, үйл ажиллагааг нь дэмжих бүс нутгийн болон олон улсын түвшний хэд хэдэн эрх зүйн баримт бичиг гарчээ. Түүнчлэн төрийн алба хаагчдад, түүний дотор цагдаагийн байгууллагад үүрэг хүлээлгэсэн баримт бичгүүд ч батлагджээ.

Эдгээрээс дэлхийн хэмжээнд гарсан эрх зүйн гол баримт бичиг нь 1998 оны 12 сарын 8-ны өдөр НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас батлан гаргасан Хүний эрхийг хамгаалагчдын тунхаглал юм. Тунхаглалд улс орнуудын хүлээх үүргийг дараах байдлаар бүлэглэж оруулсан байдаг:

1. **Улс орнууд хүний эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжих хүчин чармайлтаа үр дүнтэйгээр хэрэгжүүлэх орчныг хүний эрхийг хамгаалагчдад бүрдүүлж өгөх ёстой.** Үүнд чөлөөтэй эвлэлдэн нэгдэх, хуран чуулах (5-р дугаар зүйл), мэдээлэл олж авах, түгээн дэлгэрүүлэх (6-р зүйл), олон нийтийг хамарсан яриа хэлэлцүүлэг болон хүний эрхтэй холбоотой үйл ажиллагаанд оролцох (6(с)-р зүйл), 7, 8, 9(За, в зүйл)), мэргэжлийн, чанартай хууль зүйн туслалцаа үзүүлэх, санал болгох (9(Зс)-р зүйл), олон улсын байгууллагатай ямар нэгэн саадгүйгээр холбогдох (9(4)-р зүйл), хүний эрх, эрх чөлөөг хөхиүлэн дэмжих, хамгаалахад шаардлагатай нөөц боломжийг хүлээн авах (13- зүйл) орно. Түүнчлэн, улс орнууд хүний эрх болон үндсэн эрх чөлөөний талаарх ойлголт, үзэл санааг дэмжин дэлгэрүүлэх үүрэгтэй (14, 15-р зүйлс).
2. **Хүний эрх хамгаалагчдын үйл ажиллагаанд хөндлөнгөөс зохисгүй байдлаар оролцох ёсгүй.** Аливаа хязгаарлалт нь зөвхөн тухайн улсын олон улсын гэрээгээр хүлээсэн үүрэгтэй нь нийцэн гарсан дотоодын хууль тогтоомж болон хүний эрхийг хангах, нийтийн дэг журам, нийтийн сайн сайхны төлөөх шаардлагад нийцсэн байвал зохино (17-р зүйл).
3. **Хүний эрх хамгаалагчид** үйл ажиллагаанд нь хууль бусаар оролцсон болон тэдний эрхийг зөрчсөн тохиолдолд **гомдол гаргах**, зөрчигдсэн эрхээ сэргээлгэх бодит боломжтой байх ёстой (9(1,5)-р зүйл).
4. **Төрийн албан тушаалтнууд шаардлагатай үед хүний эрх хамгаалагчдын эрх зөрчигдөхөөс хамгаалах** (9(1)-р зүйл), мөн хүний эрхийг хамгаалснаас үүдэн аливаа халдлага, хүчирхийлэл, өс хонзон авах явдлаас бодитоор хамгаалагдах ёстой (12-р зүйл).



НҮБ-ын Хүний эрх хамгаалагчдын нөхцөл байдлын асуудлаарх Тусгай илтгэгч, Угандагийн иргэн Маргарет Секагая (зүүн талаас 4 дэхь нь) Энэтхэгийн Шринагар хотын иргэний нийгмийн байгууллагын гишүүдтэй уулзалт хийж байгаа нь. 2011 оны 1 сарын 19-ний өдөр. © REUTERS/Fayaz Kabli



НҮБ-ын Хүний эрхийн хамгаалагчдын тунхаглалын үзэл санаанд тулгуурлан хүний эрх хамгаалагчдыг хамгаалах, дэмжих зорилгоор бүс нутгийн хэмжээнд олон тооны баримт бичиг батлагджээ. Үүнд Америкийн Улсуудын Байгууллагаас баталсан Хүний эрх хамгаалагчдын талаарх Ерөнхий Ассамблейн тогтоол, Европын Холбооноос баталсан Хүний эрх хамгаалагчдын талаарх удирдамж, Европын консулын Хүний эрх хамгаалагчдын тунхаглал болон Африкийн хүний эрх хамгаалагчдыг хамгаалах тухай Африкийн комиссийн тогтоол зэрэг багтана.

Сүүлийн жилүүдэд дэлхийн улс орнууд хүний эрх хамгаалагчдыг хамгаалах, үйл ажиллагаа явуулах баталгаат орчныг бүрдүүлэх зорилгоор үндэсний хэмжээнд хууль тогтоомжуудыг баталж байна. Эдгээр хууль тогтоомжид олон улсын хэм хэмжээг хэрхэн тусгасан байдал, түүнийгээ үр нөлөөтэй хэрэгжүүлж байгаа эсэх нь харилцан адилгүй байна<sup>3</sup>.

Хууль сахиулах байгууллагууд эдгээр баримт бичигт тусгагдсан зарчим болон зөвлөмжийг биелүүлэхэд чухал үүрэгтэй юм.

- Тэд хүний эрхийн хамгаалагчдыг холбогдох мэдээллээр хангах, жагсаал цуглаан зохион байгуулах эрхээ эдлэхэд дэмжлэг үзүүлэх, эсхүл хүний эрхийн асуудлаар харилцан зөвлөлдөх зэргээр туслалцаа үзүүлэх ёстой.
- Тэд хүний эрх хамгаалагчдыг цагдан хянах, сүрдүүлэх, дарамт шахалт үзүүлэх болон дур зоргоор баривчлах зэргээр үйл ажиллагаагаа явуулахад нь хууль бусаар саад учруулах ёсгүй.
- Тэд хүний эрх хамгаалагчдыг аюул заналхийлэл, хүчирхийлэл болон бусдын зүгээс ирэх аливаа халдлагаас хамгаалах ёстой.

Эдгээр үүргийн хэрэгжилт нь улс орны дотоодын хууль тогтоомж болон аюулгүй байдал зэрэг нөхцөл байдлаас ихээхэн хамаарна. Иймээс хүний эрх хамгаалагчид үйл ажиллагаагаа үр дүнтэй, бодитой, аюулгүй явуулахын тулд зөвхөн олон улсын хэм хэмжээний талаар ойлголттой байхаас гадна хүний эрх үндэсний хууль тогтоомж, бодлого болоод тэдгээрийн хэрэгжилтийн асуудалд зохих анхаарал хандуулах шаардлагатай.

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

<sup>3</sup> Хүний эрх хамгаалагчдын талаарх үндэсний хууль тогтоомж, бодлогын нарийвчилсан дүн шинжилгээг Олон улсын Хамгаалалт байгууллагын хүний эрх хамгаалагчдыг хамгаалах тухай олон нийтийн бодлого тайлангаас дэлгэрүүлж үзээрэй. 2017 он, <https://www.protectioninternational.org/en/node/1537>

## Хүний эрх хамгаалагчид болон цагдаа хууль сахиулах нь

### 3.1. Удирдамж

Хүний эрхийг хамгаалах үйл ажиллагаа нь хэв журам сахиулахтай шууд холбоотой эсэхээс үл хамааран хүний эрх хамгаалагчид цагдаа нартай хууль сахиулах чиг үүрэгтэй нь холбогдуулан харилцах шаардлага гарна. Гэхдээ дээрх харилцаа нь заавал цагдаа, цагдаагийн үйл ажиллагаатай сөргөлдсөн агуулгатай байх албагүй. Тухайлбал, хүний эрхийг хамгаалагчид жагсаал цуглаан зохион байгуулах болон оролцох үед цагдаа нар хүний эрх хамгаалагчдыг тэдний эсрэг эсэргүүцлээс хамгаалах, аюулгүй байдлыг хангах зэргээр тайван замаар жагсаал цуглаан хийх эрхээ эдлэхэд нь дэмжлэг үзүүлж болно.

Харамсалтай нь цагдаа нар хүний эрх хамгаалагчдын ажлыг хөнгөвчилөхөөс илүүтэй саад болох нь түгээмэл байдаг. Хүний эрх хамгаалагчдыг дур зоргоороо баривчлах, цагдан хянах, тэднийг мөрдөн шалгахын тулд эрүүгийн гэмт хэргийн субъект болгох, эсвэл эрхийг нь хамгаалахаар эрмэлзэж буй хүмүүсийнх нь эсрэг гэрч болгох ч магадлалтай.

Дэлхийн олон оронд хүний эрх хамгаалагчид, тэдгээрийн үйл ажиллагааг үндэсний хууль тогтоомжоор улам бүр хязгаарлах боллоо. Тухайлбал,<sup>4</sup>

- Жагсаал цуглаан зохион байгуулахад төрийн зохих байгууллагад энэ тухай мэдэгдэн албан ёсны зөвшөөрөл авахыг шаардах, ийнхүү зөвшөөрөл аваагүй жагсаалд оролцсон үйлдлийг гэмт хэрэг гэж үзэх зэргээр тайван замаар жагсаж цуглах эрхийг хуулиар хязгаарлах,
- Төрийн бус байгууллага байгуулах, бүртгүүлэхэд биелүүлэхэд бэрхшээлтэй, эсхүл боломжгүй шаардлагуудыг хуулиар тогтоох, төрийг дэмжээгүй үзэл санаа илэрхийлсэн байгууллагуудыг шахан зайлуулах, тэдгээр байгууллагыг хууль бус хэмээн үзэж гишүүн байхыг гэмт хэрэг үйлдсэн тооцох,
- Төрөөс хяналт тавих зэргээр үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хуулиар хязгаарлах
- Засгийн газрыг шүүмжлэх болон үг хэлээр дайрахыг хуулиар эрүүгийн гэмт хэрэгт тооцох,
- Нийгмийн тодорхой бүлгийн эрхийг хязгаарласан хууль гаргах, тухалбал, ЛГБТИ хүмүүсийн эрхийг хамгаалах явдлыг хууль бусад тооцох зэргийг дурдаж болно.

Хэдийгээр дээрх үндэсний хууль тогтоомж хүний эрхийн олон улсын хэм хэмжээг зөрчиж байгаа хэдий ч хууль сахиулагчид дотоодын хуулиа сахин мөрдүүлдэг тул хүний эрх хамгаалагчдын үйлдлийг дотоодын хууль тогтоомжийг зөрчсөн гэх үндэслэлээр хэв журам сахиулах шаардлагатай болно.

Үйл ажиллагаа явуулж буй хүрээнээс үл хамааран хүний эрх хамгаалагчид цагдаагийн байгууллагын хууль эрх зүйн болон үйл ажиллагааны цар хүрээг мэддэг байх хэрэгтэй. Үүнд: үндэсний хууль тогтоомжоор цагдаагийн чиг үүрэг, эрх хэмжээг хэрхэн тодорхойлсон эсэх эрх хэмжээгээ хэрхэн хэрэгжүүлж байгаа зэргийг дурьдаж болно. Энэ нь хүний эрх хамгаалагчид цагдаатай үр дүнтэй харилцах, тэдний дэмжлэгийн авахад дөхөм болохын сацуу цагдаатай холбоотой үүсэх аливаа сөрөг үр дагаврыг бууруулах, мөн цагдаагийн зан үйлд хэрхэн зохистой байдлаар эерэг нөлөөлөл үзүүлэх вэ гэдгийг үнэлэхэд тус болох юм.

<sup>4</sup> Жишээлбэл, Хүний эрхийн төлөө үйлчлэхүй олон улсын байгууллага, Хязгаарлалтаас хамгаалалт хүртэл: Хүний эрх хамгаалагчдын эрх зүйн орчин болон тэдний үйл ажиллагааг хөхиүлэн дэмжих, хамгаалах үндэсний хууль тогтоомжийн хэрэгцээ шаардлага судалгааны тайлан (2014 он), 5 дугаар бүлэг. Хүний эрх хамгаалагчдын үйл ажиллагааг гэмт хэрэгт тооцсон Америкийн жишээн дээр (2015 он) Америк Тивийн Улсуудын Хүний Эрхийн Комиссийн тайланг үзнэ үү. <http://www.oas.org/en/iachr/reports/pdfs/criminalization2016.pdf>

### 3.2. Эрх зүйн орчныг танин мэдэх нь

Эрхэлж байгаа албан тушаалаасаа хамааран хууль сахиулагчдын гүйцэтгэх чиг үүрэг харилцан адилгүй болохыг танин мэдэх нь ихээхэн чухал юм. Хүний эрх хамгаалагчид үйл ажиллагаагаа хуулийн дагуу явуулж байгаа нөхцөлд цагдаагийн зүгээс тэдний эсрэг ямар нэгэн арга хэмжээ авах, үйл ажиллагаанд нь саад учруулах шалтгаан байхгүй. Иймээс хүний эрх хамгаалагчид үйл ажиллагаагаа явуулахдаа дотоодын хууль тогтоомжийг аль болохоор зөрчихгүй байх сонирхолтой. Энэ нь тэдний ажилд шууд болон шууд бусаар нөлөө үзүүлдэг хууль тогтоомжуудын тухай, мөн цагдаагийн үйл ажиллагааг зохицуулдаг эрх зүйн цар хүрээг сайн мэддэг байхыг шаардаж байгаа юм.



Олон нийтийн цагдаа нар засгийн газрыг эсэргүүцэгчдийг баруун Манам дахь Будаяагийн хурдны гол зам дээрх тойрог замыг чөлөөлөхийг шаардаж байгаа нь, 2012 оны 3 сарын 26. © REUTERS/Hamad I Mohammed

Тухайн орон нутагт (зарим тохиолдолд бүс нутгийн онцлогт тохирсон) **“Эрхээ мэд”** гэх мэт олон тооны цахим зааварчилгаа интернэтэд олноороо бий. Эдгээр зааварчилгаа нь хүний эрхийг хамгаалагчдад холбогдох хууль тогтоомжийн талаар мэдээлэл олж авах энгийн, хялбар эх сурвалж болох ба ямар үйлдэл хийж болох, эсхүл болохгүй талаар мэдээлэл өгнө.<sup>5</sup> Хэрвээ иймэрхүү зааварчилгаа тухайн нөхцөл байдалд болон тухайн улсад байхгүй байгаа бол хүний эрх хамгаалагчид мөн тэдний байгууллага хамгаалагчдад зориулан боловсруулах боломжтой.

Эдгээр нь ихэнх тохиолдолд **жагсаал цуглааны** үед хэрэг болно. Жагсаал цуглаан зохион байгуулах үедээ хүний эрхийг хамгаалагчид аль болохоор дотоодын хууль тогтоомжоо баримтлахыг хичээх нь зүйтэй. Тухайлбал, мэдэгдлийн хугацааг анхаарч жагсаалыг зохион байгуулалтын хувьд хууль зөрчсөн гэж олон нийтэд зарлах шалтгаан цагдаад өгөхгүй байх хэрэгтэй. Жагсаалд оролцогчид ч жагсаал цуглааныг зохицуулдаг нарийвчилсан дүрэм журмын талаар ойлголттой байж, дотоодын хууль тогтоомжийн дагуу ямар үйлдэл хийх нь хууль бус, хориотой болохыг мэдэж байвал зохино.

<sup>5</sup> Үзэл бодлоо илэрхийлэх, жагсаал цуглаан хийх эрхийн талаарх хялбаршуулсан гарын авлага, Уганда: Үзэл бодлоо илэрхийлэх, жагсаал цуглаан эрхийн талаар юу мэдвэл зохих вэ?, 4-р бүлгээс жишээг харна уу. [http://chapterfouruganda.com/sites/default/files/downloads/What-You-Need-To-Know-About-Your-Expression-and-Assembly-Freedoms\\_0.pdf](http://chapterfouruganda.com/sites/default/files/downloads/What-You-Need-To-Know-About-Your-Expression-and-Assembly-Freedoms_0.pdf)

**«Эрхээ мэд: Жагсаал, эсэргүүцлийн цуглааны үеэр эрх чинь зөрчигдвөл яах вэ?» Индиана дахь Америкийн Иргэний Эрх чөлөөний Эвлэлээс гаргасан гарын авлагад үзэл бодлоо илэрхийлэхдээ ямар үйлдэл хийхийг зөвшөөрдөг болон тухайлан зөвшөөрөл авахгүй байж болох, цагдаатай харилцахдаа биеэ хэрхэн авч явах, эрх нь зөрчигдсөн тохиолдолд хэрхэн гомдол гаргах вэ зэргийг тайлбарласан байдаг.<sup>6</sup>**

Олон нийтийг хамарсан жагсаал цуглааныг зохицуулахтай холбоотой хүний эрхийн олон улсын эрх зүйн зохицуулалт бодлогын баримт бичгийг танин мэдэж, зөв хэрэглэх чадвартай байх нь цагдаагийн үйл ажиллагааг үнэлэхэд чухал ач холбогддолтойн зэрэгцээ шаардлагатай тохиолдолд тэдний дэмжлэгийг авахад тусална. Тухайлбал, хэрэв хууль сахиулагчид тухайн жагсаал цуглааныг хууль бус гэж үзэж байгаа бол тухайн асуудлыг харилцаанд тулгуурлан хэрхэн шийдвэрлэх арга замыг эрэлхийлэх, мөргөлдөөн гарсан үед тайвнаар зохицуулж, хүрээ хязгаарыг хумих шаардлагатай байдаг. Ийнхүү ажиллахдаа тэд жагсаал цуглааны үед хууль зөрчиж хүч хэрэглэсэн үйлдэлд оролцсон иргэдийг өөрсдийн тайвнаар жагсах эрхээ эдэлж буй жагсагчдаас ялгаж зааглах шаардлагатай байдаг. Жагсаал цуглааныг улс төрийн болоод бусад төрлийн хурцадмал байдалд шилжихээс урьдчилан сэргийлж дэлхий даяар хууль сахиулах байгууллагууд олон тооны арга зүй, хэрэглэгдэхүүн боловсруулсан байдаг.<sup>7</sup> Жагсаал цуглааныг зохион байгуулах, ажиглах үед хүний эрх хамгаалагчдад хүний эрхийн олон улсын эрх зүй болон хэм хэмжээний дагуу цагдаа нар үүргээ хэрхэн биелүүлж байгаад дүн шинжилгээ хийх, мөн тэдэнтэй тулгарсан бэрхшээлийн талаар (мөн боломжит шийдлийг олохоор) зөвлөлдөхөд эдгээр жишээ тус болно.



Жагсаалд оролцогч Манамад болсон засгийн газрыг эсэргүүцсэн жагсаалын бичлэгийг хийж байгаа нь, Бахрайн. 2012 оны 12 сарын 17. © REUTERS/Hamad I Mohammed

Хүний эрх хамгаалагчид жагсаал цуглаанд хөндлөнгийн хяналт тавих зорилгоор оролцож байгаа тохиолдолд энэ тухай, түүнчлэн цагдаагийн зүгээс тэдний үйл ажиллагаанд ямар хэмжээнд оролцох, нөлөөлөх боломжтой талаар мэдэгдэх шаардлагатай.

<sup>6</sup> <http://www.glaclu.org/wp-content/uploads/2017/02/KNOW-YOUR-RIGHTS-Protesters.pdf>; Канадын Иргэний Эрхийн Холбоо, Эрхээ мэдэх, хамгаалах нь, <https://ccla.org/cclanewsites/wp-content/uploads/2017/10/Know-Your-Rights-Guide-to-Protesting.pdf>

<sup>7</sup> Жагсаал цуглааныг зохицуулах сайн туршлагуудыг олон орны жишээн дээр харж болно, жишээлбэл, Нидерландын Эмнести Интернэшнлийн салбараас гаргасан баримт бичиг, Жагсаал цуглааныг зохицуулах нь, богино өгүүллийн цуврал #1 (2013 он), НҮБ-ын Ерөнхий Ассамблейн тайван замаар жагсаал цуглаан хийх, эвлэлдэн нэгдэх эрхийн асуудал хариуцсан Тусгай илтгэгч, хууль зөрчөөгүй жагсаал цуглааныг дур зоргоороо, хууль бусаар зогсоох асуудал хариуцсан Тусгай илтгэгч нарын хамтарсан тайлан, А/НRC/31/66 (4 February 2016), Ардчилалсан Засаглал, Хүний эрхийн асуудал хариуцсан байгууллага (АЗХЭХБ)-ын гаргасан Жагсаал цуглааныг зохицуулах хүний эрхийн гарын авлага (2016 он) нь жагсаал цуглааныг зохицуулах үед хүний эрхийг хангах талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгч чадна. АХЭХБ-ын Тайван замаар жагсаал цуглаан хийх эрхийн тухай гарын авлага (2010 онд гарсан 2 дахь хэвлэл) нь тайван замаар жагсаал цуглаан хийх эрхээ бүрэн дүүрэн эдлэх боломжийг хангахын тулд хүний эрхийн олон улсын хэм хэмжээ, дүрэм журмыг дагаж мөрдөх тухай тусгасан ба АХЭХБ-ын гишүүн бус улс орнуудад ч өргөн хэрэглэгддэг баримт бичиг юм

Тухайлбал, хүний эрхийн олон улсын хэм хэмжээний дагуу жагсаал цуглааны үед цагдаа нар үүргээ хэрхэн гүйцэтгэж байгааг жагсаал цуглаанд оролцоогүй жирийн иргэдээс эхлээд цуглааны үйл ажиллагаанд хөндлөнгийн дүн шинжилгээ хийж байгаа иргэд дүрс бичлэг хийхийг ерөнхийдөө зөвшөөрдөг бөгөөд цагдаа нар үүнд саад болох ёсгүй, Хяналтын үүрэг, оролцоонд цагдаа нар хүндэтгэлтэй хандаж, дэмжлэг үзүүлбэл зохино, хүний эрх хамгаалагчид ч энэ зорилгоор тэднийг үүрэг гүйцэтгүүлэхээр уриалах боломжтой.<sup>8</sup> Гэхдээ хяналтыг хэрхэн явуулах тухайд дотоодын хууль тогтоомжид хязгаарлалт тогтоосон байж болно. Жишээлбэл, АНУ-д видео бичлэг хийхийг ерөнхийдөө зөвшөөрдөг боловч цагдаа үүргээ хэрхэн гүйцэтгэж байгаа талаар аудио бичлэг хийх дүрэм журам нь муж улс бүрт ялгаатай байдаг.<sup>9</sup> Испанид цагдаагийн үйл ажиллагааг харуулсан бичлэг хийхийг огт зөвшөөрдөггүй. Гэхдээ, Иргэний аюулгүй байдлын тухай хуулиар цагдаагийн үйл ажиллагааг бичихийг хориглодоггүй боловч бичлэгийг зөвшөөрөлгүй гаргах нь цагдаагийн ажилтан болон тэдний гэр бүлийн аюулгүй байдалд аюул учруулах, мөн цагдаагийн ажиллагааны үр дүнд эрсдэл учруулна гэж үздэг. Эдгээр дүрэм журмын талаар нарийн мэдлэгтэй хүний эрх хамгаалагчид цагдаа нарыг бичлэг хийхээ зогсоо<sup>10</sup> гэж шаардвал, дотоодын хууль тогтоомжтой илэрхий зөрчилдсөн зүйл байхгүй, мөн олон улсын хүний эрхийн хэм хэмжээгээр баталгаажсан эрхүүдийг иш татан, илүү хүчтэй байр суурьтай байж, цагдаа нартай хэрэг явдлын талаар зөвлөлдөж чадах юм.

**«Эсэргүүцлийн цуглааны үеэр цагдаагийн хүчирхийллийг баримтжуулах тухай удирдамж»-ийн 19 дүгээр зүйл нь Бразил улсад жагсаал цуглааны үеэр хүний эрх хамгаалагчдын цагдаагийн үйл ажиллагааны талаар бичлэг хийхдээ хэрэглэдэг зааварчилгаа болдог. Бичлэгийг хэрхэн хийвэл илүү үр нөлөөтэй болох, түүнчлэн хууль тогтоомжийн дагуу хийж болох үйлдэл, түүнчлэн хуулийн хэрхэн ойлгож хэрэглэх талаарх асуулт, зөвлөмжүүдийг энэхүү зөвлөмжид тусгасан байдаг. Түүнчлэн, хэрэв цагдаа хууль бус шийдвэрээ тулгавал ямар арга хэмжээ авах талаар зөвлөсөн байдаг. Жишээлбэл, бичлэгээ зогсоох, эсвэл устгахыг шаардсан тохиолдолд цагдаагийн ажилтанд уг бичлэг цацагдаж байгаа, мөн хууль бус үйл ажиллагаанаас сэргийлэхэд тустай болохыг хэлэх хэрэгтэй гэж зааварчилгаанд зөвлөжээ.<sup>11</sup>**



“Цагдаа саатуулагдсан үедээ хэрхэх талаарх эрхээ мэд” Үндэсний Хүний Эрхийн Нийгэмлэг (Хакам)-ийн гарын авлага, 2016 он, дэлгэцийн зургийг 2018 оны 5 сард авав.

Хүний эрх хамгаалагчид жагсаал цуглааны үеэр, эсвэл ажлаа хийж байхдаа цагдаад **баривчлагдах**, магадгүй **хоригдох** нөхцөлд орж болох юм. Хүний эрхийн олон улсын эрх зүй хэм хэмжээ нь ийм нөхцөлд олон тооны хамгаалалт болон дүрэм журам хэрэгжүүлэхийг цагдаа нарт үүрэг болгосон байдаг. Эдгээрийн дундаас, цагдаа нар хүнийг баривчилах болон саатуулах үедээ баривчилсан шалтгааныг хэлж өгсөн байх, эрх зүйн туслалцаа авах (цагдаад байцаагдах үед ч мөн адил), өөрийгөө гэм буруугүй

<sup>8</sup> Дэлгэрэнгүй мэдээллийг НҮБ-ын Ерөнхий Ассамблейн тайван замаар жагсаал цуглаан хийх, эвлэлдэн нэгдэх эрхийн асуудал хариуцсан тусгай илтгэгч, хууль зөрчөөгүй жагсаал цуглааныг дур зоргоороо, хууль бусаар зогсоох асуудал хариуцсан тусгай илтгэгч нарын хамтарсан тайлан, A/HRC/31/66 (2016 оны 2 сарын 4), 68-72 догол мөрнөөс үзнэ үү.

<sup>9</sup> Цахим Хил байгууллага: Цагдаагийн ажлыг бичиж авмаар байна уу? Эрхээ мэд (2015 он), <https://www.eff.org/deeplinks/2015/04/want-record-cops-know-your-rights>

<sup>10</sup> Ley Orgánica 4/2015, de 30 de marzo, de protección de la seguridad ciudadana (2015), Art. 36.23, <https://www.boe.es/buscar/pdf/2015/BOE-A-2015-3442-consolidado.pdf>

<sup>11</sup> Advogados Activistas, Artigo 19 and WITNESS, Guia como lmar a violencia policial em protestos (2014), <http://artigo19.org/wp-content/uploads/2014/06/GUIA-WITNESS-R02-web.pdf>



гэж үзэх, дуугүй байх зэрэг олон тооны эрхийг тодорхойлж өгсөн байдаг.<sup>12</sup> Хүний эрх хамгаалагчид эдгээр эрх үндэсний хууль тогтоомжид туссан эсэх, тийм бол ямар байдлаар туссаныг мэдэх, ийм нөхцөлд эрхийнхээ төлөө гомдол гаргах чадвартай байх хэрэгтэй. Үүнд дотоодын хууль тогтоомжийн дагуу баривчилгааг хэрхэн явуулбал хууль бус гэж үзэхгүй (хууль ёсны) байх, мөн баривчлагдах үедээ ямар эрхтэй гэдгийг мэдэж байх зэрэг багтана.



«Цагдаад саатуулагдсан үед хэрхэх талаарх эрхээ мэд» Малайзын Үндэсний Хүний Эрхийн Нийгэмлэг (Хакам)-ээс боловсруулсан гарын авлагад тус улсад цагдаа хүнийг зогсоож, байцааж, баривчлах үед ямар эрхтэй байх вэ гэдгийг тайлбарлажээ. Гарын авлагад цагдаагийн ажилтан дүрэмт хувцасгүй яваа бол өөрийгөө танилцуулах мөн баривчлах, саатуулах үедээ холбогдох хүний эрхийг тайлбарлж өгөх үүрэгтэй. Мөн ямар үйлдэл хийх, байцаалтын үед ямар мэдээлэл өгөх, биед ямар төрлийн нэгжлэгийг баривчлахгүйгээр, эсвэл дараа нь хийж болох, хэн (цагдаагийн албан хаагчийн албан тушаал, жишээ нь эмнэлгийн ажилтан гэх мэт), ямар төрлийн нэгжлэг хийх эрхтэй байдаг талаар тайлбарласан байдаг.<sup>13</sup>

"Know your rights when confronted by police" leaflet by the National Human Rights Society Hakam, 2016. Screenshot taken in May 2018.

Хүний эрх хамгаалагчид хийж хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа, эсхүл байгууллагатай нь холбоотой асуудлаар цагдаагийн байгууллагад шалгагдах нь цөөнгүй тохиолддог. Хэрэв цагдаа нар хүний биед нэгжлэг, албан газарт үзлэг хийх тохиолдолд эрх бүхий этгээдээс ямар зөвшөөрөл авсан байх, ямар мэдээллийг өгөх үүрэгтэй талаар хүний эрхийг хамгаалагчид сайтар мэдэж байх нь чухал.

Хэрэв хэрэг **шүүхийн шатанд** явж байгаа бол хүний эрх хамгаалагчид өөрт байгаа мэдээллийн эх сурвалжаа ил болгох, гэрчийн мэдүүлэг өгөх шаардлага гарч болно. Ийм нөхцөлд хүний эрх хамгаалагчид тэдэнд хамааралтай хуулийн хамгаалалт тухайн улсад ямар түвшинд байдгийг мэдэх нь ихээхэн чухал. Олон улсын түвшинд хүний эрх хамгаалагчдад үзүүлэх дэмжлэг нэмэгдэж байгааг дагаад сэтгүүлчид мэдээллийн эх сурвалжаа нууцлах шаардлагатай байдагтай төстэй давуу эрх байдаг ч ихэнх улсад үүнийг дотоодын хууль тогтоомжид тусгаагүй байдаг. Гэхдээ зарим онцгой тохиолдол байдгаас жишээлбэл, Зааны Ясан Эрэг улс болон Малид хүний эрх хамгаалагчдыг хамгаалах тухай хуулийг саяхан баталжээ. Эдгээр хуулиар хүний эрх хамгаалагчдын мэдээллийн эх сурвалжаа нууцлах боломжийг баталгаажуулсан, Зааны Ясан Эрэг улсын хууль нь хамгаалагчдыг мэдээллийн эх сурвалжаа илчлэхгүй байх эрхийг маш тодорхой баталгаажуулж өгсөн байна.<sup>14</sup>

Цаашлаад, хүний эрх хамгаалагчдын олон нийттэй харилцах харилцаа нь сэтгүүлчийн үйл ажиллагаатай ижил төстэй байдгийг харгалзан үзэж мэдээллийн эх сурвалжаа хамгаалах эрхийг олгосноор ТББ-ууд хүний эрхийн асуудлаарх судалгаагаа амжилттай хийх боломж бүрдэж байгаа юм.

<sup>12</sup> Баривчилгаа болон саатуулахтай холбоотой олон улсын хэм хэмжээний талаар дэлгэрэнгүй мэдээллийг Эмнести Интернэшнлийн Шударгаар шүүлэх эрх гарын авлагаас (2 дахь хэвлэл, 2014) үзнэ үү. POL 30/002/2014.

<sup>13</sup> <http://hakam.org.my/wp/index.php/sitemap/know-your-rights-when-stopped-by-police/>

<sup>14</sup> Cote d'Ivoire Loi N° 2014- 388 du 20 Juin 2014 portant promotion et protection des défenseurs des droits de l'Homme (Art. 16) and Decret N° 2017-121 du 22 Fevrier 2017 portant modalites d'application de la Loi N° 2014- 388 du 20 Juin 2014 portant promotion et protection des défenseurs des droits de l'Homme (Art. 9, 10(e)); Mali Loi No 2018-005 du 12 Jan 2018 relative aux Defendeurs des droits de l'Homme, Art. 14; Олон улсын, бүс нутгийн болон зарим улсын нөхцөл байдалд Нээлттэй Нийгэм Шударга ёсны Санаачилгаас хийсэн дүгнэлтийг мөн үз, Curiae to the Magistrate Court, Case No. 21184/01/16, State Attorney of Israel v. Breaking the Silence.

**Сьерра Леоний асуудал хариуцсан Тусгай Шүүх (Хэргийн дугаар SCSL-2004-16-AR73), 2006 оны 5 дугаар сарын 26. Нууц хадгалах үндэслэлээр асуултанд хариулахыг шаардахгүйгээр ТФ1-15 дугаартай гэрчийн аман мэдүүлэг өгөх шийдвэрийн эсрэг прокурор давж заалдсан асуудлаар шийдвэр гаргасан байна.**

**«Сэтгүүлч мэдээллийн эх сурвалжаа хамгаалах цаад шалтгаан нь, Эмнести Интернэшнл болон Хүний эрхийн хяналт зэрэг ТББ-уудын олон нийтэд зориулж гаргасан тайланд туссан ... зарчмуудад хамааралтай юм шиг надад санагддаг. Дайны хөлд нэрвэгдсэн улсын талаар мэдээлж байгаа эрэн сурвалжлах сэтгүүлч, түрхэн зуур болоод өнгөрсөн зөрчил мөргөлдөөний талаарх дайны сурвалжлагчийн мэдээ болон хүний эрхийн байгууллагын бэлтгэсэн «дэлгэрэнгүй» тайлангуудын хооронд багахан л ялгаа бий. Хүмүүсийн нэрийг нууцлах баталгаа өгч байж авсан мэдээллээ нэгтгэн хэвлүүлэх зэргээр бүгд л үзэл бодлоо илэрхийлэх эрхээ (хамгийн гол нь хэлсэн үгийнхээ эх сурвалжийг хамгаалах эрхийг оролцуулаад) эдэлж байгаа хэрэг<sup>15</sup>».**

Хүмүүсийг хуулийн дагуу хуульч шиг хамгаалж байгаа хүний эрх хамгаалагчид нь нууц хадгалах, түүнийг задруулахгүй байх эрхийн үр нөлөөг хүртэгч байж болно.

Зарим тохиолдолд, хамгаалагчид хүний эрхийн зөрчил болон хүчирхийллийн хэргийн талаар зөвлөлдөхөөр цагдаад хандах (6-р хэсэгт илүү тодорхой өгүүлнэ) боломжтой. Хүний эрх хамгаалагчдад нууц хадгалах давуу эрх үндэсний хууль тогтоомжоор олгогдоогүй, шүүхээс энэ тухайд ямар нэгэн дүрэм журам гаргаагүй бол хамгаалагчид цагдаад хандах эсэхээ, эсвэл хэрхэн хандахаа анхааралтай бодолцож үзэх хэрэгтэй. Ялангуяа цагдаагийн хүссэн мэдээллийг өгөөгүйн улмаас мөрдөн байцаалтанд саад учруулсан хэмээн хамгаалагчдыг баривчлах зэргээр дарамт шахалт үзүүлэх эрх мэдэлтэй байгаа тохиолдолд үүнийг анхаарах нь ихээхэн чухал юм.

Хүний эрх хамгаалагчид тухайн мэдээллийг цагдаатай хуваалцах сонирхолтой байгаа эсэхээс үл хамааран, эрхийг нь хамгаалахаар ажиллаж байгаа хүмүүст хамаарах мэдээллийг өгөхийг шаардаж байгаа үед цагдаад мэдээлэхээсээ өмнө тэдгээр хүмүүст мэдэгдэж, зөвшөөрөл авах хэрэгтэй. Хүний эрхийн зөрчил, хүчирхийллийн хохирогчид тулгарсан асуудлаа хүний эрх хамгаалагчидтай хувиараа зөвлөлдөж болох тул зөвхөн тэдний зөвшөөрлийг авсан нөхцөлд л цагдаад мэдэгдэх нь зүйтэй.

Ихэнх тохиолдолд, зарчмын хувьд, хүний эрх хамгаалагчид үйл ажиллагаагаа хуулийн хүрээнд явуулах сонирхолтой байдаг ч улс төрийн нөхцөл байдал, хуулийн зохицуулалт ихээхэн хязгаарлагдмал байгаа нөхцөлд ийм боломж олдохгүй байж болно. Ийм хязгаарлалттай, энэ нь хүний эрхийн олон улсын эрх зүйг зөрчиж байсан ч хууль сахиулагчид үндэсний хууль тогтоомжоо хэрэглэх ёстой байдаг.

Ийм нөхцөлд ямар үйл ажиллагааг үндэсний хууль тогтоомжийн хүрээнд явуулахыг зөвшөөрдөг болон зөвшөөрдөггүйг хүний эрх хамгаалагчид нарийн сайн мэдэж байх хэрэгтэй. Маш хязгаарлагдмал эрх зүйн орчинтой улсад хуулийн хүрээнд бүтээлч байдлаар асуудалд хандахыг шаарддаг.

OH.MN  
СУДАЛГААНЫ САН

<sup>15</sup> Сьерра Леоны асуудал хариуцсан Тусгай шүүх, Прокурор, Алекс Тамба Брима & Оросын эсрэг хэрэг #. SCSL-2004-16-AR73, Эрхэм шүүгч Жеоффри Робертсоны тусгайлсан болон санал нийлсэн үзэл бодлууд, QC (2006 оны 5 сарын 26), 28-р догол мөр.

Жишээлбэл, ОХУ-д хүний эрх хамгаалагчид ганц ганцаараа самбар барин зогсож эсэргүүцлээ илэрхийлэх болсон нь албан ёсны зөвшөөрөл шаардагдахгүйгээс гадна олон тооны эсэргүүцэгчид бие биенээсээ тодорхой хэмжээний зайтай зогсон, олон хүн бөөгнөдөггүй учир цуглаан гэж үздэггүй.<sup>16</sup>

2014 онд ганц хүний эсэргүүцлийн жагсаалыг ОХУ-ын засгийн газрын холбогдох байгууллагаас зөвшөөрөл авахгүйгээр Эмнести Интернэшнл зохион байгуулахдаа хувцас өмсгөдөг манеканыг үхүүлэх хуудас бариулан ашигласан.<sup>17</sup>



Эмнести Интернэшнлийн “Ухаалаг бай”: - Оросын Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, хувцасны манекан ашигласан эсэргүүцлийн жагсаалыг харуулсан киноноос авсан зураг. 2015 он.

Оросын бусад хүний эрх идэвхитнүүд олон нийтийн газраар явахдаа үүргэвчидээ эсэргүүцлийн хуудас наах зэргээр «Чимээгүй эсэргүүцлийг» өдөр тутамдаа хийдэг.<sup>18</sup>

Хуулиар зөвшөөрөөгүй үйл ажиллагаа явуулахдаа хүний эрх хамгаалагчид өөрсдийн үйлдлийн болзошгүй үр дагаврыг сайтар үнэлэх хэрэгтэй. Үүнд оноох шийтгэлийн төрлүүдийг мэдэж байх нь илүүдэхгүй. Зарим тохиолдолд оногдуулсан торгууль нь бага, эрсдэлийг даваад гарах боломжтой, хамгаалагчдыг ажлаа үргэлжлүүлэхэд нөлөө үзүүлэхээргүй байж болно. Гэхдээ, бусад тохиолдолд хүний эрхийг хамгаалагчдыг хорих хэмжээний шийтгэл оноохоор, тэдний үйл ажиллагааг хязгаарлаад зогсохгүй, хувь хүний аюулгүй байдалд нөлөө үзүүлэх хэмжээнд ч (зарим улсад баривчлагдах нь эрүүдэн шүүлтэд өртөх, амь насаа алдах ч эрсдэлтэй байдаг) хүрч болно. Хууль бусаар жагсаал цуглаан зохион байгуулах нь зарим улсад хэдэн жил хүртэл хугацаагаар хорьж саатуулах шийтгэлтэй байдаг.<sup>19</sup> Хүний эрх хамгаалагчид хувь хүн хийгээд байгууллагын түвшинд шийдвэр гаргахдаа тухайн нөхцөл байдалд хуулийг ямар хэмжээнд зөрчиж байгаа, дагалдах эрсдэлийг хүлээхэд ямар хэмжээний бэлтгэлтэй байгаа вэ гэдгээ нухацтай бодож тунгаах хэрэгтэй.

<sup>16</sup> Ганцаараа эсэргүүцлээ илэрхийлэгчдийг “хууль бус жагсаал” зохион байгуулсан хэмээн баривчилж, шүүсэн хэрэг хэд хэдэн удаа гарсан юм. Английн Эмнести Интернэшнлээс гаргасан ОХУ: ганцаараа эсэргүүцлээ илэрхийлэгчид Болотная талбайд болсон жагсаалын үеэр саатуулагдав (2015 он). <https://www.amnesty.org.uk/press-releases/russia-one-person-picket-protesters-locked-after-bolotnaya-demo>

<sup>17</sup> “Ухаалаг бай” [https://www.youtube.com/watch?v=WODhMS\\_fTU](https://www.youtube.com/watch?v=WODhMS_fTU)

<sup>18</sup> Дойче Велле, Оросын идэвхтэнүүд бүтээлчээр сэтгэж байна. 2016 он, <http://www.dw.com/en/russian-opposition-activists-get-creative/a-19550498>

<sup>19</sup> Жишээлбэл, Орост зөвшөөрөлгүй жагсаал цуглаан зохион байгуулсан тохиолдолд торгох, мөн 15 хоног хүртэл баривчлан саатуулах шийтгэлтэй байдаг. 3 төрлийн зөрчил 5 хүртэл жилээр хорих шийтгэлтэй. Эмнести Интернэшнлийн энэхүү жишээг Оросын Шинээр гарсан дарангуй хуулиар шийтгүүлсэн тайван замаар тэмцэгчдийг суллах ёстой, 2015 он-оос дэлгэрүүлэн үз. <https://www.amnesty.org/en/latest/news/2015/12/Russia-Peaceful-activist-sentenced-under-repressive-new-law-must-be-released/>



Орон байртай байх эрхийн төлөө тэмцэгчид Пном Пений давж заалдах шатны шүүх рүү очих замдаа цонхоор хашгирч байгаа нь, Камбож, 2015 оны 1 сарын 26.

1990-ээд оны сүүлээр Сербийн Оптор! залуучуудын хөдөлгөөний дэмжигчид тухайн үеийн ерөнхийлөгч Слободан Милошевичийг эсэргүүцсэн үйл ажиллагааныхаа үеэр олон удаа цагдаад баривчлагдаж байжээ. Гишүүдээ тэмцэлдээ идэвхитэй оролцуулах, баривчилгааны сөрөг үр дагаврыг бууруулахын тулд Оптор! «В төлөвлөгөө» хэмээх тактикийг боловсруулсан нь эхний баривчилгаа явагдсаны дараа дараагийн эсэргүүцэгчдийг цагдаагийн газрын гадна талд бэлэн байлгах явдал байв. Үндсэн эсэргүүцлийн жагсаалд оролцогчид баривчлагдана гэсэн бодолтой, баривчлагдахад бэлтгэгдсэн байдаг байв. Өмнө нь баривчлагдаж байсан хүмүүсийн туршлагад үндэслэн цагдаагийн асуудаг асуултуудын жагсаалт болон боломжит хариултыг гаргах зэргээр цагдаагийн байцаалтанд бэлтгэдэг байжээ. Хоёрдахь эсэргүүцлийг мөн урьдчилан төлөвлөж, хичнээн тэмцэгчид үндсэн эсэргүүцлийн ажиллагаанд оролцохгүй ард нь үлдэх болон хуульчид, хэвлэл мэдээллийнхэн, сөрөг хүчнийхнийг уриалахад бэлэн байхаар төлөвлөдөг байв. Хуульчид нэмэлт баривчилгаа явагдахаас урьдчилан сэргийлэхийн тулд цагдаагийн газарт хамгийн түүрүүнд ирэх ёстой. Тэд мөн цагдаагийн газрын гадна талд бусад жагсагчид болсон явдлын талаар мэдээлэл хийж байх хооронд баривчлагдсан идэвхитнүүдийг суллах талаар цагдаа нартай ярилцах ёстой байв.<sup>20</sup>

### 3.3 Хандлагыг ойлгох нь

Цагдаа өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэх явцдаа тухайн нөхцөл байдлын түвшингээс хамааран баривчлах, эсхүл газар дээрх нь торгох, тэр ч бүү хэл тодорхой арга хэмжээ авахгүй ч байж болно. Дээрх тохиолдолд цагдаагийн байгууллагын баримтлах бодлого хийгээд тухайн гэмт үйлдэлд цагдаа нарын хандах ерөнхий хандлагыг мэдэж байх нь ихээхэн чухал. Цагдаагийн зүгээс зарим тохиолдолд ойлгож, хүлцэх боломжтой, тухайлбал, хүний эрх хамгаалагчид ямар нэгэн байдлаар дайсагнасан зан авир гаргаагүй буюу цагдаагийн зүгээс тэднийг “гэмт хэрэгтэн” гэж үзэхгүй байж болно.

<sup>20</sup> Хүний эрхийн шинэ тактик, В төлөвлөгөө: Дарангуйллыг бууруулахын тулд хоёрдогч эсэргүүцэгчдийг ашиглах нь, 2003 он, <https://www.newtactics.org/sites/default/les/resources/PlanB-EN.pdf>

Жишээлбэл, Угандад хий, газрын тосны салбартай холбоотой газрын эрхийн асуудлаар ажиллаж байсан иргэний нийгмийн байгууллагын гишүүдийг газрын тос олборлолтын бүсэд ажиллаж байхад нь Эрчим хүчний яамнаас зохих зөвшөөрөл аваагүй гэх үндэслэлээр цагдаа нар баривчилжээ. Баривчлах явцад тэд өөрсдийгөө хүний эрх хамгаалагчид гэдгийг байнга хэлж, Үндсэн хуулиар баталгаажсан улс орныхоо аль ч хэсэгт зорчих эрхтэй болохоо ярьж, тайлбарласны үр дүнд цагдаа нар хүний эрх хамгаалагчдыг баривчлахаа зогсоож, тэдэнд хүлээцтэй ханджээ.<sup>21</sup>

Дотоодын хууль тогтоомжийн дагуу зохих зөвшөөрөлгүйгээр жагсаал цуглаан зохион байгуулж байгаа (төлөвлөж байгаа) хүний эрх хамгаалагчдад цагдаагийн зүгээс ямар арга хэмжээ авч болохыг бодолцох нь зүйтэй. Олон улсын хүний эрхийн хэм хэмжээгээр бол эрх баригчдад мэдээлээгүй гэдэг нь жагсаалыг хууль бус гэж үзэх үндэслэл болохгүй бөгөөд цагдаагийн зүгээс тайван жагсаалыг ямар нэгэн үл ялих шалтгаанаар хууль бус гэж үзэн тараах ёсгүй.<sup>22</sup> Зарим улсад жагсаал цуглаан тайван явагдаж байгаа тохиолдолд үндэсний хууль тогтоомжоор зөвшөөрөгдөөгүй байсан ч цагдаагийн зүгээс зохих дэмжлэг үзүүлдэг.

Жишээлбэл, Армен улсын Цагдаагийн тухай хуульд зохих зөвшөөрөл аваагүй хэдий ч тайван журмаар зохион байгуулагдаж байгаа жагсаал цуглаанд цагдаа нар дэмжлэг үзүүлэх үүрэгтэй байхаар хуульчилжээ.<sup>23</sup> Шведэд цагдаа нар зөвшөөрөл аваагүй жагсаал цуглааныг мэдээлэхгүй байх нь түгээмэл бөгөөд тодорхой тохиолдолд, үүрэг авсан үедээ л мэдээлдэг.<sup>24</sup>

Гэвч улс төрийн болоод эрх зүйн дарангуйлсан дэглэмтэй орнуудад жагсаал цуглааныг зөвшөөрөлгүйгээр зохион байгуулсан бол цагдаа нар жагсаалыг тараах нь ихээхэн түгээмэл байдаг. Ийм нөхцөлд жагсаалыг тараахын тулд цагдаагийн зүгээс хүч хэрэглэхээс өөр аргагүйд хүрэх, ямар төрлийн хүч хэрэглэхийг хүний эрх хамгаалагчид бодолцох хэрэгтэй.



German riot police carry a protestor near Schanzenviertel ahead of the G20 summit in Hamburg (Germany), July 4, 2017. © REUTERS/Hannibal Hanschke

чөлөөтэй нэвтрэх боломжоор хангах хэрэгтэй болох ба хэд хэдэн сонголт байна. Үүнд, цагдаа цугларсан олныг хүч албадлага хэрэглэн тараах, эсэргүүцэгчдийг баривчлах, эсвэл ямар нэгэн үр дагавар бий болгохгүйгээр тэднийг зүгээр л хөөгөөд явуулчихаж болох юм. Хүний эрх хамгаалагчдын тайван байдал нь цагдаа нарыг илүү зөөлөн арга хэрэглэх магадлалыг нэмэгдүүлнэ.

Зарим тохиолдолд хамгаалагчид өөрсдийн дуу хоолойгоо сонсгохын тулд **иргэний үл захирагдахуй** буюу шударга бус шийдвэр, үйл ажиллагааны эсрэг тайван замаар тэмцэх тактикийг сонгоход хүрч мэднэ. Жишээлбэл, нутгийн уугуул иргэд үндэстэн дамнасан компаний эсрэг газрын эрхийн төлөөх тэмцлийн үед хүний эрх хамгаалагчид компаний эзэмшлийн газар нутаг руу нэвтрэх зам гарц зэргийг хаах шийдвэр гаргаж болох юм. Энэ нөхцөл байдал цаашид яаж үргэлжлэх нь хоёр талын хандлагаас шалтгаалах болно. Цагдаагийн байгууллага компаний зүгээс хүсэлт гаргавал компанийг

<sup>21</sup> Угандагийн Хүний эрхийн төв, Уганда дахь хүний эрх хамгаалагчид: Хүний эрхэд тулгарч болзошгүй зөрчлийг ойлгох ба даван туулах нь, 3-р цуврал, 2013 он, [http://www.hrcug.org/publications/ le/HRDs%20Report%202013.pdf](http://www.hrcug.org/publications/le/HRDs%20Report%202013.pdf)

<sup>22</sup> НҮБ-ын Ерөнхий Ассамблейн тайван замаар жагсаал цуглаан хийх, эвлэлдэн нэгдэх эрхийн асуудал хариуцсан Тусгай илтгэгч, хууль зөрчөөгүй жагсаал цуглааныг дур зоргоороо, хууль бусаар зогсоох асуудал хариуцсан Тусгай илтгэгч нарын хамтарсан тайлан, А/НРС/31/66 (4 February 2016)

<sup>23</sup> Жагсаал цуглаан хийх эрхийн тухай хууль, 2011 он, 31-р зүйл, 2-р догол мөр

<sup>24</sup> АХЭХБ-ын сонгогдсон гишүүн орнуудын Тайван замаар жагсаал цуглаан хийх эрхийн хэрэгжилтэнд хийсэн үнэлгээ, 2015 оны 4 сараас 2016 оны 7 сар, 7-р хуудас, <https://www.osce.org/odihr/28972?download=true>



Гэсэн хэдий ч дэлхийн олон оронд эсэргүүцэгчдийн үйл ажиллагаанаас үл хамааран цагдаа нар ихээхэн дарангуйлсан хандлагатай, жагсаал цуглааны үеэр хүч хэрэглэхэд бэлэн байдаг гэдгийг мэдэж байвал зохино. Иймд тогтоосон хууль дүрмийг зөрчих эсэх, хэрвээ зөрчихөөр бол ямар хэмжээнд зөрчих эсэхийг шийдэхээсээ өмнө нөхцөл байдлын талаар бүрэн ойлголттой байх нь маш чухал юм.

### 3.4 Хэрхэн харилцах вэ?

Гарын авлагын 3.2 дахь хэсэгт дурдсанчлан хүний эрх хамгаалагчид янз бүрийн нөхцөл байдалд цагдаа нартай чиг үүргийнх нь хүрээнд харилцах боломжтой. Хэрвээ хүний эрх хамгаалагчид эрхээ мэдэж байгаа бол цагдаа нартай үр дүнтэй харилцаж чадах бөгөөд, хууль зүйн үндэслэл бүхий гомдол гаргах боломжтой юм.

«Цагдаа нар ТББ-ын байранд нэгжлэг хийж байна: Та юу хийх хэрэгтэй болохоо мэдэх үү?» хэмээх «Дөрөв дэх бүлэг» төрийн бус байгууллагаас гаргасан гарын авлага нь Угандагийн иргэний нийгмийн байгууллагын ажилтнуудад цагдаагийн нэгжлэг болон хөрөнгө битүүмжлэх үед ямар үйлдэл хийх талаар зааварчилгаа болдог. Зааварчилгаанд цагдаагийн ажилтны бичиг баримтыг хэрхэн шалгах, нэгжлэг хийх зөвшөөрлийг шаардах, зөвшөөрөлд юуг шалгахар заасан (зөрчлийн сэжиг таамаг, яг юуг эрж хайж байгаа гэх мэт), нэгжлэгийн үеэр хуульч байлцуулахыг шаардах, цагдаагийн асуултанд хэрхэн хариулах болон битүүмжилсэн эд зүйлсийн нарийвчилсан жагсаалт бүхий гарын үсэг зурсан нэгжлэгийн хуудсыг хүлээн авах эрхтэй гэх мэт зөвлөгөөг өгсөн байдаг.<sup>25</sup>

Хэрвээ хүний эрхийг хамгаалагчид цагдаа нар тэдний болон бусдын эрхийг зөрчсөн гэж үзвэл уг зөрчлийг буруушаах, мөн **олон нийтэд хандан мэдэгдэл** хийх, эсвэл цагдаагийн шууд харьяалах байгууллагаболон зохих хяналт тавих байгууллагад гомдол гаргаж болно. Цагдаагийн байгууллагын гаргасан хүний эрхийн аливаа зөрчлийн эсрэг хариу арга хэмжээ авах нь хариуцлагатай байдлыг бий болгоход чухал нөлөөтэй учир хүний эрх хамгаалагчид бүхий л нөхцөл байдлыг юуны өмнө анхааралтай нягтлан үзэж, өөрсдийнхөө гаргасан мэдэгдэл нь баримттай, хууль зүйн хувьд үндэслэл бүхий гэдгийг шалгах ёстой. Энэ нь хамгаалагчдад итгэх итгэлийг нэмэгдүүлээд зогсохгүй тэдний гомдол, нэхэмжлэл болон зөвлөмжийг хүлээн авах магадлалыг нэмэгдүүлэх юм.

Хүний эрх хамгаалагчид эсэргүүцэхээсээ өмнө энэ нь хүний эрхийн олон улсын эрх зүй болоод дотоодын холбогдох хууль тогтоомжийн дагуу үнэхээр хүний эрхийн зөрчил мөн эсэхийг эхлээд үнэлэх хэрэгтэй. Болсон явдлыг хэт дэвэргэх, эсвэл цагдаа хуулийн дагуу хэдий ч зохисгүй үйлдэл гаргасан гэж буруутгах нь хүмүүсийг төөрөгдүүлээд зогсохгүй хүний эрх хамгаалагчдад итгэх итгэл, хүлээн зөвшөөрөгдсөн чадварт сөрөг нөлөө үзүүлж болзошгүй. Жишээлбэл, АНУ-д цагдаа болон жагсагчдын хооронд болсон ширүүн мөргөлдөөний дараа зарим хүний эрхийн идэвхитнүүд нийгмийн сүлжээгээр дамжуулан цагдааг “дайны үед ч хориглодог нулимс асгаруулагч хий хэрэглэсэн” хэмээн буруутгасан байдаг. Энэ нь хууль зүйн хувьд алдаатай мэдэгдэл бөгөөд хууль сахиулахтай холбоотой эрх зүйн хүрээ, зэвсэгт мөргөлдөөний үед гардаг дайсагнал хоёрын хоорондох маш том ялгааг буруугаар ойлгосон хэрэг юм. Энэ мэт мэдэгдлүүд нь хүний эрх хамгаалагчдын үйл ажиллагааны хүлээн зөвшөөрөгдөх байдалд сөргөөр нөлөөлж, тэдний илрүүлсэн зөрчил, гаргасан зөвлөмж, тухайн мэдэгдлийн хууль ёсны бөгөөд баримттай байх зэрэг шинжийг үгүйсгэхэд хүргэнэ. Үнэн хэрэгтээ хууль сахиулахын тулд нулимс асгаруулагч хий хэрэглэхийг хүний эрхийн олон улсын эрх зүйн хэм хэмжээний дагуу хууль бус гэж үздэггүй.

Гэхдээ дээрх үйлдэл нь хүч хэрэглэсэн болон тайван замаар эсэргүүцлээ илэрхийлсэн эсэхээс үл хамааран аль алинд нь сөрөг нөлөө үзүүлэх бөгөөд хүчирхийлэл газар авч, хүч хэрэглэж байгаа хүмүүсийг өөр бусад аргаар зогсоох боломжгүй болсон үед л цагдаа энэхүү зэвсгийг хэрэглэх ёстой. Үүнийг цугларсан олныг тараах зорилгоор л хэрэглэх ёстой бөгөөд эсэргүүцэгчид зугтах, холдох боломжгүй үед хэрэглэх ёсгүй. Ямар ч нөхцөлд нулимс асгаруулагчаар хүнийг

<sup>25</sup> <http://chapterfouruganda.com/sites/default/files/downloads/KNOW-YOUR-RIGHTS%3AGUIDELINES-ON-POLICE-SEARCHES-OF-NGO-OFFICES.pdf>.

шууд буудаж болохгүй.<sup>26</sup> Хэрэв эдгээр журмыг цагдаа нар баримтлаагүй тохиолдолд хүний эрх хамгаалагчид цагдаагийн хөндлөнгийн оролцоог зохих байдлаар шүүмжилж байр сууриа илэрхийлэх боломжтой. Маш олон тохиолдолд хүний эрх хамгаалагчид өөрийн үзсэн харсан, ажигласан зүйлсээ олон нийттэй хуваалцахаар өөрийн эрхгүй сэтгэл хөдлөлдөө автах нь элбэг тохиолддог. Олон нийтийг хамарсан жагсаал цуглааныг ажиглаж байгаа хүний эрх хамгаалагчид ийм байдалд орох нь амархан.



Арьс өнгөөр алагчлах үзлийг дэмжигчдийн зохион байгуулсан цуглааныг нийгмийн сүлжээгээр тараасан мэдээлэл гарсны дараа болсон цуглааны үеэр жагсаалыг эсэргүүцэгч цагдаа нартай ярилцаж байгаа нь, Хойд Каролина Дурам хот, АНУ, 2017 оны 8 сарын 18, © REUTERS/Jason Miczek

Цагдаа нар хүч албадлага хэрэглэхээр завдах эсвэл тухайн нөхцөлд хууль бус үйл ажиллагаа явуулах гэж байна гэж тэд үзэж болох юм. Иймэрхүү нөхцөлд гэрэл зураг, дүрс бичлэгийг нийгмийн сүлжээгээр цаг алдалгүй тараах нь ихээхэн төөрөгдлийг үүсгэнэ. Ялангуяа олныг хамарсан үйл ажиллагаа нь тодорхой цаг хугацаанд, тодорхой газар болдог тул тухайн нөхцөл байдал, үйл явдал хэрхэн өрнөж байгаа талаар зөвхөн ерөнхий байдлаар ажиглах боломж олдог. Иймд нийгмийн сүлжээгээр тарсан мэдээлэл тухайн жагсаал цуглааны цаад учир шалтгаан болоод чухам юу болсон талаарх үнэн зөв мэдээллийг өгч чадахгүй байх эрсдэлтэй тул хүний эрх хамгаалагчдыг цагдаатай үр дүнтэй, бүтээлч хамтын ажиллагаа өрнүүлэх, тэдний гаргасан шүүмжлэл болон мэдэгдлийг нь цагдаагийн зүгээс нухацтай авч үзэхэд саад учруулах магадлалтай.

MN  
СУДАЛГААНЫ САН

<sup>26</sup> Нидерландын Эмнести Интернэшнл (), Хууль сахиулах байгууллагын ажилтнуудын галт зэвсэг, хүч хэрэглэхдээ баримтлах НҮБ-ын үндсэн зарчим, 2015, 157-р хуудас, <https://www.amnesty.nl/actueel/use-of-force-guidelines-for-implementation-of-the-un-basic-principles-on-the-use-of-force-and-rearms-by-law-enforcement-officials>



Цагдаа нар Венесуэлийн Каракас хот дахь Омбудсмэний байрны гадна жагссан оюутнуудыг тараахаар нулимс асгаруулагчаар буудаж байгаа нь, 2014 он, © Carlos Becerra

Европын Аюулгүй байдал, Хамтын ажиллагаа хариуцсан Байгууллага, Ардчилсан Засаглал, Хүний эрхийг хангах Байгууллага (АЗХЭХБ)-аас Жагсаал цуглаан хийх эрхийн хэрэгжилтэнд Хяналт тавих чухал ач холбогдолтой гарын авлагыг боловсруулжээ.<sup>27</sup> Энэ нь зарим талаар АЗХЭХБ-ын өөрийн гишүүн орнуудад хэрэгжүүлдэг тусгайлан хяналтын үйл ажиллагаанд зориулагдсан байх боломжтой. Гэхдээ энэ зааварчилгаа олон талаараа жагсаал цуглаанд хяналт тавьж байгаа хүний эрх хамгаалагчдад хамааралтай юм. Үүний дотроос, «Хөндлөнгийн хянагчид жагсаал цуглааны үеэр албан ёсны үзэл бодлоо хэвлэл мэдээллийнхэн болон бусад байгууллагад ямар нэг байдлаар илэрхийлэхгүй байхыг зөвлөж байна. Хүний эрхийн хараат бус хяналтыг ямар ч тайлбар хязгаарлах ёсгүй юм».

Хүний эрхийг хамгаалагчид цагдаагийн үйл ажиллагаа (буруутай ажиллагаа)-г үнэлж дүгнэхдээ зөвхөн олон улсын хэм хэмжээ төдийгүй дотоодын хууль тогтоомжид нийцсэн эсэхийг шалган үзэх хэрэгтэй. Зарим тохиолдолд цагдаагийн үйл ажиллагаа дотоодын хууль тогтоомж болон олон улсын хүний эрхийн хэм хэмжээг аль алиныг нь зөрчсөн байх боломжтой. Энэ талаар 4-р хэсэгт дэлгэрүүлж үзэх болно.

Цагдаагийн үйл ажиллагааг үндэсний хууль тогтоомжийн дагуу зөвтгөх боломжтой байсан ч тухайн хууль нь олон улсын хүний эрхийн хэм хэмжээнд нийцээгүй хууль болохыг хүний эрх хамгаалагчид илрүүлж болно. Ийм нөхцөлд цагдаагийн зүгээс хуулийн ямар заалтыг үндэслэн ямар сонголт хийж байгааг нь анхааралтай ажиглах хэрэгтэй. Хэрвээ цагдаа нарт өөр ямар нэгэн сонголтгүйгээр, тодорхой арга хэмжээ авахыг хуулиар үүрэг болгосон байвал цагдаа руу чиглэсэн шүүмжлэл, зөвлөмж илүүц байж мэднэ. Энэ нөхцөлд дотоодын хууль тогтоомжид байгаа олон улсын хүний эрхийн хэм хэмжээний зөрчлийг ил болгон гаргаж тавих, хэлэлцүүлэг өрнүүлэх, мөн холбогдох хууль тогтоох байгууллагад хандах зэргээр ажиллавал хүний эрх хамгаалагчдын мэдэгдэл илүү үр дүнд хүрэх магадлалтай.

<sup>27</sup> АЗХЭХБ, Жагсаал цуглаан хийх эрхийн хэрэгжилтэнд хяналт тавих тухай гарын авлага (2011 он), 34-р хуудас, <https://www.osce.org/odihr/82979?download=true>.

Гэхдээ хуулиар цагдаа нарт тодорхой төрлийн сонголт хийхийг зөвшөөрсөн байвал тухайн нөхцөл байдлыг харгалзан үзэж бүтээлч байдлаар цагдаа нартай шүүмжлэл өрнүүлэх, яриа хэлэлцээр хийх нь цагдаа нарын зан төлөвийг өөрчлөхийг хүсч байгаа хамгаалагчдад илүүтэй хамааралтай.

Хуулинд заасан “хууль сахиулагчид ... болно” гэдэг тодорхойлолт нь “хууль сахиулагчид ... ёстой” гэдэг тодорхойлолтоос илүү олон хэрэглэгддэг. Энэхүү “болно” гэдэг утга нь хуулиар олгосон боломжуудаас хэрхэн сонголт хийж байгаа талаар цагдаа нартай ярилцах, хүний эрхийн хандлагаар шийдвэр гаргах үйл явцыг цагдаа нарт санал болгох боломжийг олгож байгаа юм. Жишээ нь, дотоодын хууль тогтоомжийн дагуу хууль бус гэж үзсэн жагсаал цуглааны хувьд хуулиар тараах ёстой гэж заасан байсан ч заавал тийнхүү тараах шаардлагагүй. Цагдаа хууль, дэг журам сахиулах үндсэн үүрэгтэй тул хүний эрх хамгаалагчид, хуулиар зөвшөөрөөгүй боловч тайван цуглааныг тараах нь дэг журам сахиулах бус сөрөг үр дагавартай болохыг цагдаа нарт тайлбарлан ойлгуулж болно. Цагдаагийн зүгээс дэг журам сахиулах бус эмх замбараагүй байдал үүсгэж мэдэх тул тайван цуглааныг тараахаас татгалзах хэрэгтэй. Энэ бол орчин цагт хүлээн зөвшөөрөгдсөн хэм хэмжээ бөгөөд жагсаал цуглааныг зохицуулах сайн туршлагад тооцогддог юм.<sup>28</sup>



Израйлийн цэргүүд Палестиний баруун эргийн Офра тосгоны иргэдийг албадан нүүлгэх ажиллагааны үеэр оршин суух эрхийн төлөө тэмцэгчид байшингийн дээвэр дээр гарч эсэргүүцлээ илэрхийлж байгаа нь, 2017 оны 2 сарын 28, © REUTERS/Ronen Zvulun

Цагдаа тодорхой арга хэмжээ авахыг хуулиар үүрэг болгосон байсан ч үүргээ хэрхэн гүйцэтгэх талаар зөвлөлдөх бага боловч орон зай байж л таарна. Тухайлбал, зөвшөөрөлгүй суурьшсан иргэдийг нүүлгэн шилжүүлэх шүүхийн шийдвэрийг ихэвчлэн цагдаа гүйцэтгэх үүрэгтэй болдог. Нүүлгэн шилжүүлэлтийн талаар цагдаатай зөвшилцөх боломж тун бага, эсвэл огт байхгүй. Гэхдээ цагдаагийн зүгээс энэхүү шийдвэрийг биелүүлэхдээ дараах асуудлуудыг анхаарч үзсэн байх ёстой. Үүнд:

- Тухайн шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр эсэхийг цагдаагийн зүгээс зохих ёсоор нягтлан үзэх,
- Шийдвэр гүйцэтгэхээс өмнө тухайн шийдвэрт давж заалдах гомдол гаргах хугацаа өнгөрөхийг хүлээх,
- Дотоодын хууль тогтоомжид заасны дагуу нүүлгэн шилжүүлэлт хийхээс өмнө оршин суугчдад энэ талаарх мэдэгдлийг хангалттай хэмжээнд өгөх,
- Цагдаа нүүлгэн шилжүүлэлт хийх тохиромжтой цагийг сонгох ёстой, жишээ нь шөнийн цагаар, эсвэл хүмүүсийг эрсдэлд оруулж мэдэх цаг агаарын нөхцөлд нүүлгэн шилжүүлэлтийг явуулахгүй,
- Цагдаагийн зүгээс хүч хэтрүүлсэн хэрэглэх эсвэл хууль бус аргаар хүч хэрэглэх болон эд хөрөнгөнд хохирол учруулж болохгүй.

<sup>28</sup> АЗХЭХБ, Жагсаал цуглаан зохицуулах үед хүний эрхийг хангах нь гарын авлага (2016 он), 31-р хуудас.



Цагдаагийн үйл ажиллагаанд нөлөөлөхийг хүсч буй хүний эрх хамгаалагчид ямар ч нөхцөлд, тухайн тохиолдолд хэрхэн ажиллах талаарх стратегиа боловсруулах хэрэгтэй. Цагдаагийн байгууллага дотор хэнтэй харилцаа тогтоох, энэ нь тэдний хийхийг хүсч буй өөрчлөлтөнд нөлөөлөх эерэг, сөрөг нөлөөллийн талаар 6-р хэсэгт дэлгэрэнгүй авч үзнэ.

### 3.5 Дүгнэлт ба зөвлөмж

---

Хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа нь цагдаагийн үйл ажиллагаатай шууд холбоогүй байсан ч хүний эрх хамгаалагчид чиг цагдаатай чиг үүрэгтэй нь холбогдуулан харилцах шаардлагатай болдог. Хүний эрхийг хамгаалах үйл хэргээ явуулж байхдаа цагдаагийн хэтийдсэн оролцооноос зайлсхийхийн тулд, ядаж л цагдаагийн үйл ажиллагаанаас үүдэн бий болох сөрөг үр дагаварыг бууруулахын тулд хамгаалагчид олон хүчин зүйлсийг бодолцож үзэх шаардлагатай.

- Хүний эрх хамгаалагчид хуулийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулахыг эрмэлздэг. Энэ нь явуулж буй үйл ажиллагаатайгаа холбоотой дотоодын хууль тогтоомжийн талаар ойлголттой байхыг шаардана. Гэхдээ, тухайлбал, эрх зүйн болоод улс төрийн дарангуй уур амьсгалтай, дотоодын хууль тогтоомж нь олон улсын хүний эрхийн хэм хэмжээг зөрчсөн улсад үйл ажиллагаа явуулж буй хамгаалагчдад тухайн хуулийг сахин мөрдөхөд хүндрэл тулгардаг. Ийм нөхцөлд хүний эрх хамгаалагчид хийх гэж байгаа (хууль бус) үйл ажиллагааныхаа болзошгүй үр дагавар болон ямар эрсдэл үүрэх гэж байгаагаа анхааралтай авч үзэх хэрэгтэй.
- Хүний эрх хамгаалагчид хуулиас гадуур үйл ажиллагаа явуулахаар шийдсэн тохиолдолд тухайн асуудалд цагдаа нар ямар хандлагатай байдаг талаар мэдэх нь ихээхэн чухал. Ингэснээр цагдаа бүрэн эрхээ тэдний тусын тулд, мөн тэдний эсрэг хэрхэн хэрэгжүүлж байгааг үнэлэх боломжийг олгоно.
- Цагдаатай үр дүнтэй харилцахын тулд хамгаалагчид болох гэж байгаа нөхцөл байдалд хэрэглэх боломжтой дотоодын хууль тогтоомжийн талаар судлаж, тодорхой ойлголттой байх хэрэгтэй. Энэ нь цагдаатай тулгарсан үед эрхээ эдлэхийг шаардахаас гадна олон нийтэд хандсан мэдээлэл нь хууль зүйн хувьд алдаагүй, үндэслэл бүхий байх боломжийг олгоно. Цаашлаад, цагдаагийн бүрэн эрхийг хүний эрхэд нийцүүлэн хэрхэн хэрэгжүүлэх талаар шууд харилцан яриа өрнүүлэх ямар орон зайг олгоно.



## Цагдаа хүний эрхийг зөрчигч болох нь

### 4.1 Удиртгал

Хүний эрх хамгаалагчид хэрэгжүүлсэн үйл хэргийнхээ төлөө аюул заналхийлэлтэй байнга тулгарч, хүний эрхийн зөрчлийн золиос болох эрсдэлтэй. Цагдаа ийм нөхцөлд хүний эрх хамгаалагчдыг хамгаалах үүрэгтэй боловч өөрсдөө хүний эрх хамгаалагчдад эрсдэл учруулж, тэдний эрхийг зөрчигч болох нь олонтаа.

Тухайн улс орны нөхцөл байдлаас шалтгаалан цагдаагаас үүдэлтэй аюул занал, хүний эрхийн зөрчил нь харилцан адилгүй. Цагдаагийн зүгээс хүний эрх хамгаалагчдад учруулж болох хүний эрхийн зөрчилд дур зоргоороо баривчлах, цагдан хянах, гутаан доромжлох, дарамтлах, эрүүдэх болон бусад хэлбэрийн зүй бус харьцах, хууль бусаар шийтгэл оногдуулах явдал орно. Ийм нөхцөлд цагдаад зөрчлийн талаар мэдээлэх, хамгаалалт хүсэх нь хүний эрх хамгаалагчдыг улам бүр аюултай байдалд оруулж, цаашдын дарамт хүчирхийлэл, хариу авах эрсдэлийг бий болгоод зогсохгүй, хамгаалагчдын болон тэдний үйл хэргийн эсрэг цагдаагийн мөрдөн шалгах ажиллагааны бай болгох эрсдэлтэй.

Иймээс хүний эрх хамгаалагчид цагдаагийн тэдэнд учруулж болзошгүй эрсдэлийн талаар ойлголттой байж, тэрхүү эрсдэлийг бууруулах, хамгаалах төлөвлөгөө боловсруулах нь чухал. Энэ хэсэгт бид дээрх асуудлын тухайд анхаарвал зохих зүйлсийн талаар тоймлон авч үзэх болно. Өмнө нь өгүүлсэнчлэн, энэхүү гарын авлага хүний эрх хамгаалагчдад зориулсан аюулгүй ажиллагааны зөвлөмж биш билээ.



Венесуэлийн Каракас хотод болсон Ерөнхийлөгч Николас Мадурогийн засаг захиргааг эсэргүүцсэн жагсаалын үеэр жагсагчид руу аюулаас хамгаалах хүчнийхэн (баруун гар талд) буутай ижил зүйл чиглүүлсэн байгаа нь, 2017 оны 6 сарын 17, © REUTERS/Christian Veron

### 4.2 Эрх зүйн орчныг танин мэдэх нь

Цагдаагийн зүй бус үйл ажиллагаа нь хүний эрхийн хамгаалагчдад аюул учруулж, тэдний эрхийг зөрчихөд хүргэдэг. Цагдаа хүний эрхийг хамгаалагчдын эрхийг зөрчсөн эсэхийг үнэлэхийн тулд тэд цагдаагийн үйл ажиллагааг зохицуулсан дотоодын хууль тогтоомж болон олон улсын хэм хэмжээний талаар ойлголттой байх хэрэгтэй.

Хамгаалагчдыг хүчирхийлэх, хулгайлах, амь насыг нь хөнөөх зэрэг нь хүний эрхийн зөрчил гэдэг нь маш тодорхой тул үүнийг хүний эрхийн зөрчил гэдгийг ойлгохын тулд хуулийг нарийвчлан мэдэх шаардлагагүй. Харин хүний эрхийг зөрчсөн эсэх нь тийм ч тодорхой бус, түүнчлэн цагдаа нар хүний эрхийг шууд илэрхий байдлаар зөрчөөгүй байсан ч хүний эрхийг хамгаалагчид хүний эрхийн зөрчил хэмээн үзэх тохиолдол гарч болно. Тухайлбал, жагсаал цуглааны үеэр цагдаа нар хүний эрх хамгаалагчдын эсрэг хүч хэрэглэсэн гэж үзвэл, эхлээд хүч хэрэглэхэд хүргэсэн

нөхцөл байдлыг авч үзэх, мөн хүч хэтрүүлэн хэрэглэсэн, эсхүл шаардлагагүй үед хүч хэрэглэсэн зэрэг асуудлыг дүгнэхээсээ өмнө ямар арга хэрэгсэл ашигласныг нь үнэлэх хэрэгтэй. Үүний тулд хүч хэрэглэх асуудлыг дотоодын хууль, бодлого болон олон улсын хэм хэмжээнд хэрхэн авч үздэг талаар, мөн энэ тухайд цагдаа ямар бүрэн эрхтэй, хуулиар ямар эрх хэмжээ олгогдсон талаар ойлголттой байх шаардлагатай.<sup>29</sup> Баривчилсан тохиолдолд ч үүнд нэгэн адил хамаарна Дур зоргоороо баривчилсан гэж дүгнэхийн тулд дур зоргоор баривчилна гэдэг нь чухам ямар утгатай, ямар хуульд заасан байдаг, баривчилгааг хуулийн дагуу явуулахын тулд цагдаа ямар дүрэм журам баримтлахыг хуулиар зөвшөөрдөг талаар ойлголттой байх шаардлагатай.



Цагдаа нар эсэргүүцэгчийг саатуулж байгаа нь, Бразилын Сан Паоло хот, 2013 оны 6 сарын 18. © Mndia Ninja

**«Кени улсад Цагдаагийн үйлдсэн хүний эрхийн зөрчлийг баримтжуулах тухай удирдамж» нь иргэдээс хүний эрх хамгаалагчдад хандан гаргасан цагдаагийн хууль бус үйл ажиллагаатай холбоотой гомдлыг хүлээн авах, үнэлэхэд удирдлага болговол зохих чухал баримт бичиг юм. Энэхүү удирдамж нь хэдийгээр хүний эрх хамгаалагчдын эсрэг зөрчлийг баримтжуулахад тусгайлан зориулагдаагүй хэдий ч цагдаагийн үйлдсэн (үчирч болох) хүний эрхийн зөрчилтэй холбоотой бүх төрлийн харилцаанд хэрэглэх боломжтой Үүнээс гадна, хүний зөрчлийг хэрхэн ямар аргаар баримтжуулах, холбогдох мэдээллийг хэрхэн цуглуулахыг тайлбарлахаас гадна ямар эрх зөрчигдсөн болохыг тодорхойлоход тус болох олон улсын болоод үндэсний хүний эрхийн хууль тогтоомжуудыг задлан шинжлэх асуудлыг мөн тусгажээ. Учир нь цагдаа хууль зөрчсөн эсэхийг үнэлэхийн тулд хүний бүхий л эрхийг агуулгыг зөв ойлгож, тайлбарлах шаардлагатай.<sup>30</sup>**

Хүний эрх хамгаалагчдыг цагдаагийн хөндлөнгийн оролцооноос хэрхэн хамгаалсан талаарх дотоодын хууль тогтоомжийн зохицуулалт, түүний хамгаалалтын түвшинг танин мэдэх нь ихээхэн чухал. Жишээлбэл, Зааны Ясан Эрэг, Мали зэрэг улсуудад хүний эрх хамгаалагчид өөрсдийн үйл хэргээсээ болон илэрхийлсэн үзэл бодлоосоо болж яллагдах, мөрдөгдөх, баривчлагдан саатуулагдах ёсгүй гэдэг тусгайлсан заалтыг холбогдох хуулинд оруулж өгсөн байдаг.<sup>31</sup>

<sup>29</sup> Нидерландын Эмнести Интернэшнл (), Хууль сахиулах байгууллагын ажилтнуудын хүч ба галт зэвсэг хэрэглэхдээ баримтлах НҮБ-ын үндсэн зарчим (2015)-ыг хэрэгжүүлэх Удирдамжийг боловсруулжээ. Энэ нь хүний эрх хамгаалагчдад цагдаагийн зан авир хүний эрхийн олон улсын эрх зүй болон хэм хэмжээтэй тохирч байгаа эсэхийг хянахад тус болж чадна.

<sup>30</sup> Мусила, Годфрэй, Гитари, Кристофер болон Варнэй Кени улсад Цагдаагийн үйлдсэн хүний эрхийн зөрчлийг баримтжуулах тухай удирдамж (2016), [https://papers.ssrn.com/sol3/papers.cfm?abstract\\_id=2956514](https://papers.ssrn.com/sol3/papers.cfm?abstract_id=2956514)

<sup>31</sup> Cote d'Ivoire Loi N° 2014- 388 du 20 Juin 2014 portant promotion et protection des défenseurs des droits de l'Homme (Art. 5) and Decret N° 2017-121 du 22 Fevrier 2017 portant modalites d'application de la Loi N° 2014- 388 du 20 Juin 2014 portant promotion et protection des défenseurs des droits de l'Homme (Art. 12); Mali Loi No 2018-005 du 12 Jan 2018 relative aux defenseurs des droits de l'homme, Art. 5.

Цагдаа нарын үйлдсэн хүний эрхийг зөрчилд гомдол гаргах боломжуудын талаар хүний эрх хамгаалагчид зөв ойлголттой байх хэрэгтэй. Олон оронд цагдаагийн эсрэг гаргасан гомдлыг шалгадаг хөндлөнгийн хяналтын механизм байдаг. Хүний эрхийн зөрчлийн төрөл болон тухайн хяналтын механизмын хамаарах асуудлын хүрээ зэргээс хамааран хүний эрхийг хамгаалагчид зөрчлийг шалган шийдвэрлүүлэхээр зохих механизмд хандан гомдол гаргах боломжтой. Ийнхүү гомдол гаргахаас өмнө хамгаалагчид дараах асуудлыг анхаарах шаардлагатай. Жишээ нь, зарим механизм гомдлыг шалгахдаа цагдаагийн байгууллага дахь нэгжийг ашигладаг. Энэ нь мөрдөн байцаалтыг үр дүнгүй болгохоос гадна хамгаалагчдаас хариу авах эрсдэлийг нэмэгдүүлдэг тул уг асуудлыг нухацтай анхаарах хэрэгтэй. Иймд хамгаалагчид тухайн механизмын гомдол гаргагч болон гэрчүүдэд ямар хамгаалалт санал болгож байгааг мөн анхаарвал зохино.<sup>32</sup>

Үндэсний хэмжээнд гомдол нь үр дүн багатайгаас гадна хэтэрхий аюултай гэж үзвэл хүний эрх хамгаалагчид гомдолоо бүс нутгийн болон олон улсын байгууллагад гаргаж болох юм. Америк дундын Хүний эрхийн комиссийн Хүний эрх хамгаалагчдын нөхцөл байдлын талаарх Тусгай илтгэгч, НҮБ-ын Хүний эрх хамгаалагчдын Нөхцөл байдлын асуудал эрхэлсэн Тусгай илтгэгч зэрэг хувь хүний гомдлыг хүлээн авдаг механизмууд<sup>33</sup> эрсдэлийн эсрэг хариу арга хэмжээ авах зарим төрлийн хамгаалалтыг санал болгох боломжтой.

### 4.3 Хандлагыг ойлгох нь

Үйл ажиллагаа явуулж байгаа талбар болон гишүүнчлэлийн бүлгээсээ хамааран зарим хамгаалагчид цагдаагийн довтолгоо, аюул заналхийллын хохирогч болох өндөр эрсдэлтэй байдаг. Энэхүү эрсдэлийг үүсгэж байгаа нөхцөл нь улс орон бүрт харилцан адилгүй хэдий ч ерөнхийдөө эмэгтэй хамгаалагчид, ЛГБТИ иргэдийн болон цөөнх, дүрвэгсдийн эрх, газар, байгаль орчны эрх, засаглалын асуудлаар хүний эрх хамгаалах нь ихэнхдээ эрсдэлтэйд тооцогддог.<sup>34</sup>

Цагдаагийн хандлага ихэвчлэн ард иргэдийн хандлагыг харуулж байдаг. Гэхдээ энэ нь цагдаа олон нийтийн дэмждэггүй асуудлаар ажилладаг хамгаалагчдад шууд аюул занал учруулдаг гэсэн үг биш юм. Үүнээс гадна мэргэжлийн ур чадвар, цагдаагийн байгууллагын доторх авлигын түвшин зэрэг бусад хүчин зүйлс цагдаагийн зүгээс хүний эрх хамгаалагчидтай хэрхэн харилцахад ихээхэн нөлөөлдөг.

Цагдаагийн хандлага болон тэдний учруулж болох эрсдэлийг үнэлэхдээ хүний эрх хамгаалагчид өмнө нь ижил салбарт ажиллаж, цагдаатай харилцаж байсан хамгаалагчдын туршлагаас суралцах нь хэрэг болж мэднэ. Өөрөөр хэлбэл, хүний эрхийн хамгаалагчид, төрийн бус байгууллагуудын сүлжээ, хоорондын нягт хамтын ажиллагаа нь ихээхэн чухал юм.

Хүний эрх хамгаалагчдын эрхийг зөрчсөн цагдаагийн ерөнхий үйлдлээс цагдаагийн хүчний ямар хэлтсийн, ямар тодорхой албан тушаалтан зөрчсөн болохыг ялгаж салгах нь мөн чухал юм. Цаашилбал, тэрхүү зөрчил нь цагдаагийн албан хаагчдын хүний эрхийн хамгаалагчдын талаарх мэдлэг ойлголт дутмаг байснаас үүдэлтэй юу эсвэл тэдний үйл ажиллагааны зорилго, мөн чанарыг буруу ойлгосонтой холбоотой юу гэдгийг үнэлэх хэрэгтэй. Хэрвээ ийм тохиолдол гарвал, цагдаагийн байгууллагатай яриа хэлэлцээр өрнүүлэх, хүний эрхийг хамгаалах үйл хэргийн зорилгыг тайлбарлах, цагдаагийн удирдлагыг энэ сэдвээр албан хаагчдынхаа мэдлэг боловсролыг сайжруулах сургалт явуулахаар шахах зэргээр ажиллах хэрэгтэй.

<sup>32</sup> Хянан шийдвэрлэх механизмын давуу болон дутагдалтай талуудыг хэрхэн тодорхойлох талаар Нидерландын Эмнести Интернэшнлийн ( ) гаргасан удирдамжийг үз. Цагдаа ба хүний эрх хөтөлбөр, Цагдаагийн хяналт (2015), [https://www.amnesty.nl/content/uploads/2017/01/ainl\\_police\\_oversight.pdf?x79902](https://www.amnesty.nl/content/uploads/2017/01/ainl_police_oversight.pdf?x79902), энэ механизмыг ашиглах нь зүйтэй юу, үгүй юу гэдгийг тодорхойлоход хамгаалагчдад тустай байж мэднэ.

<sup>33</sup> Нөхөн үржихүйн эрхийн төв болон үндсэн хуулийн эрхийн төв, Хүний эрхийг хамгаалах эрх маань зөрчигдвөл би яах вэ? (огноогүй), [http://www.defendingrights.org/hrd\\_les/WhatDoIDo\\_Factsheet\\_CRR\\_CCR.pdf](http://www.defendingrights.org/hrd_les/WhatDoIDo_Factsheet_CRR_CCR.pdf)

<sup>34</sup> НҮБ-ын Ерөнхий Ассамблей, Хүний эрх хамгаалагчдын нөхцөл байдал, Ерөнхий нарийн бичгийн даргын тэмдэглэл, А/70/217 (2015 оны 7 сарын 30).



Кенийн Хүний эрхийн Үндэсний Комисс (КХЭҮК)-оос тус улсын гурван (Квали муж, Бусиа муж, Марсабит муж) мужид хүний эрх хамгаалагчид, цагдаагийн ажилтнууд болон хэвлэл мэдээллийнхний дунд харилцан ойлголцлыг бий болгох зорилготой төслийг хэрэгжүүлсэн байна. Өөр өөр бүлгийн оролцогчдод хэд хэдэн төрлийн сургалт явуулж, бусдынх нь хийдэг ажлыг тайлбарлаж өгчээ. Цагдаагийн ажилтнуудад НҮБ-ын Хүний эрх хамгаалагчдын тухай Тунхаглал болон Европын Холбооны Хүний эрх хамгаалагчдын Удирдамжийг дэлгэрэнгүй танилцуулж, хүний эрх хамгаалагчид гэж хэн болох, юу хийдэг, тэдэнд төрийн болоод хувийн хэвшлийн байгууллагаас үчруулдаг бэрхшээлүүдийн талаар мэдээлэл өгч, хамгаалагчдын үйл хэрэг цагдаагийн ажилтай ямар холбоотой талаар харилцан ярилцаж, урам зориг авсан байна. Цагдаагийн чиг үүрэг нэгэнт л хүний эрхийг хамгаалахтай шууд холбоотой тул тэд хүний эрхийг хамгаалагчдын үйл ажиллагааг өөрсдийн ажлын нэг тал гэж харах хэрэгтэй. Хамгаалагчдын үйл ажиллагаагаа аюулгүй явуулах орчныг бий болгоход хувь нэмрээ оруулна гэдэг нь өөрсдийн ажлаа хөнгөвчилж байна гэсэн үг. КХЭҮК-ийн дунд хугацааны тайлангаас үзэхэд, сургалт явуулсны дараах саруудад хүний эрх хамгаалагчдаас цагдаагийн эсрэг гаргасан гомдлын тоо багассан байна. Мөн өмнөх жилтэй харьцуулахад, Марсабит, Квали болон Бусиа мужуудад болсон эсэргүүцлийн жагсаалын үеэр хамгаалагчдыг баривчилсан тохиолдол жилийн хугацаанд (2014 оны 9 сараас 2015 оны 9 сар) бүртгэгдээгүй байна. Сургалтын дараа хамгаалагчид, цагдаагийн ажилтнууд болон хэвлэл мэдээллийн төлөөлөл бүхий Харилцан яриа хэмээх Форумыг сорилт бэрхшээлийг даван түүлсан туршлагаа хуваалцах, бие биэндээ хэрхэн туслалцаа үзүүлэх саналаа солилцох зорилгоор байгуулжээ.<sup>35</sup>

#### 4.4 Хэрхэн харилцах вэ?

Цагдаа нар хүний эрх зөрчсөний дараа хүний эрх хамгаалагчид ихэнх тохиолдолд болсон явдлын талаар олон нийтэд хандан шүүмжилсэн мэдэгдэл гаргахыг хүсдэг. Гэхдээ, цагдаагийн үйл ажиллагаанд нөлөөлөхийн тулд иймэрхүү мэдэгдлийг олон нийт төдийгүй цагдаагийн зүгээс хэрхэн хүлээж авахыг бодолцох хэрэгтэй. Ялангуяа, шүүмжилж байгаа арга зам нь, цагдаагийн зүгээс жагсаал цуглааныг хэрхэн зохицуулах талаар нээлттэй хэлэлцүүлэгт оролцох эсэх болон шүүмжлэл, санал болгосон зөвлөмжүүдийг нухацтай хүлээн авах эсэхэд ихээхэн нөлөө үзүүлнэ.



Цагдаа нар Алтон Стерлингийг буудан алсан явдлыг эсэргүүцэгчийг Батон Руж хотын цагдаагийн хэлтсийн цагдаа нар цагдаагийн газрын удирдах байрны ойролцоо баривчлан саатуулсан байна. АНУ, Луизиана муж, Батон Руж, 2016 оны 7 сарын 16, © REUTERS/Jonathan Bachman/File Photo

<sup>35</sup> Дунд хугацааны үйл ажиллагааны тайлан, 2014 оны 9 сараас 2015 оны 9 сар, Кенийн Хүний Эрхийн Үндэсний Комисс (КХЭҮК), EIDHR 2014/348/866 (2015), <http://knchr.org/Portals/0/AllOtherReports/EU%20FINAL%20YEAR%20ONE%20INTERIM%20REPORT%20-%202010%20Dec%202015.pdf?ver=2016-01-26-155143-633>

Гэхдээ энэ нь өөрийн үйл ажиллагааг хэт хязгаарлаж, цагдаагийн буруутай үйл ажиллагааны талаар хэвлэл мэдээллээр шүүмжлэхээ зогсоо гэсэн үг биш. Харин ч иймэрхүү мэдэгдлийн ойлгомжтой, тодорхой байдал болон хэлбэр, үгийн сонголтонд анхааралтай хандаж байх ёстой талаар хэлж байгаа юм. Энэ нь аливаа үйл явдлын талаар үзэл бодлоо илэрхийлэхээс өмнө найдвартай, бүрэн дүүрэн мэдээлэл байгаа эсэхээс мөн шалтгаалдаг. Олон нийтэд хандсан мэдээлэл нь баталгаа нотолгоогүй, цуурхалд суурилсан, нэг талыг барьсан, цагдааг хэт буруушаасан, эсвэл доромж үг хэллэг хэрэглэсэн бол цагдаагийн байгууллагатай үр дүнтэй яриа хэлэлцээр хийх боломжийг үгүй хийх магадлалтай. Цагдаагийн эсрэг сэтгэл хөдлөл, хувь хүний өрөөсгөл үзэл санаа орсон мэдээллээс илүүтэй бодит баримттай, үнэн зөв нэр томъёогоор бичигдсэн мэдээлэл нь цагдаатай яриа хэлэлцээр хийх замыг нээлттэй үлдээх боломжтой.

#Цагдаагийн харгислал гэх мэт хаштагийн доорх твиттерийн зурвас нь энэ тохиолдолд ихээхэн сөрөг үр дагавартай ба тэдний үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн ямар ч зөвлөмжийг хүлээн авахаас шууд татгалзахад хүргэх талтай. Олон нийтэд хандаж мэдээлэл хийхээсээ өмнө цагдаа нарт эхлээд өөрсдийн тайлбарыг хийх боломж олгох, тэдний тайлбар мэдэгдлийг өөрсдийн мэдээлэлдээ зохистойгоор тусгах нь илүү үр дүнтэй. Гэхдээ цагдаа нар үнэхээр хүний эрх зөрчсөн бол уг асуудалд шүүмжлэлтэй хандсан хэвээр байх нь зүйтэй.

Олон нийтийг хамарсан жагсаал цуглааны дараа цагдаагийн үйл ажиллагааны талаар тайлбар хийхдээ жагсагчдын гаргасан ямар нэгэн хууль бус үйлдлийн талаар дутуу дулимаг, хэт ерөнхий, эсвэл бүр хэтрүүлсэн мэдээлэл хийхгүйгээр болсон үйл явдлын бүх талыг харуулсан мэдэгдэл хийх нь зүйтэй. “Тайван жагсаал”-ын үеэр жагсагчид ямар нэг байдлаар хүчирхийлэл үйлдсэн тохиолдолд цагдааг хүч хэрэглэсэн хэмээн шүүмжлэх нь сөрөг үр дагавартай төдийгүй хамгаалагчдын гаргасан мэдэгдлийн үндэслэл, тэдэнд итгэх итгэлд хохирол учруулах аюултай. Цагдаа нар хүч хэтрүүлэн хэрэглээгүй л бол зарим жагсагчдын гаргасан хууль бус үйлдлийг хүлээн зөвшөөрөх нь олж авсан мэдээлэлд итгэх итгэлийг нэмэгдүүлнэ.

Цагдаагийн үйлдсэн хүний эрхийн зөрчлийг баримттайгаар олон нийтэд мэдээлнэ гэдэг нь ихээхэн ярвигтай асуудал юм. Ийм тохиолдолд цагдаа үнэн хэрэгтээ ямар хэмжээнд хариуцлага хүлээх нь ч тодорхойгүй байдаг. Тэр ч байтугай, хүний эрх хамгаалагчид цагдааг хүний эрхийн зөрчилд буруутай гэж үзлээ гэхэд үүнийгээ батлахад хэцүү байж мэднэ. Ийм нөхцөлд хүний эрх хамгаалагч нар цагдааг буруутгаж байгаа үндэслэлдээ болгоомжтой хандах хэрэгтэй ба энгийн сэжиг таамаглал, тухайн зөрчлийг цагдаа үйлдсэн нь нотлогдсон тохиолдол хоёрыг ялгаж салгах хэрэгтэй. Гэхдээ цагдаа нар цагдаагийн албан хаагч болох нь танигдахуйц, бусдаас ялгаж таних боломжтой байдгийг үргэлж санах хэрэгтэй. (эргүүл хийх болон дэг журам сахиулах үүрэг хүлээсэн үедээ өөрийн нэр бүхий тэмдгийг зүүсэн байх, эсвэл гэмт хэргийн мөрдлөг, баривчилгаа болон бусад үүрэгтэй холбоотойгоор энгийн хувцас өмссөн тохиолдолд бичиг баримтаа биедээ авч явах зэргээр). Хэрвээ ийнхүү таних боломжгүй бол хүний эрх хамгаалагчид энэ чиглэлд өөрчлөлт хийх талаар цагдаагийн байгууллагад хүсэлт тавьж болох юм.

Зарим тохиолдолд цагдааг хүний эрхийн зөрчилд буруутгасан мэдээллийг олон нийтэд цацах нь хариу арга хэмжээ авах эрсдэлийг дагуулдаг. Тухайн нөхцөл байдлаас хамааран үйл явдлын агуулгыг мэдээлэхдээ хувь хүний нэрийг дурдалгүйгээр байгууллагын нэрийг хэрэглэвэл, мөн хүний эрх хамгаалагчийн байгууллага ямар нэгэн сүлжээнд харъяалагддаг бол тухайн сүлжээний нэрийг дурдах нь иймэрхүү эрсдэлийг бууруулахад тус дөхөм болж чадна.

Хүний эрх хамгаалагчид цагдаагийнхны гарт эрх нь зөрчигдөж байгаа хүмүүсийн талаар цагдаад шууд гомдол гаргах талаар бодож байж болох юм. Гэхдээ энэ нь үнэхээр зөвлөлдөх боломжтой асуудал уу, эсвэл тэднийг илүү их аюулд оруулж байна уу гэдэг нь тухайн үеийн нөхцөл байдал, цагдаагийн байгууллагатай тогтоосон харилцаа болон цагдаагийн байгууллагын мэргэжлийн үр чадварын түвшнээс ихээхэн хамаарна.

Хэрвээ цагдаатай шууд харилцах гэж байгаа бол хамгаалагчид тухайн албан тушаалын зэрэг дэв нэг бүрийн хуулиар хүлээсэн үүрэг хариуцлага, шийдвэр гаргах эрх хэмжээний талаар ойлголт мэдлэгтэй байх, ямар албан тушаалтанд хандах нь хамгийн зөв, үр нөлөөтэй болохыг тодорхойлох хэрэгтэй (хэнтэй харилцах талаар 6.2 дахь хэсгээс үз).

Өмнө нь зөрчил гаргаж байсан цагдаагийн ажилтан уг хэрэгт дахин холбогдсон, эсвэл хамтран ажиллагсад нь мэдээллийг хүлээн авч, зөрчлийг шалгах болсон тохиолдолд хүний эрхийг зөрчлийг цагдаагийн газарт шууд мэдээлэх нь ихэнхдээ буруу сонголт байдаг. Энэ бол



хамгийн үр дүн муутай бөгөөд тухайн асуудлыг гаргаж тавьсан хүний эрх хамгаалагчдад эрсдэл дагуулахыг үгүйсгэхгүй.

Жишээлбэл, Африкийн нэгэн хүний эрх хамгаалагч байгууллагынхаа нэгэн гишүүнийг цагдаа барьж аваад машины тээшинд хийгээд явсан гэж мэдээлжээ. Тэрээр утастай явсан учир байгууллага руугаа утасдаж, мөн өмнө нь харилцаж байсан цагдаагийн газрын даргатай утсаар ярьжээ. Цагдаагийн газрын дарга баривчилгаа явуулсан ажилтантайгаа утсаар яриад хамгаалагчийг сулласан байна.<sup>36</sup>

Цагдаагийн газрын өндөр албан тушаалтантай холбоо тогтоох нь доод шатны албан хаагчидтай холбоотой хүний эрхийн зөрчлийг шийдвэрлэхэд ихээхэн дэмжлэг болохын зэрэгцээ өндөр албан тушаалтан хүний эрхийг хамгаалагчдыг үйл хэргийг зөвөөр хүлээн авч дэмжих, тэдний, эрхийг зөрчсөн ажилтныхаа асуудлыг зүй зохистойгоор шийдвэрлэх нь хамгаалагчдын эсрэг халдах нь тэвчиж болшгүй зүйл гэсэн хүчтэй дохиог өгнө.

#### 4.5 Дүгнэлт ба зөвлөмж

---

Дэлхий даяар үйл ажиллагаа явуулж байгаа хүний эрх хамгаалагчдын хувьд зарим тохиолдолд цагдаа үйл ажиллагаанд нь саад болохоос гадна хувийн аюулгүй байдалд нь ноцтой эрсдэл учруулж байдаг. Ийм нөхцөл байдалд хүний эрх хамгаалагчид үйл ажиллагаа явуулахдаа:

- Явуулж буй үйл ажиллагааныхаа хүрээнд олон улсын хүний эрхийн хэм хэмжээ болон дотоодын хууль тогтоомжоо мэдэх нь цагдаагийн хүний эрх зөрчсөн үйлдлийг таньж мэдэхэд тус дөхөм болохоос гадна энэхүү зөрчил нь дотоодын хууль тогтоомжийн зохицуулалтаас үүдэлтэй эсэх, эсхүл цагдаагийн үүрэг хариуцлагатай холбоотой эсэхийг ялгах боломжтой болно.
- Цагдаагийн зүгээс хүний эрх хамгаалагчдад хандах хандлага, үйл ажиллагаа болон цагдаагийн байгууллагын ажилтны мэргэжлийн үр чадварын хэр хэмжээ зэргийг мэдэж байх нь цагдаагийн зүгээс хамгаалагчдад учрах эрсдэлийг тооцоолоход тус болно.
- Цагдаагийн буруутай үйл ажиллагааг олон нийтэд мэдээлэхийн өмнө үнэхээр хүний эрхийн зөрчил байсан эсэх, гаргасан гомдол нь баримт нотолгоотой, алдаагүй эсэхийг шалгах хэрэгтэй.
- Хүний эрхийг зөрчсөн цагдаагийн үйл ажиллагаатай холбоотой мэдэгдлийг олон нийтэд дэлгэх, түүнчлэн цагдаагийн байгууллага болон гомдол барагдуулах бусад механизмд хандахынхаа өмнө холбогдох эрсдэлийг үнэлж үзэх хэрэгтэй.

UIN.MN  
СУДАЛГААНЫ САН

---

<sup>36</sup> Тэргүүн шугам дээрх хамгаалагчид, Дасгал ажлын ном: Эрсдэлд орсон хүний эрх хамгаалагчдыг хамгаалах практик алхмууд (2016), 29-р хуудас

## Цагдаа хамгаалагч болох нь

### 5.1 Удиртгал

Дэлхий даяар хүний эрх хамгаалагчид хийж буй ажлаасаа болж дарамт шахалтаас эхлээд бие махбодын дайралт, хулгайлагдах, амь насанд нь заналхийлэх, тэр ч байтугай амиа алдах зэрэг ноцтой эрсдэлүүдтэй нүүр тулгарч байна. Цагдаа нь эрсдэлд байгаа хүний эрхийг хамгаалагчид болон бусад хүний эрхийг хамгаалах, хамгаалагчдыг үйл хэргээ аюулгүй явуулах баталгаат орчныг бүрдүүлэх түүнчлэн гэм буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэхийн тулд мөрдөн шалгах чиг үүргийг хэрэгжүүлдэг.

Гэхдээ улс орон болоод бусад нөхцөл байдлаас хамааран хүний эрх хамгаалагчдын цагдаад хандах явдал харилцан адилгүй. Өмнөх бүлэгт дурдаж байсанчлан, олон тохиолдолд цагдаа өөрөө хамгаалагчдын эрхийг зөрчсөн гэм буруутан болдог. Энэ нь хамгаалагчдыг цагдаагийн үр нөлөөтэй, шаардлагад нийцсэн хамгаалалтыг авахад зарим тохиолдолд саад учруулдаг.

Гэвч цагдаа бол хүний эрх хамгаалагчдыг эрсдэлд оруулж буй цорын ганц тоглогч биш. Ажиллаж буй салбар, хамгаалж буй эрх ашиг зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалан хүний эрхийн хамгаалагчид бусад байгууллага, иргэдийн зүгээс ирэх аюул занал, дайралтын бай болдог. Жишээлбэл, зэвсэгт бүлэглэлүүдийн үйлдсэн хүчирхийлэл, гэм буруутай этгээдүүд хуульд заасан ял шийтгэлээс мултарч байгааг буруушаасныхаа төлөө хүний эрхийн хамгаалагчид тэдгээр бүлэглэлүүдийн заналхийлэл, дарамтын бай болдог бол бизнесийн байгууллага ажилчдынхаа эрхийг зөрчсөн эсхүл байгаль орчинд хохирол учруулсан асуудлаар ажиллаж байгаа хамгаалагчдад хувийн компаниуд саад тогтрон учруулдаг. Цаашлаад гэр бүлийн хүчирхийллийн эсрэг тэмцдэг хамгаалагчид хүчирхийлэгч болон тэдний гэр бүлийн гишүүдийн аюул заналхийлэлд өртөх магадлалтай. Орон нутгийн иргэдийн манлайлагчид, шашны байгууллагууд эмэгтэйчүүдийн хүчирхийллийн эсрэг болон ЛГБТИ иргэдийн эрхийн төлөө ажилладаг хамгаалагчдын эсрэг дайралт хийж байсан тохиолдол ч цөөнгүй байна.<sup>37</sup>



Тэмцэгчид Гуарани Каиова омгийн тэргүүн Семаио Вилхалвагийн аллагыг эсэргүүцэж хиймэл цус бие дээрээ асган эсэргүүцлээ илэрхийлж байгаа нь, 2015 оны 9 сарын 17, Сан Паоло. Эсэргүүцлийг зохион байгуулагчид, Вилхалваг өмнө нь Антонио Жао, Мато Гроссо Сул мужийн захиргаанд байсан омгийн газар нутгаас омгийн гишүүдийг хөөж гаргахаар 8 сарын 29-нд болсон мөргөлдөөний үеэр буудуулж амиа алдсан гэжээ. Хэргийг цагдаагийн газраас мөрдөн шалгаж байна. © REUTERS/Nacho Doce

<sup>37</sup> НҮБ-ын Ерөнхий Ассамблей, Хүний эрх хамгаалагчид, Ерөнхий нарийн бичгийн даргын тэмдэглэл, А/65/223 (2010 оны 8 сарын 4), 4-16 дугаар хуудас

Иймэрхүү аюул заналтай нүүр тулгарах үед хүний эрхийг хамгаалагчид өөрсдийн зөрчигдсөн эрхээ хамгаалуулах, тэдэнд халдсан халдлагыг мөрдөн шалгуулахаар цагдаагийн байгууллагад хандаж болох юм. Дээрх тохиолдолд хүний эрх хамгаалагчид цагдаагийн байгууллага тэдний эрхийг үр дүнтэй хамгаалах үүргээ биелүүлэх чадвартай эсэх мөн цагдаад хандснаар гарч болох эрсдэлүүдийг бодолцох хэрэгтэй. Ингэснээр тэд хэрвээ шаардлага гарвал цагдаад итгэж хандаж болох эсэх, хэрвээ тийм бол ямар хэмжээнд гэдгийг, мөн шаардлагатай гэж үзсэн тохиолдолд цагдаагаас өөр хамгаалалт авах талаар илүү сайтар бодолцож шийдвэр гаргах боломжтой болно.

## 5.2 Эрх зүйн орчныг танин мэдэх нь

Хэд хэдэн улс хүний эрх хамгаалагчдыг хамгаалах үндэсний хууль тогтоомжийг баталж, үүндээ НҮБ-ын Хүний эрх хамгаалагчдын тухай тунхаглалаар олон улсын өмнө хүлээсэн үүргээ тусгаж өгсөн байдаг. Энэ нь хүний эрхийг хамгаалагчдын үндэсний хэмжээнд хууль ёсоор ажиллах эрхийг баталгаажуулсан эерэг алхам хэдий ч хууль тогтоомжийг үр дүнтэй хэрэгжүүлж байгаа эсэх, мөн хүний эрх хамгаалагчдын үйл ажиллагаанд хэрхэн нөлөөлж байна вэ гэдэг нь улс орон бүрт харилцан адилгүй байгааг тэмдэглэх хэрэгтэй.<sup>38</sup>



Манадо хотод болсон Далай тэнгисийн асуудлаарх дэлхийн бага хурлын үеэр, хууль бус загасчлал болон далай тэнгисийг бохирдуулахыг эсэргүүцэн уриа лоозон барин жагсаж байгаа байгаль хамгаалагчдыг цагдаа нар хамгаалж байна, Индонез улс, 2009 оны 5 сарын 11. © REUTERS/Yusuf Ahmad

Мексик, Бразил, Колумб, Гондурас зэрэг Латин Америкийн орнуудад үндэсний хууль тогтоомж нь хүний эрх хамгаалагчдыг хамгаалах тусгайлсан механизм бий болгоход хүргэсэн байдаг.<sup>39</sup> Эдгээр механизмыг цагдаа хүний эрх хамгаалагчдыг хамгаалах арга хэмжээг авах үедээ голдуу ашигладаг байна.<sup>40</sup> Ийм механизмаар дамжуулан авч болох хамгаалалтын арга хэмжээнүүдийг харвал, хамгаалалт авахын тулд тодорхой шалгууруудыг хангасан байх ёстой ба өнгөрсөн хугацаанд хамгаалуулж байсан хүний эрх хамгаалагчдын туршлага нь хамгаалагчдад хэрэгцээ гарсан үед ямар хэмжээний хамгаалалт авах боломжтой талаар ойлголт өгнө.

<sup>38</sup> Олон улсын хамгаалалт байгууллага, Тусгай тайлан: Хүний эрх хамгаалагчдыг хамгаалах төрийн бодлого (2017) <https://www.protectioninternational.org/en/node/1537>

<sup>39</sup> Зааны Ясан Эрэг зэрэг бусад улсуудад Хүний эрхийн үндэсний комисс нь хамгаалах механизмыг хэрэгжүүлэх үүрэгтэй байдаг.

<sup>40</sup> Хамгаалалтын механизмуудын тухай Америкийн Эмнести Интернэшнл; Хүний эрх хамгаалагчдыг хамгаалах төрийн хамгаалалтын механизм (2017), AMR 01/6211/2017.

2016 онд Хүний Эрхийн Олон Улсын Төв (ХЭОУТ) байгууллага хүний эрхийн тэргүүлэх мэргэжилтэн, хуульчид болон дэлхийн өнцөг булан бүрээс ирсэн 500 гаруй хүний эрх хамгаалагчидтай хамтран «Хүний эрх хамгаалагчдыг хамгаалах, хүлээн зөвшөөрөх тухай загвар хууль»-ийг боловсруулж, олон нийтийн хүртээл болгожээ. Үг загвар хууль улс орнуудад НҮБ-ын ХЭХ Тунхаглалыг үндэсний хэмжээнд хэрхэн хэрэгжүүлэх удирдамж бөгөөд төр, түүний албан хаагчид хүний эрх хамгаалагчдыг үйл хэргээ явуулах боломж олгох, хамгаалах, тэдний эрх зөрчигдөх, мөрдөн шалгагдахаас урьдчилан сэргийлэх, зөрчигдсөн эрхийг сэргээх үүргүүдийг тусгайлан зохицуулсан заалтуудыг багтаажээ. Мөн хүний эрх хамгаалагчдыг хамгаалах үндэсний механизмыг хэрхэн бий болгох талаар авч үзсэн байна.<sup>41</sup> ХЭОУТ-ийн мэдээлснээр, үг загвар хуулийг Мали улсын парламент 2017 оны 12 сарын 13-нд баталсан Хүний эрх хамгаалагчдыг хамгаалах тухай хуулиа боловсруулахдаа ашигласан байна.<sup>42</sup>

Хүний эрх хамгаалагчдын эрхийг тухайлсан хуулиар хамгаалахын зэрэгцээ бусад хууль тогтоомжоор зарим эрхийг хамгаалалтыг бий болгох боломжтой. Жишээлбэл, Филлипиний улсын хууль тогтоох байгууллагаас 2012 онд баталсан Хүчээр сураггүй алга болгохоос бүх хүнийг хамгаалах тухай хуулиар эрэн хайх, мөрдөн байцаах, яллах ажиллагааны үеэр хүнийг хүч хэрэглэсэн байдлаар алга болохоос, мөн хариу авах, айлган сүрдүүлэхээс хамгаалдаг. Хүний эрхийн байгууллагын төлөөлөгчид энэхүү хуулиар хамгаалагдах бүлэгт хамаардаг.<sup>43</sup>

Хүний эрхийн хамгаалалт ямар түвшинд байгаа эсэхийг онолын хувьд мэдэхийн зэрэгцээ практикт хэрхэн хэрэгжиж байгаа үнэлэх хэрэгтэй. Эрх зүйн баталгаат орчин сайтар хангагдсан боловч үүнийг амьдралд хэрхэн хэрэгжүүлэх хүний нөөц, санхүүгийн чадавхи хязгаарлагдмал эсвэл байхгүй бол хэрэгжилт хангалтгүй гэсэн үг. Энэ нь цагдаагийн байгууллага болон тусгай хамгаалалтын механизмд ч хамааралтай бөгөөд санхүү, техникийн хүчин чадал, нөөц хангалтгүйгээс үр дүнтэй хамгаалалт хэрэгжүүлж чадахгүй. Түүнчлэн, хүний эрх хамгаалагчдыг хамгаалах нь цагдаагийн эн тэргүүний зорилт биш ч байж болно. Энэ чиглэлд нөөцийг хангалтгүй хуваарилсан бол хамгаалалтын арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлэхэд маш төвөгтэй. Жишээлбэл, байгууллагыг бүхэлд нь хамгаалуулахаар ганцхан ажилтныг томилох нь байгууллагын аюулгүй байдалд оруулах хувь нэмэр тун бага, тухайн байгууллагад ажилладаг хувь хүнээс ч бага үүрэгтэй байна.

Хүний эрх хамгаалагчдыг хамгаалах хууль байхгүй байгаа нь төр, цагдаагийн байгууллагын хүний эрх хамгаалагчдыг аливаа халдлага, бусад эрүүгийн гэмт хэргээс хамгаалах үүргээс чөлөөлөх үндэслэл болохгүй. Хүнийг гэмт хэргийн хохирогч болохоос хамгаалах цагдаагийн үүрэг нь хамгаалагчдад нэгэн адил хамаарах бөгөөд цагдаа энэхүү үүргээ ялгаварлалгүйгээр гүйцэтгэх ёстой. Хүний эрх хамгаалагчдын хувьд цагдаагийн найдвартай хамгаалалалт авах боломж нь зөвхөн дотоодын хууль тогтоомжийн асуудал биш, цагдаагийн хүчин чадал, хүний эрх хамгаалагчдыг хамгаалах цагдаагийн хүсэл зориг гэх мэт олон хүчин зүйлсээс хамааралтай ба энэ талаар дараагийн бүлгүүдэд дэлгэрэнгүй авч үзнэ.

UIN.MN  
СУДАЛГААНЫ САН

<sup>41</sup> [https://www.ishr.ch/sites/default/les/documents/model\\_law\\_english\\_january2017\\_screenversion.pdf](https://www.ishr.ch/sites/default/les/documents/model_law_english_january2017_screenversion.pdf) — хаягаар орж үзнэ үү.

<sup>42</sup> ХЭОУТ, Мали: Шинийг санаачилсан шинэ хууль хүний эрх хамгаалагчдын хамгааллыг бэхжүүлээ (2018 оны 1 сарын 16), <http://www.ishr.ch/news/mali-groundbreaking-new-law-strengthens-legal-protection-human-rights-defenders>

<sup>43</sup> 24-р хэсэг. [http://www.lawphil.net/statutes/repacts/ra2012/ra\\_10353\\_2012.html](http://www.lawphil.net/statutes/repacts/ra2012/ra_10353_2012.html); Гэхдээ Ерөнхийлөгч Дутертегийн “хар тамхины эсрэг дайн” энэ хуулийн үр нөлөөтэй хэрэгжих эсэхэд ихээхэн эргэлзээ төрүүлэх болоод байна. Нэмэлт мэдээллийг Филлипиний Эмнести Интернэшнл, Шинэ засаг захиргааны үед ял шийтгэлээс мултрах явдал нэмэгдэж байна, НҮБ-д илгээсэн Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт, хэлэлцүүлэг (2017 оны 5 сар), ASA 35/5445/2017; Нэмэлт мэдээллийг “Хязгаарлалтаас хамгаалалт хүртэл: Хүний эрх хамгаалагчдын эрх зүйн орчны талаар болон тэдний үйл хэргийг дэмжих, хамгаалах үндэсний хууль тогтоомжийн хэрэгцээ шаардлага судалгааны тайлан”-гаас үз, ХЭОУТ (2014) [http://www.ishr.ch/sites/default/les/article/les/research\\_report\\_on\\_legal\\_environment\\_for\\_hrds\\_upload.pdf](http://www.ishr.ch/sites/default/les/article/les/research_report_on_legal_environment_for_hrds_upload.pdf)

Хүний эрх хамгаалагчдын үйл ажиллагааг үндэсний хууль тогтоомжоор хууль бус хэмээн үздэг нөхцөлд асуудлыг өөрөөр авч үзнэ. Олон улсын хүний эрхийн хэм хэмжээг зөрчиж байгаа хэдий ч зарим улсууд зарим хүний эрхийг хамгаалагчдын үйл ажиллагааг хууль бус<sup>44</sup> гэж үздэг болохыг 3-р бүлэгт авч үзсэн билээ. Ийм нөхцөлд цагдаагаас хамгаалалт хүсэх нь, өөрсөддөө тулгардаг эрсдэл, аюул заналыг цагдаад ойлгуулахын тулд юу хийдэг, өөрийн үйл ажиллагааны зарим хэсгийг тайлбарлах зэргээр өөрсдийгөө санамсаргүй байдлаар хэрэгт унагахад хүргэж мэдэх юм. Иймэрхүү тохиолдолд цагдаа үйл ажиллагааг нь мэдэж байх нь ямар үр дагавартай байж болох, ямар эрсдэл учруулж болохыг сайтар бодож тунгаах ёстой.

Цагдаа хуульд заасан хамгаалах үүргээ биелүүлээгүй, үр дүнтэй, зохистой хамгаалалтын арга хэмжээ аваагүй, эсвэл ямар ч арга хэмжээ аваагүй тохиолдолд хүний эрх хамгаалагчид дотоодын хуулиар тэдэнд гомдол гаргах эрх байгаа эсэхийг шалгаж үзэх хэрэгтэй.<sup>45</sup> Улс орны нөхцөл байдал болон хариуцлагын тогтолцооноос хамаараад иймэрхүү гомдлыг цагдаагийн байгууллагын дотоод хяналтын механизмд хандаж болох бөгөөд, хэрвээ тухайн механизм нь хараат бус байж чадахгүй тохиолдолд, бусад хөндлөнгийн байгууллагад хандах боломжтой.

### 5.3 Хандлагыг ойлгох нь

Зарим улс оронд цагдаа нар хүний эрхийн талаар, хүний эрх хамгаалагчдын хэн болох, юу хийдэг талаар ерөнхий ойлголт байхгүй, эсвэл хангалтгүй байх нь бий. Энэ нь хүний эрхийн хамгаалагчдын үйл ажиллагааны хууль ёсны байдал, хэрэгцээ шаардлага, холбогдох эрх болон хууль зүйн хамгаалалтыг хүлээн зөвшөөрөхөөсөө илүүтэйгээр тэднийг үймээн таригчид, цагдаагийн ажилд саад учруулагчид гэж үзэхэд нөлөөлдөг.

Олон тохиолдолд хүний эрхийн асуудал цагдаагийн хувьд харь холын, дэг журам сахиулах ажлаа хийхэд нь тээг саад болон хувирч, эцэст нь хүний эрх хамгаалагчдад үл итгэх, тэр ч байтугай дайсагнасан байдлаар хандахад хүргэдэг.

Чухамдаа бол цагдаа нар өөрсдийгөө хүний эрх хамгаалагчид хэмээн харж, хамгаалагчдын үйл ажиллагааг өөрсдийнх ажилд нь саад бологч, бэрхшээл гэж үзэлгүйгээр хүний эрхийг хамгаалах чиг үүргээ биелүүлэхэд нь тус дэм болж байна гэж үзвэл зохино. Байгууллагынхаа албан хаагчдын хүний эрхийн ойлголт, хандлагыг нэмэгдүүлэх, хүний эрх нь дэг журам сахиулахад саад болдоггүй харин ч чухал ач холбогдолтой ойлголт болохыг ойлгуулах нь цагдаагийн байгууллагын удирдлагын үүрэг хариуцлагын асуудал юм. Хүний эрх хамгаалагчдын ажилд туслалцаа үзүүлэх, ялангуяа тэдний ажилд хэт их саад учруулахгүй байх, шаардлагатай үед тэднийг хамгаалах үүрэг мөн энд хамаарна (НҮБ-ын тунхаглалын 12-р зүйл).

Нөгөөтэйгүүр, цагдаа нь амьдарч байгаа нийгмийнхээ нэгэн хэсэг болохын хувьд хүний эрх хамгаалагчдын эсрэг аюул занал, халдлагыг үүсгэж болох нийгэмд давамгайлж байгаа үзэл бодол, өрөөсгөл хандлагуудыг өөгшүүлдэг болохоо ухамсарлах хэрэгтэй. Ялангуяа үйл ажиллагаа явуулж буй улс оронд нь хаалттай, эмзэг асуудлаар ажиллаж байгаа, нийгмийн зүгээс гутаан доромжлогдсон, дайсагнасан бүлэгт харъяалагддаг хамгаалагчдад илүү бэрхшээлтэй байдаг. Энэхүү байдал нь хамгаалалт үр дүнгүй байх, тулгарсан аюулыг ноцтой хэмээн үзэхгүй байх, эсвэл аюулд орсон хүний эрх хамгаалагчдад туслалцаа үзүүлэхээс татгалзахад хүргэж болно.

<sup>44</sup> Жишээлбэл, Оросын ЛГБТИ иргэдийн эрхийг хамгаалагчдыг "ижил хүйстний суртал ухуулгын хууль"-ийг интернэтээр олон нийтэд цацсан хэргээр ялласан (Евдокия Романовнагийн жишээг Тэргүүн шугам дахь хамгаалагчид байгууллага мэдээлсэн байдаг 2017 он) бол <https://www.frontlinedefenders.org/en/case/evdokiya-romanova-found-guilty-gay-propaganda>; Угандад 2016 онд батлагдсан ТББ-ын тухай хуулинд байгууллагын зорилго нь тус улсын хуультай "зөрчилдөж" байгаа байгууллагыг бүртгэхээс татгалзана гэж заажээ. Энэхүү заалт нь ялангуяа ЛГБТИ иргэд, биеэ үнэлэгч, хар тамхи хэрэглэгчд, эмэгтэйчүүдийн бэлгийн эрх, эрүүл мэнд, аюулгүй үр хөндүүлэх зэрэг эрхийн төлөө ажиллаж байгаа байгууллагуудад нөлөөлөх магадлалтай. 2006 оны ТББ-уудыг бүртгэх тухай (нэмэлт өөрчлөлт) хуулиар ТББ-ууд бүртгэлгүйгээр үйл ажиллагаа явуулах нь хууль бус юм. Эмнести Интернэшнл, Аюул дундах хүний эрх хамгаалагчид – Иргэний нийгмийн орон зай хумигдаж байна (2017 он) АСТ 30/6011/2017.

<sup>45</sup> НҮБ-ын Хүний эрх хамгаалагчдын тухай тунхаглалын 9-р зүйлд гомдол гаргах, хохирлоо барагдуулах эрхийг баталгаажуулсан байдаг.





Венесуэлийн ерөнхийлөгч Николас Мадурогийн засаглалын эсэргүүцсэн жагсаалын үеэр жагсагчид хэв журам сахиулж байгаа цагдаа нарыг тэвэрч байна. 2014 оны 5 сарын 22, Каракас хот, © REUTERS/Carlos Garcia Rawlins

Гэхдээ энэ нь бүх цагдаа нар хувь хүнийхээ хувьд хүний эрх хамгаалагчдыг хамгаалах үүргээ биелүүлэхгүй байснаараа тэдний үйл хэргийн эсрэг байдаг гэсэн үг биш. Үүнд цагдаагийн албан хаагчдын мэргэжлийн ур чадварын хэр хэмжээ, цагдаагийн байгууллага ажлаа хэрхэн гүйцэтгэдэг болон хувь хүний үзэл бодол цагдааг үүргээ гүйцэтгэхэд нь хэр хэмжээнд саад учруулдаг зэргийг ойлгох нь чухал юм. Хүний эрх хамгаалагчид цагдаагийн нэг ажилтны сөрөг хандлага, үл ойшоосон байдал болон цагдаагийн байгууллагаас үүдэлтэй ерөнхий бэрхшээлийг өөр хооронд ялгаж зааглан ойлгох хэрэгтэй.

Хүний эрхийн зарим байгууллагууд албан газрыг нь хамгаалах үүрэгтэй цагдаагийн ажилтнуудыг «хянах» хэрэгтэй болдог. Тэд цагдаагийн ажилтнуудын нэр, хувийн дугаар бүхий энгэрийн тэмдэгтэйгээ үүргээ гүйцэтгэсэн огноо, цаг, гарын үсэг зэргийг тэмдэглэж, тогтмол хугацаанд ажиллаж байгаа эсэх, мөн ямар ажилтан үүргээ бүрэн биелүүлэхгүй байгааг баримтжуулж байхаар цагдаагийн газартай тохиролцжээ.<sup>46</sup>

UJIAN  
СУДАЛГААНЫ САН

Цагдаагийн ажилтнуудад хүний эрх хамгаалагчдын ажлыг ойлгуулах, тэднийг аюулгүй орчинд ажиллах боломжийг хангахад цагдаагийн гүйцэтгэх үүргийг онцгойлон авч үзэх нь сөрөг хандлагыг багасгаж, хүний эрх хамгаалагчдад хэрэгцээ гарсан үед илүү хурдан хариу арга хэмжээ авдаг болоход хувь нэмрээ оруулна. Ер нь цагдаагийн байгууллагад хүний эрх хамгаалагчдыг хамгаалах үндсэн чиг үүрэгтэй, энэ чиглэлд тусгайлан сургаж бэлтгэгдсэн тусгай нэгж байх ёстой. Ийм тусгайлан нэгж байхгүй байсан ч хүний эрх хамгаалагчдыг хамгаалахад оролцож байгаа цагдаагийн ажилтнуудыг энэ чиглэлээр сургах хэрэгтэй ба тэдэнд хамгаалагчдын үйл хэрэг, хэрэгцээг таниулах хэрэгтэй. Хэрэв энэ чиглэлээр тодорхой ажил хийгдэхгүй байгаа бол хүний эрхийг хамгаалагчид энэ төрлийн сургалт явуулахыг цагдаагийн удирдлагаас шаардах хэрэгтэй.

<sup>46</sup> Олон улсын хамгаалалт байгууллага, Хүний эрх хамгаалагчдыг хамгаалах нь: Сайн туршлага болон сургамжууд (2012 он), 114-р хуудас



Мьянмар улсын Янгон хот дахь Тайландын элчин сайдын яамны өмнө Буддын лам нар, хүний эрхийн төлөө тэмцэгчид Тайландын засгийн газраас хуучин хамба ламыг нь баривчлахын тулд Дхамакаяа сүмд нэгжлэг хийх зөвшөөрөл өгсөн тусгайлсан хууль гаргахаар уриалж байгааг эсэргүүцсэн жагсаалыг цагдаа нар зохицуулж байгаа нь, 2017 оны 2 сарын 24, © REUTERS/Soe Zeya Tun

## 5.4 Хэрхэн харилцах вэ?

Өмнө нь аюул заналхийлэл, халдлагад өртөж байсан болон өртөх магадлалтай хүний эрх хамгаалагчид цагдаагаас хүсэх боломжтой хамгаалалтын хэд хэдэн хувилбар байж болох юм. Хамгаалалтын арга хэмжээ нь хувь хүний эрхийг хамгаалагчийг дагалдан явж хамгаалах, албан газрыг нь хамгаалах, яаралтай тусламж шаардлагатай үед хэрэглэдэг “тусламж дуудах утас” эсвэл камер зэргээс авахуулаад (сумны хамгаалалттай) машин, утас зэрэг янз бүрийн хэрэгсэл байж болно

**Жишээлбэл, Колумб улсад хүний эрх хамгаалагчид Үндэсний Цагдаагийн газрын тусгайлсан нэгжтэй радиогоор дамжуулдаг утсаар шууд холбогддог харилцаа холбооны сүлжээг байгуулжээ. Энэ нь хамгаалагчдад аюулд орсон үедээ цагдаагийн эргүүл дуудах боломжийг олгодог байна.<sup>47</sup>**

Хамгаалалтын арга хэмжээг цаг алдалгүй авах, мөн хамгаалалт нь зохистой, үр дүнтэй, аюулын зэрэгт тохирсон байх нь чухал юм. Хамгаалагчдын нөхцөл байдал, хэрэгцээнээс хамааран гарах үр дүн нь харилцан адилгүй байна. Нэгэн ижил аюул тулгарсан бүх хамгаалагчдад ижил төрлийн хамгаалалын арга хэмжээ авах нь үр дүнтэй байж чадахгүй болохыг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Жишээлбэл, яаралтай тусламж шаардлагатай үед хэрэглэдэг “тусламж дуудах утас” нь цагдаа хариу арга хэмжээ яаралтай авах боломжтой хот суурин газарт үр дүнтэй байж болох хэдий ч харин хөдөө, алслагдсан орон нутагт цагдаа хэргийн газар ирэх гэж их хугацаа зарцуулах тул энэ нь үр дүн багатай арга хэмжээ юм.

Цагдаагийн ажилтнууд хамгаалалтын үед аливаа эрсдэлийг үнэлэх шаардлагатай дээр хүний эрхийг хамгаалагчийн хэрэгцээ шаардлагад нийцсэн хамгаалалтын арга хэмжээг тохируулан хэрэгжүүлэх, тэдэнд хамгаалалт шаардлагатай эсэх, ямар арга хэмжээ авах талаар хамгаалагчидтай зөвлөлдөх хэрэгтэй. Хүний эрх хамгаалагчид өөрсдийн нөхцөл байдал, тулгарч буй аюул болон аюулын хэр хэмжээг хамгийн сайн мэдэж байдаг тул тэдэнд тохирох хамгаалалтын арга хэмжээг шийдвэртэй авах хэрэгтэй.

47 Мөн тэнд

Хүний эрх хамгаалагчдыг цагдаагийн ажилтан өдрийн тодорхой цагуудад, тэр ч байтугай өдөр шөнөгүй дагалдан явж хамгаалах нь тэднийг ажлаа хийх чадварт нь нөлөөлж болох юм. Нийгмийн зүгээс цагдаад итгэх итгэл ерөнхийдөө доогуур байдаг улсуудад цагдаагийн ажилтантай цуг байж олон нийтэд харагдах нь хамгаалагчийн нэр хүндэд сөргөөр нөлөөлөх, мөн тэднийг цагдаатай хамтарч байна гэж хүмүүс ойлгох талтай. Хүний эрх хамгаалагчдын ажил дээр нь ч, гэрт нь ч цагдаа байх нь тэднийг гэмт хэрэгт холбогдсон байх гэдэг ойлголтыг төрүүлэийг ч үгүйсгэхгүй. Хэрвээ хүний эрх хамгаалагчид ажлаар олон нийт болон хүний эрхийн зөрчлийн хохирогчидтой харилцдаг бол тэдэнтэй уулзах үед цагдаа байх нь эдгээр хүмүүсийг хамгаалагчдаас холдуулж, тэдэнтэй харилцах, ярилцахад саад болох талтай.

Цагдаагийн ажилтнуудаас дүрэмт хувцас бус энгийн хувцас өмсөх хүсэлт тавьж энэхүү эрсдэлийг бууруулж болох юм. Гэхдээ хамгаалагчид тусламж хэрэгтэй байгаа хохирогчидтой харилцахдаа зөвхөн хохирогчдыг анхаарахаас гадна хамгаалагч цагдаагийн хамгаалалтанд байхдаа хохирогчтой харилцах нь ямар эрсдэлтэй болохыг анхаарч үзэх хэрэгтэй. Хамгаалагчийг хамгаалж байгаа цагдаагийн ажилтан санамсаргүй байдлаар хохирогчийн байгаа газар, нэр гэх мэт тодорхой мэдээллийг олж авах боломжтой бөгөөд хамгаалагчийн ажиллаж байгаа хэргээс шалтгаалан хохирогчийг эрсдэлд оруулж болно. Цагдаагийн байгууллагаас нөгөө хохирогчийн эрхийг зөрчсөн тохиолдолд энэ нь ихээхэн хүндрэлтэй асуудал болно. Хүний эрхийг хамгаалагчид эрсдэлтэй нөхцөлд байгаа хохирогчидтой харилцах гэх мэт тодорхой ажил үүргийг гүйцэтгэхдээ бодолтой байх хэрэгтэй. Хэдийгээр хохирогчдыг цагдаагийн хамгаалалтанд байгаа үед нь харилцахад аюулгүй хэмээн үзэж болох хэдий ч зөвхөн хохирогчид зөвшөөрсөнөөс бусад тохиолдолд тэдэнтэй харилцахгүй байсан нь зөв сонголт болно.

Хүний эрх хамгаалагчид цагдаатай хамт явах нь олон нийтэд сөрөг ойлголт төрүүлээд зогсохгүй тэднийг улам илүү аюул занал, халдлагын бай болгох аюултай үр дагавартай байж болзошгүй. Жишээ нь, Бразилийн Фавела хэмээх (хотын бүсэд албан бусаар бий болсон суурингууд) зэвсэгт бүлэглэлүүдийн хяналтанд байдаг суурингуудад цагдаагийн хамт нэвтрэх нь хүний эрх хамгаалагчдыг тэдгээр зэвсэгт бүлэглэлийн халдлагын бай болгох аюултай.

Хүний эрх хамгаалагчид хамгаалалт авахаасаа өмнө хамгаалалтын арга хэмжээ авах үед цагдаагийн байгууллагаас ямар тохиолдлуудад үйл ажиллагаанд нь хөндлөнгөөс оролцох вэ гэдгийг тодруулж, хамгаалалтын нөхцлүүдийг сайтар хэлэлцэх хэрэгтэй. Цаашилбал, хамгаалагчид өөрсдийн үүрэг хариуцлагын талаар болон тэдэнд ямар хязгаарлалт тавьж болохыг мэдэж байх хэрэгтэй. Жишээлбэл, хохирогчтой ярилцлага хийх гэх мэт тодорхой үүрэг гүйцэтгэж байх үедээ дагалдан яваа цагдаагийн ажилтны чиг үүргийг үгүйсгэх нь цагдаагийн зүгээс хүлээн зөвшөөрөхгүй байх боломжтойн зэрэгцээ хамгаалалтын арга хэмжээг цуцлахад ч хүргэж мэднэ. Жишээлбэл, Колумб улсад хамгаалалтын арга хэмжээг “хамгаалалтын зохисгүй хэрэглээ” гэдэгт юу орох вэ гэдгийг тодорхойлсон байдаг бөгөөд үүнд хүн дагалдуулахгүйгээр аялах, хаалттай эсвэл олон нийтийн газар хүн дагалдуулж явахад саад болох зэрэг багтана.<sup>48</sup>

Бодит амьдралд хэрэгжих боломжтой байсан ч цагдаагийн зүгээс хүний эрх хамгаалагчдад (үр дүнтэй) хамгаалалт үзүүлэх сонирхолгүй байж болно. Энэ нь өмнөх хэсэгт өгүүлсэнчлэн, цагдаа нарын хамгаалагчдын тухай болон тэдний ажлын талаарх буруу ойлголтоос үүдэлтэй бөгөөд тэдэнд тулгарсан аюулыг нухацтай авч үзэхгүй, тэдний хамгаалуулах хэрэгцээг ойлгож, туслахын оронд тэдэнд тулгардаг аюулынх нь төлөө тэднийг буруушаах явдалд хүргэж болзошгүй. Цагдаагийн хамгаалалт авах боломжгүй нөхцөлд хамгаалагчид цагдаагаас гадна аюулгүй байдлыг хангах, хамгаалалтын үйлчилгээ үзүүлдэг өөр байгууллагад хандах боломжтой. Жишээлбэл, Пийс Бригад Интернэшнл (ПБИ) сайн дурынхны багийг хүний эрх хамгаалагчдыг дагалдуулан хамгаалах, эсвэл байгууллагын албан байранд байрлаж байгууллагыг хамгаалах, мөн тогтмол хугацаанд утсаар холбогдон аюулгүй байдлыг шалгах зэрэг үйлчилгээ үзүүлдэг.<sup>49</sup>

Хамгаалагчид цагдаагийн байгууллагаас хамгаалалт хүссэн эсэхээс үл хамааран тэдний эсрэг үйлдэгдсэн ямар нэгэн аюул заналхийлэл, халдлагыг хэнд, хэрхэн мэдээлэх вэ гэдэг нь тусдаа асуудал юм.

<sup>48</sup> Олон улсын хамгаалалт байгууллага, Хүний эрх хамгаалагчдыг хамгаалах нь: Сайн туршлага болон сургамжууд (2012 он), 2-р хэсэг, 4.5 дахь бүлэгт “зохисгүй хэрэглээ” гэх мэт ойлголтууд нь Бразил, Колумб, Гватемал зэрэг улсуудад байдаг хамгаалалтын механизм юм.

<sup>49</sup> Пийс Бригад Интернэшнл, Дагалдан хамгаалах нь, <https://www.peacebrigades.org/en/about-pbi/what-we-do/protective-accompaniment>

Зарим хүний эрхийг хамгаалагчид цагдаагийн дарамт, халдлагыг мэдээлснийхээ төлөө цагдаагийн газрын байранд хүчирхийлэлд өртөж, хуулийн зохих хамгаалалт авахын оронд өөрсдийгөө цагдаагийн мөрдөн байцаалтын бай болгосон тухайгаа мэдээлсэн байдаг. Энэ тухайд тэд өөрсдийгөө гэмт хэргийн хохирогчийн хувиар эрх эдлэх ёстой гэдгээ мэдэж байх нь чухал юм. Олон улсын хэмжээнд, албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж үйлдсэн гэмт хэрэг болон зөрчлийн хохирогчдын талаарх хууль цаазын үндсэн зарчмуудын тухай НҮБ-ын Тунхаглалд гэмт хэргийн хохирогчидтой хэрхэн харилцах талаарх олон улсын хэм хэмжээг зааж өгсөн байдаг. Тухайлбал, хохирогчдыг энэрэн нигүүлсэх, эрхэм чанарыг нь хүндэтгэх ёстой бөгөөд тэд хөндөгдсөн эрхээ сэргээлгэхээр шударга ёсны механизмд яаралтай хандах эрхтэй (4-р зарчим). Албан тушаалтнууд хохирогчид учрах тааламжгүй байдлыг багасгах, шаардлагатай үед тэдний хувийн орон зайг хамгаалах, тэднийг болон гэр бүлийг нь, гэрч нарыг айлган сүрдүүлэх, хариу авах явдлаас хамгаалах ёстой (6-р зарчим).

Хүний эрх хамгаалагчид ямар мэдээлэл өгвөл цагдаа нар нууц гэж үзэхгүй байж болох мөн өгсөн мэдээллийг нь өөрсдийнх нь болон байгууллагынх нь эсрэг ашиглаж болохыг бодолцож хянуур байх хэрэгтэй.

Жишээ нь, Бангладешийн хүний эрх хамгаалагчдын цагдаад өгсөн мэдээллийг цагдаа хэвлэл мэдээллийнхэнд дамжуулж, хамгаалагчдын мэдээлсэн аюулын тухай маргаашийнх нь орон нутгийн сонинд хэвлэгдсэн байжээ.<sup>50</sup>

Аливаа хүчирхийлэл, аюул заналхийллийн талаар цагдаад мэдээлэх шийдвэр гаргахаасаа өмнө хамгаалагчид өөрт болон бусдад учирах эрсдэл, хууль зөрчигчдөд хариуцлага хүлээлгэхийн тулд мөрдөн байцаах ажиллагаа явуулах шаардлага байгаа эсэх, ийм үйлдлүүд шийтгэлээс мултрах ёсгүй гэсэн дохиог өгөх гэх мэт олон асуудлуудыг анхаарч үзэх хэрэгтэй. Зарим нэгэн тодорхой хэргүүдээс гадна, хүний эрхийн зөрчлийг мэдээлэх нь хамгаалагчдын эсрэг хүчирхийллийн хэлбэрүүдийг илрүүлэхэд мөн хүчирхийлэлтэй тэмцэх, хамгаалагчдыг илүү өргөн хүрээнд хамгаалахад шаардлагатай арга хэмжээг авахад тус болдог тул хамгаалагчид илүү өргөн хүрээгээр асуудалд хандвал зохино.

**Тухайлбал, Гватемалад Яамтай байгуулсан гэрээний дагуу Дүн шинжилгээ хийх нэгжийг байгуулсан ба энэ нь хүний эрх хамгаалагчдын эсрэг гарсан халдлагад дүн шинжилгээ хийж, хүчирхийллийн хэлбэрүүдийг судлах зорилготой юм. Энэхүү нэгж нь Дотоод хэргийн яам, прокурор, цагдаа мөн ТББ-ын төлөөлөлтэйгөөр байгуулагджээ.<sup>51</sup> Хэдийгээр энэ нь хүний эрхийг хамгаалах чиглэлээр хийгдсэн сайн алхам хэдий ч, олж илрүүлсэн хэргийг хэрхэн шийдвэрлэх талаар хуулинд нарийвчлан тусгаж өгөөгүй байна. Үр дүнд хүрэхийн тулд Нэгжийн гаргасан дүгнэлтийн дараа холбогдох ажиллагааг явуулах шаардлагатай.**

Зарим хүний эрх хамгаалагчид цагдаа нар тоохгүй, эсвэл ямар нэгэн арга хэмжээ авахгүй юм чинь цагдаад хандах нь утгагүй хэрэг гэж үздэг байж болох юм. Иймэрхүү төсөөллийг зөвтгөх тодорхой тохиолдлууд ч байдаг. Хүний эрх хамгаалагчид хэдийгээр цагдааг хариу үйлдэл хийнэ гэсэн хүлээлтгүй байсан ч хүний эрхийг зөрчлийг мэдээлж байх нь чухал. Хэрэв цагдаа хуульд заасны дагуу зохих арга хэмжээ аваагүй тохиолдолд тэдний үл тоомсорлосон байдлын эсрэг тодорхой арга хэмжээ авах хэрэгтэй.

Гэхдээ зөрчлийг мэдээлэх нь утгагүй зүйл биш боловч хамгаалагчдын хувьд мөн л аюултай, тэдний (бие махбодод) аюулгүй байдалд эрсдэл учруулдаг. Ийм тохиолдолд хамгаалагчид өөрсдийн аюулгүй байдлыг хамгийн эхэнд бодох хэрэгтэй бөгөөд хэтэрхий эрсдэлтэй байвал цагдаатай харилцахгүй байсан нь дээр.

<sup>50</sup> Тэргүүн шугам дээрх хамгаалагчид, Хохирогчдыг буруушаасан нь: Бангладешийн хүний эрх хамгаалагчдын алдаа (2016 он), 16-р хуудас

<sup>51</sup> Яамтай байгуулсан гэрээ #.103-2008 (2008 оны 1 сарын 10), <https://www.congreso.gob.gt/wp-content/plugins/acuerdos/includes/uploads/docs/2008/gtamx103-2008.pdf>



Олон улсын Олимпын Хорооны 119-р чуулган Гватемала хотод болох үеэр Гватемалд эмэгтэйчүүдийн амийг хөнөөх явдал их байгаад олны анхаарлыг хандуулахыг хүссэн тэмцэгч эсэргүүцлээ илэрхийлж байгаа нь, 2007 оны 7 сарын 3. Эсэргүүцлийн хуудсан дээр “Эмэгтэйчүүдийг хөнөөхөө зогсоо” гэсэн байна. © REUTERS/Daniel LeClair

## 5.5 Дүгнэлт ба зөвлөмж

Хүний эрх хамгаалагчдыг учирч буй аюул занал, халдлагаас хамгаалахад цагдаа чухал үүрэг гүйцэтгэж чадна. Гэхдээ цагдаагаас тусламж хүсч хандахдаа авах хамгаалалтын түвшин болоод уг арга хэмжээнээс учрах эрсдэлийг ч бас үнэлж үзэх хэрэгтэй. Хэрвээ цагдаагийн зүгээс хамгаалж чадахгүй, эсвэл тэднийг хангалттай хэмжээнд хамгаалахыг хүсэхгүй байгаа нөхцөлд, эсвэл эрсдэл хэтэрхий их байгаа бол хамгаалагчид цагдаагаас өөр, өөрсдийн гэсэн хамгаалалтын сүлжээтэй болох нь илүү чухал болно.

- Хүний эрх хамгаалагчид үндэсний хууль тогтоомжоор баталгаажсан хамгаалалтын түвшингээ мэддэг байх шаардлагатай. Зарим улс хүний эрх хамгаалагчдыг хамгаалах тусгайлсан хуультай байдаг бол зарим тохиолдолд тусгайлсан хамгаалалтын механизмыг ч бий болгосон байдаг. Ийм нөхцөлд, хамгаалагчид энэхүү зохицуулалт нь үр дүнг нь тооцоолох хэмжээнд хэрэгжиж чадсан уу, хэр итгэж болох вэ гэдгийг үнэлэх шаардлагатай. Хамгаалагчдыг хамгаалах хууль байхгүй гэдэг нь цагдаагийн байгууллагыг хамгаалах үүргээс нь чөлөөлөхгүй.
- Цагдаа нар хүний эрх хамгаалагчдын талаар сөрөг ойлголт, өрөөсгөл хандлагатай байж болно. Хамгаалагчид энэ талаар болон энэхүү хандлага нь тэднийг (үр дүнтэй) хамгаалах цагдаагийн хүсэл зоригт ямар хэмжээгээр нөлөөлөх талаар ойлголттой байвал зохино.
- Хүний эрх хамгаалагчдад ямар түвшний хамгаалалт хэрэгтэй байдаг, хувь хүний нөхцөлд байдлаас шалтгаалан ямар төрлийн хамгаалалтын арга хэмжээ авах нь зохистой талаар зохион байгуулдаг хэлэлцүүлэгт цагдаа, хамгаалагчдыг идэвхтэй оролцуулах хэрэгтэй. Ингэхдээ, онолын хувьд боломжтой хувилбаруудыг бодолцож үзэхээс гадна амьдрал дээр энэ нь хэрхэн хэрэгжих вэ, хэрэгжүүлэх арга хэрэгсэл болон цагдаагийн зүгээс (үр дүнтэй) хамгаалах хүсэл зориг хэр байна вэ гэдгийг ч бодолцож үзэх нь чухал юм.



**UIH.MN**  
СУДАЛГААНЫ САН

## Үр дүнтэй яриа хэлэлцээ хийх нь: Боломж болон сорилтууд

### 6.1 Удиртгал

Өмнөх хэсгүүдэд өгүүлсэнчлэн, хүний эрх хамгаалагчид цагдаагийн ажилтай янз бүрийн байдлаар холбогддог. Зарим үед хамгаалагчид цагдаагийн зүй бус үйл ажиллагааны хохирогч болж цагдаагийн гарт эрхээ зөрчүүлж ч болзошгүй. Цагдаагийн байгууллагатай үр дүнтэй яриа хэлэлцээ хийх нь энэ мэтийн асуудалд анхаарлыг нь хандуулах, тулгамдаад буй хүний эрхийн асуудлуудыг шийдвэрлэхэд тус дөхөм болно.

Цагдаатай холбоотой хүний эрхийн асуудлаар ажилладаг хүний эрхийн хамгаалагчдын хувьд цагдаагийн байгууллага шууд харилцагч болно. Жишээлбэл, газрын эрхийн асуудлаар ажиллаж байгаа хамгаалагчдын хувьд хэрвээ цагдаа нар албадан нүүлгэж байгаа бол цагдаатай ярилцах нь чухал гэж үзэх нь түгээмэл байдаг. Гадуурхалд өртсөн цөөнхийн эрхийн төлөө тэмцэж байгаа хамгаалагчдын хувьд угсаатны болон арьсны өнгөөр ялгаварлан хүнийг эрүүгийн хэрэгт татах, сэжиглэх цагдаагийн үйл ажиллагааны практикийг ил болгон тавих, энэ талын ойлголт хандлагыг өөрчлөх, цөөнхийн бүлгийг ялгаварлан гадуурхах гэмт хэргийг мэдээлэх, цагдаагийн зүгээс ийм төрлийн гэмт хэргээс сэргийлэх, илрүүлэх, мөрдөн шалгах арга хэмжээ авахыг шаардах шаардлага гарч болзошгүй. Зарим үед жишээ нь, цагдаа нар ЛГБТИ хүмүүсийг дарамтлах, дур зоргоороо баривчлах, тэдэнтэй зүй бусаар харьцах зэргээр хамгаалагчдын шийдвэрлэх асуудлын нэг хэсэг болж ч магадгүй.

Дээрх бүх нөхцөл байдалд хүний эрх хамгаалагчид харилцан адилгүй зорилгуудаа бодитоор биелүүлэхийн тулд цагдаагийн байгууллагатай хэрхэн шууд харилцах вэ гэдгээ бодолцох хэрэгтэй, Үүнд:

- Тулгараад байгаа асуудлын талаар илүү их мэдээлэл олж авах,
- Болсон явдлыг цагдаагийн зүгээс юу гэж үзэж байгааг болон нөхцөл байдлын талаар илүү сайн ойлголттой болох,
- Цагдаагаас цогц ажиллагаа явуулахыг шаардах, тухайлбал, баривчлагдсан хүний хаана байгааг тодорхой болгох, түүнийг суллах, цагдаагийн ажилтны ёс зүйн зөрчлийг илрүүлэх дотоодын мөрдөн шалгах ажиллагааг явуулах гэх зэрэг
- Цагдаагийн байгууллагатай холбоотой тулгамдсан асуудлууд болон тэдгээрийн шийдлийг хэлэлцэх, ярилцах. Тухайлбал, “Зогсооноод - нэгжлэг хийдэг” явдлыг зогсоох, жагсаал цуглааныг зохицуулах, албадан нүүлгэх шийдвэрийг биелүүлэх зэрэг зарим төрлийн ажиллагаа явуулж буй цагдаагийн арга барилыг дахин хянаж үзэх гэх мэт



Мальта улсын сангийн сайд Крис Кардонаг авлигын эсрэг бичдэг сэтгүүлч Дафни Каруана Гализигийн аллагад буруутгагдсан хүмүүсийн нэгэнтэй нь уулзсан хэмээн Дафни Санаачилга төслийн хэсэг сэтгүүлчид мэдээлсний дараа иргэний нийгмийн идэвхтнүүд түүнийг байцаахыг цагдаагаас шаардаж, Валетта (Мальта) хотын цагдаагийн газарт орхисон зурагт хуудсан дээгүүр цагдаагийн ажилтнууд алхаж байна, 2018 оны 4 сарын 19, © REUTERS/Darrin Zammit Lupi

Цагдаатай үр дүнтэй яриа хэлэлцээ хийх нь хүний эрхийг хамгаалах зорилгодоо хүрэх хамгаалагчдын хүчин чармайлтыг нэмэгдүүлэх боломж олгоно. Гэхдээ цагдаатай харилцах талаар шийдвэр гаргахаасаа өмнө хэд хэдэн зүйлийг бодолцох хэрэгтэй. Юуны өмнө хүний эрхийг хамгаалагчид яриа хэлэлцээний үр дүнд бий болох эерэг боломжийн талаар төдийгүй учирч болох сорилт, болзошгүй эрсдэлүүд, түүнчлэн цагдаагийн байгууллагатай үр дүнтэй яриа хэлэлцээ хийх нь боломжтой эсэх талаар үнэлгээ хийх хэрэгтэй. Ихэнх тохиолдолд цагдаатай харилцаа холбоо тогтоох нь амаргүй, шууд харилцаа тогтоох гэж оролдох нь хамгаалагчдыг өөрсдийг нь болоод тэдний эрхийг нь хамгаалж байгаа хүмүүсийг эрсдэлд оруулах тул цагдаагийн байгууллагад шууд хандах нь зөв сонголт биш гэдгийг ойлгох хэрэгтэй. Гэхдээ, хэрэв цагдаатай хамтран ажиллах шийдвэр гаргасан бол яриа хэлэлцээрийг аль болох үр дүнтэй хийхийн тулд цагдаагийн байгууллагыг сайн мэдэж, ойлгож авах нь нэн чухал юм.

## 6.2 Хэнтэй хамтрахаа шийдэх нь

Хууль сахиулах байгууллага шатлан захирах бүтэцтэй байдаг. Шийдвэрлэх асуудлаас хамааран, тухайн асуудлыг шууд зохицуулах захирах, захирагдах зарчимд үндэслэсэн олон төрлийн хэлтэс нэгжүүд ажилладаг. Иймд хамгаалагчид цагдаагийн байгууллагын доторх бүтэц, “хэн нь хэн болох”, “хэн нь юу хариуцдаг” болохыг ойлгож авах нь чухал юм. Энэ нь хүний эрх хамгаалагчдын хүсч буй өөрчлөлтийг хийхэд шаардлагатай шийдвэр гаргах эрх мэдэлтэй, тулгамдсан асуудлыг хэлэлцэх хамгийн сайн хамтрагчийг олоход тус дөхөм болох юм.

**Бага албан тушаалтны түвшинд:** Зарим үед хүний эрх хамгаалагчид хууль сахиулах чиг үүргийг гардан хэрэгжүүлж байгаа доод шатны цагдаагийн ажилтнуудтай ярилцах нь үр дүнтэй байдаг. Жишээ нь, тэд шийдвэрлэх гэж байгаа асуудалтай нь холбоотой үйл ажиллагааг зохицуулахад оролцож байсан тухайлбал, хохирогчийг албадан саатуулсан, эрэн сурвалжилсан, баривчилсан, хэрэг бүртгэл, мөрдөн байцаалт явуулсан нэр бүхий цагдаагийн ажилтантай ярилцахыг хүсч болох юм. Иймэрхүү ярилцлагын үеэр болсон үйл явдал, нөхцөл байдлын талаар хамгийн ойрын эх сурвалжаас мэдээлэл авах, тодорхой нэг хэргийн талаар ярилцах, таамаглал дэвшүүлэхийн зэрэгцээ өөрсдийн хүссэн мэдээллээ олж авах зэрэгт ач холбогдолтой байж болно.

**Дунд болон дээд тушаалын түвшинд:** Ихэнх тохиолдолд хамгаалагчдын гаргаж тавьдаг хүний эрхийн асуудал нь үүрэг гүйцэтгэсэн хувь цагдаагийн ажилтны авсан арга хэмжээ, шийдвэрээс бус харин тэдний хүлээж авсан тушаал шийдвэрийн үр дүн байдаг. Жагсаал цуглааныг тараах, албадан нүүлгэн шилжүүлэх зэрэг тушаалуудыг ихэвчлэн дээд шатны албан тушаалтан өгсөн байдаг. Иймээс хүний эрх хамгаалагчид шийдвэр гаргахад оролцсон хүмүүстэй асуудлаа ярилцах нь зүйтэй. Цагдаагийн байгууллага дахь ийм албан тушаалтнууд нь доод тушаалын албан хаагчдын талаар хамгаалагчдын гаргасан гомдлыг хэлэлцэхэд хамтрагчийн үүрэг гүйцэтгэх боломжтой. Эндээс авч үзвэл, яриа хэлэлцээр нь алдаа гаргасан цагдаагийн ажилтны буруутай үйл ажиллагаанд хариуцлага хүлээлгэх, хариуцлага, хяналтын тогтолцоог хангахад зохих үүрэг гүйцэтгэнэ.

**Дээд түвшинд:** Амьдрал дээр илэрдэг хүний эрхийн зөрчлүүд нь цагдаагийн байгууллагын дээд түвшний албан тушаалтнуудын түвшинд шийдвэрлэвэл зохих бодлого, зохион байгуулалтын түвшний асуудлын үр дүн байдаг. Үүнд, дүрэм журам, зааварчилгааг хангалттай өгдөггүй, ажилтныг ажилд авах, тэднийг сургалтанд хамруулахдаа хүний эрхийн асуудлыг орхигдуулснаас, цагдаагийн байгууллагын албан хаагчдын асуудалд олон талт байдлаар асуудалд хандах чадвар хангалтгүй байдаг зэрэг асуудлыг нэрлэж болно.

**Сургалтын байгууллагууд:** Цагдаагийн байгууллагын бүрэлдэхүүнд хамаарах сургалтын байгууллагууд нь хүний эрх хамгаалагчийн хувьд харилцахад хамгийн хялбар газар юм. Гэхдээ, сургалтын байгууллагууд нь тухайн улс оронд дэг журам сахиулах ажиллагаа хэрхэн явагдах ёстойг шийддэг газар биш гэдгийг мартаж болохгүй. Ихэнх тохиолдолд сургалтын байгууллагын дарга байна гэдэг нь цагдаагийн мэргэжлийн хувьд цаашид өсөх боломжгүйд (арай дээгүүр албан тушаалтай байсан ч гэсэн) тооцогдох бөгөөд тухайн ажилтан хууль сахиулах байгууллагын дотор ямар нэгэн нөлөөгүй, эсвэл тун бага нөлөөтэй байдаг. Хэдий тийм боловч тэдгээр ажилтан цагдаагийн сургалт хэрхэн явагддаг, хүний эрхийн асуудлыг сургалтын хөтөлбөрт хэрхэн оруулдагийг мэдэхэд тань чухал хамтрагч болж чадна.



Хүчирхийллийн эсрэг иргэний хөдөлгөөнийхөн Нигерийн цагдаагийн газрын ерөнхий мөрдөн байцаагч Соломон Арасыг цагдаагийнхны 2015 оны 8 сарын 18-нд хэт их хүч хэрэглэсэн хэргийг шалгуулахаар шаардаж байгаа бөгөөд уг хөдөлгөөний гишүүн цагдаагийн үйлдсэн аллагуудын тухай ярьж байна. © REUTERS/Afolabi Sotunde

Цагдаагийн байгууллагын дотор зохих түвшиндээ очиж харьцах нь ихэнхдээ амаргүй байдаг. Дээд албан тушаалын хүнтэй уулзахаар очсон хүний эрх хамгаалагчдыг тухайн асуудлаар шийдвэр гаргаж чадах хүнтэй уулзуулахын оронд заримдаа хэвлэл мэдээллийн, эсвэл олон нийттэй харилцах ажилтан, хүний эрхийн хэлтэс юмуу, сургалтын хэлтсийн ажилтнуудтай уулзуулах нь олонтаа тохиолддог. Эдгээр ажилтнуудаас мэдээлэл авах нь хамгаалагчдын ажилд хэрэгтэй боловч тэд бол тухайн тодорхой асуудлын талаар шийдвэр гаргах аливаа эрхгүй. Цагдаагийн үйл ажиллагаа хэрхэн явагдах талаарх бодлого, зааварыг зөвхөн дээд түвшний нэгжүүд тодорхойлдог ба эрх хэмжээний хувьд сургалтын байгууллага нь тэдгээр заавар журмыг зөвхөн хүлээн авагч бөгөөд дэг журам сахиулах, зааварчилах тухайд ямар нэгэн шийдвэр гаргах эрх мэдэлгүй байдаг.

Хүний эрх хамгаалагчдад цагдаад хандах, холбогдох этгээдтэй харилцаа холбоо тогтоох янз бүрийн арга зам байдаг. Явал хамгийн тохиромжтой, боломжийн байх вэ гэдэг нь тухайн нөхцөл байдал болон цагдаатай харилцах харилцаанаас ихээхэн хамаарна. Жишээ нь, хамгаалагчид цагдаа нартай холбоо тогтоохын тулд тэдний оролцож байгаа хурал, зөвлөгөөнд оролцох, эсвэл өөрсдийн зохион байгуулсан хуралд тэднийг урьж болох юм. Өөр нэг хувилбар бол одоо байгаа сүлжээгээ ашиглах, жишээ нь, цагдаатай холбоотой асуудлаар ажиллаж байгаа байгууллагаас, эсвэл парламентийн гишүүн юм уу, элчин сайдын яамны ажилтнуудаас цагдаагийн байгууллагатай холбож өгөхийг гуйж болно.

Зарим тохиолдолд цагдаа нар өөрийн байгууллага дотроос гаргасан санал, санаачлагад нааштай ханддаг гэдгийг санаж байхад илүүдэхгүй. Иймд хамгаалагчид зарим тохиолдолд цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд өөрчлөлт хийхээр оролдохоос илүүтэйгээр тухайн байгууллага доторх ижил үзэл бодолтой хүмүүсээс дэмжлэгийг авах нь асуудлыг шийдвэрлэхэд илүү үр ашигтай байж болно.

90-ээд оны сүүл, 2000-аад оны эхээр Оросын Иргэдийн Хяналт байгууллагаас цагдаагийн байгууллага нь бусад байгууллагатай харьцуулахад хүний эрхийн ноцтой зөрчлүүдийг байнга гаргаж байгааг илрүүлжээ. Үг байгууллагын хийсэн эхний алхам бол тэдний санаа бодлыг хүлээн авах, мөн байнга хамтран ажиллах сонирхолтой цагдаагийн албан хаагчдыг олж тогтоох явдал байв. Тэдгээр ажилтантай харилцах арга барил нь зөвхөн өөрсдийн санаа бодлыг тулгахаас гадна хариуд нь санал болгох ямар нэг зүйлтэй байх, тэдний хүчин зүтгэл ажлыг нь хэцүү биш, харин ч үр дүнтэй болгоход чиглэх ёстой байжээ.<sup>52</sup>

Хүний эрхийн байгууллага дундаас цагдаатай харилцаа тогтоох зөв хүн(хүмүүс)ийг сонгох нь хамгийн чухал. Тэрхүү хүн (хүмүүс) нь харилцааны соёл сайтай, болж өгвөл цагдаагийн талаар мэдлэгтэй, холбогдох туршлагатай, цагдаагийн соёл, хандлага, үг хэллэгийг ойлгодог байх хэрэгтэй. Ялангуяа, байгууллагын дээгүүр албан тушаалтантай ярилцахдаа, тодорхой нэр хүндтэй, болж өгвөл цагдаагийн байгууллагатай харилцаж байсан хүнийг уулзуулбал тэдний ярианд илүү ач холбогдол өгөх магадлалтай. Хэрвээ цагдаатай шууд уулзаж ярилцах оролдлого бүтэлгүйтвэл, хүний эрхийг хамгаалагчид энэ тухайгаа олон нийтэд мэдээлэх хэрэгтэй. Ингэснээр цагдаа нар дараа нь хамгаалагчдыг өөрсөдтэй нь ярилцах гэж оролдоогүй, тэдний үзэл бодлыг сонсохыг хүсээгүй гэж зарга мэдүүлж чадахгүй болно. Энэ нь цаашдаа, цагдаагийн үзэл бодлыг өөрчлөхөд шаардлагатай нийгмийн дарамт шахалтыг бүрдүүлэх боломжийг олгоно.

### 6.3 Хандлагыг ойлгох нь

Цагдаагийн байгууллагын холбогдох албан тушаалтантай уулзахын өмнө, тухайн байгууллага болон хувь хүний түвшинд хүний эрхийн асуудал, тэр дундаа хүний эрхийг хамгаалагчдын талаарх асуудалд асуудалд хэрхэн ханддаг ерөнхий хандлагыг танин мэдэх нь чухал юм. Энэ нь хамгаалагчдыг уулзалтын үеэр ямар үр дүнд хүрч болох, мөн болзошгүй асуудал, маргаан мэтгэлцээнийг урьдчилан таамаглах, тэдгээрийг хэлэлцэхэд бэлэн байхад тус болно.



Вашингтон Хотын цагдаагийн газрын түрүүч, трансжэндэр эмэгтэй Жессика Хокинс (зүүн гар талд) хэлтсийнхээ ЛГБТ иргэдийн асуудал хариуцсан нэгжийг удирддаг бөгөөд трансжэндэр тэмцэгч Руби Корадотой Вашингтон (АНУ) хотын өнгөт арьстай трансжэндэр эмэгтэйчүүд хоргодож байгаа Корадогийн гэрт ярилцаж байгаа нь, 2016 оны 10 сарын 10. © REUTERS/ Jonathan Ernst

<sup>52</sup> Хүний эрхийн шинэ тактик, Холбоотонтой болох нь, Хүний эрхийг хангахын тулд засгийн газрын ажилтнуудтай хамтрах нь (2003 он), <https://www.newtactics.org/sites/default/les/resources/Making-Allies-EN.pdf>



Энэ асуудлаар хамгийн түрүүнд анхаарах зүйл бол хамтрагчийн яриа хэлэлцээрт оролцох чинхүү хүсэл зориг юм. Хүний эрх хамгаалагчид, цагдаагийн ажилтнууд ерөнхийдөө хүний эрхийн асуудалд хэр ээлтэй хандаж (болохыг зорьж) байгаа эсэх, өөрсдийн гаргасан алдаа, дутагдалд хэр шүүмжлэлтэй хандаж байгаа эсэх, ажлаа сайжруулах хэр их хүсэл сонирхолтой байгаа зэргийг үнэлэх шаардлагатай. Зарим үед хамгаалагчид тэдэнд хандахаасаа өмнө цагдаагийнхан үр дүнтэй яриа хэлэлцээр хийх хүсэлтэй байгаа эсэхийг мэдэх боломжтой байж болох юм. Бусад тохиолдолд, анх удаа харилцах нь, цагдаагийн байгууллагаас үр дүнтэй хэлэлцүүлэгт оролцох амлалт нь хэр үнэн болохыг мэдэхэд хамгаалагчдад тус болно. Иймэрхүү хүсэл зориг байгаа гэдгийн шалгуур үзүүлэлтэд, хамтрагч нар мэдээллээ нээлттэй өгдөг байх (үйл ажиллагаатай холбоотой бодлоготой танилцах боломжтой байх гэх мэт), холбогдох дээд тушаалын албан хаагчтай уулзахад хялбар болох гэх мэтийг нэрлэж болох юм. Нөгөөтэйгүүр, чинхүү хүсэл зориг байхгүй байгааг харуулах үзүүлэлтүүд нь, жишээлбэл, холбогдох шийдвэр гаргагчидтай уулзалт товлоход үргэлж бэрхшээл учирах, оронд нь хэвлэл мэдээллийн ажилтан, эсвэл сургалтын ажилтантай уулзуулах, хамтрагчид бодитой оршин байгаа томоохон хүндрэл бэрхшээлийг үгүйсгэх (зөвхөн "ёс суртахууны доголдолтой" хэдхэн хүний тухай л ярих гэх мэт), эсвэл байгууллагын бүтэц дотроо хүний эрх хамгаалагчдыг өөр асуудлын тухай хэлэлцүүлэхээр чиглүүлэх зэргээр "ямар ч шийдэлгүй, цаг үрэх" мэтийг хэлж болно.

Цагдаагийн албан тушаалтнууд бодлого, зааварчилгааны талаар мэдээлэл өгөх үедээ аюулгүй байдлын талаар байнга дурьддаг ("нууцын зэрэглэлтэй" мэдээлэл). Цагдаагийн тусгай ажиллагаа явуулахтай холбоотой тактикийг нууцалж байгааг ойлгож, хүлээн авч болох ч ерөнхий бодлого, заавар журмыг олон нийтэд мэдээлэх нь ил тод, хариуцлагатай байдлын асуудал юм. Эдгээр бичиг баримтууд хүний эрхийг зөрчиж байгаа эсэхээс үл хамааран хүний эрх хамгаалагчдын дэвшүүлж буй асуудлуудыг хэлэлцэхэд цагдаагийн байгууллагын зүгээс нээлттэй байх хэрэгтэй.

Аюулгүй байдалтай холбоотой тайлбарын цаана ярилцагч нар өөрсдийнхөө алдаа дутагдлаа халхавчлах, цагдаа нарын хүний эрхийн гомдолтой холбоотой сайжруулах шаардлагатай асуудлуудын талаар нээлттэй ярилцах сонирхол муу байгааг харуулсан үзүүлэлт байж ч мэднэ.

Хүний эрхийг хамгаалагчид цагдаатай холбоотой асуудлаар ажиллах үед анхаарах ёстой өөр нэг зүйл бол цагдаагийн зүгээс гаргаж болзошгүй өрөөсгөл, хэт нэг талыг харах хандлага юм. Цагдаа нар хамгаалагчдыг цагдаагийн ажлын жинхэнэ бэрхшээл, сорилтын талаар ямар ч ойлголтгүй, "хүн өмөөрдөг гэмт хэрэгтнүүд" гэж үзэж болзошгүй. Иймэрхүү хандлагаас сэргийлэх, зохицуулахын тулд 3.4, 4.4 дэх хэсгүүдэд дэлгэрэнгүй өгүүлсэнчлэн хамгаалагчид цагдаатай холбоотой асуудлаар цагдаатай хэрхэн харилцах нь ихээхэн чухал юм.

Хэрвээ цагдаагийн зүгээс илэрхий дайсагнасан хандлагатай байгаа бол хүний эрх хамгаалагчид цагдаатай хамтрах шийдвэр гаргахаасаа өмнө нарийвчилсан эрсдэлийн үнэлгээ хийх хэрэгтэй. Эрсдэлийн үнэлгээ хийхдээ юуны өмнө хамтран ажиллах шийдвэр гаргаснаас учирч болох сөрөг үр дагаваруудыг авч үзэх хэрэгтэй. Үүнд, яриа хэлэлцээр ямар ч үр дүнд хүрэхгүй байх, эсхүл хүссэн үр дүнг бий болгож чадахгүй байх, цаашлаад хүний эрх хамгаалагчдыг болон тэдний хамгаалж байгаа хүмүүсийг ямар нэгэн аюулд оруулах, шийтгүүлэхэд хүргэх бодитой эрсдэлд хүргэж болно. Энэ мэт бодит эрсдэлийн үед хүний эрхийг хамгаалагчид нэн тэргүүнд өөрсдийн аюулгүй байдалдаа анхаарч, цагдаатай хамтрахаас өөр арга замаар хүний эрхийн асуудлыг шийдвэрлэх, эсвэл учирч болох эрсдэлээ хүлээж, ямартай ч цагдаатай харилцаад үзэх өөр нэгэн сонголт байж болно.

Үүнтэй холбоотой анхаарах бас нэг асуудал бол хамгаалагчид ихэнхдээ, үр дүнтэй яриа хэлэлцээр хийхийн тулд дэмжиж, хамгаалахын хүсч буй хүмүүсийнхээ талаар зарим нэг мэдээллийг цагдаад өгөх шаардлагатай болдог. Жишээ нь, хэн нэг хүнийг дур мэдэн баривчилсан хэргийг авч үзлээ гэхэд хохирогчийн зүгээс гомдол мэдүүлснийг цагдаа мэдэх л болно. Энэ нь цагдаагийн зүгээс хариу арга хэмжээ авахад хүргэж, хохирогчийг давхар аюулд оруулж мэднэ. Иймээс хамгаалагчид өөрт байгаа мэдээлэл нь анхаарал татахаар байвал цагдаад мэдэгдэхдээ болгоомжлох нь зүйтэй. Хэрвээ хариу арга хэмжээ авах эрсдэл өндөр байвал хамгаалагчид тухайн тодорхой тохиолдол, эсхүл хохирогчийн нэрийг ил болголгүйгээр тулгамдсан тодорхой бэрхшээлүүдийг илүү хийсвэр байдлаар дүрслэх зэрэг өөр арга хэрэглэх хэрэгтэй.

Цагдаа нар хүний эрхийг хамгаалагчдын дэмжиж, хамгаалж байгаа хүмүүсийн талаар өрөөсгөл буруу ойлголттой байгаа нь тэдний хандлага, үйл ажиллагаанд нөлөөлсөн байхыг үгүйсгэхгүй. Энэхүү ухамсартай ба ухамсаргүй өрөөсгөл ойлголт нь хувь хүний үзэл бодол, туршлагаар баяжиж, улмаар цагдаагийн ажилтнуудыг тодорхой бүлэг хүмүүсийг аюултай гэж үзэхэд хүргэж болзошгүй. Хүний эрх хамгаалагчид энэ мэт өрөөсгөл ойлголт, болзошгүй үр дагаврыг залруулахад чухал үүрэгтэй хэдий ч шүүмжлэлээ илэрхийлэх, тайлбарлахдаа болгоомжтой хандах хэрэгтэй. Цагдаагийн хэт нэг талыг барьсан өрөөсгөл хандлага, сөрөг үзэл бодол нь илэрхий байсан ч түүнийг нь шулуухан гаргаж тавих нь тэднийг биеэ өмгөөлж, хамгаалах байдалд оруулж, үр дүнтэй яриа хэлэлцээр хийх боломжийг сааруулна.

Тухайлбал, Баруун Европын олон оронд хүнийг яс үндсээр нь ялгаварласан асуудлыг шалгалаа гэхэд цагдаагийн ажилтнууд үүнийг маш эмзгээр хүлээн авч, өөрсдийгөө маш хурдан хамгаалж эхэлдэг ("би арьс өнгөөр ялгаварлагч биш" гэх мэтээр). Тиймээс энэ мэт асуудлыг хөндөхдөө аль болох эерэг уур амьсгал бүрдүүлэхийг хичээх нь чухал. Жишээ нь, арьс өнгөний үзэлтэй холбоотой өрөөсгөл ойлголтууд, эсвэл арьс өнгөөр ялгаварлах үзлийн талаар цагдаатай ярилцахаас илүүтэйгээр хэрхэн үр дүнтэй хамтран ажиллах вэ гэх мэт стратегийн асуудлаар ярилцах нь үр дүнтэй байж болох юм.

2007-2008 онд Нээлттэй Нийгмийн Шударга ёсны төлөөх Санаачилгаас хүнийг саатуулан зогсоох, нэгжих явдлыг хэрхэн үр дүнтэй шийдвэрлэх стратегийн төслийг хэрэгжүүлэхдээ Испани, Унгар, Болгарын зарим цагдаагийн газруудыг сонгон авч үндэсний цөөнхийн иргэдийг илүүтэй зогсоож, нэгжлэг хийдэг явдлыг багасгах олон тооны шинэчлэлийн арга хэмжээг танилцуулсан байдаг. Цагдаа, иргэний нийгмийн байгууллагууд хамтран ямар нөхцөлд саатуулан зогсоож, шалгах, нэгжлэг хийх талаарх шалгууруудыг боловсруулж, цагдаагийн ажилтнуудыг сургах, тоон мэдээллийг хэрхэн боловсруулах, дүн шинжилгээ хийх талаар танилцуулж, орон нутгийн иргэдтэй энэ талаар яриа хэлэлцүүлэг өрнүүлжээ. Төслийн зорилтот газруудад 6 сарын хугацаанд иргэдийг, тэр дундаа үндэсний цөөнхөд хамаарах иргэдийг саатуулан зогсоож шалгах, явдал бүурсныг төслийн мониторингийн судалгаа харуулжээ.<sup>53</sup>

Хүний эрхийг хамгаалагчид цагдаагийн ажилтнуудын хандлагыг ажиглахаас гадна өөрсдийн хандлага, болзошгүй сөрөг ойлголтуудын талаар мэдсэн байвал зохино. Хүний эрхийг зөрчиж байгаа цагдаатай байнга харилцаж байгаа хүний эрхийг хамгаалагчид цагдаа нарыг ерөнхийд нь "муу залуус" хэмээн үзэх хандлагатай байдаг. Бүтээлч яриа хэлэлцээр хийх боломжийг бий болгохын тулд хүний эрх хамгаалагчид энэхүү сөргөлдөөнийг намдааж, болж өгвөл арай өөр хандлагыг сонгох хэрэгтэй. Үүнийг хэрхэн хэрэгжүүлэх эсэх нь тулгамдаад байгаа хүний эрхийн асуудал болон цагдаагийн гүйцэтгэх үүргээс ихээхэн хамаарах нь тодорхой.

## 6.4 Хэрхэн харилцах болон урхинд орохоос сэргийлэх нь

Хүний эрхийг хамгаалагч болон цагдаа нарын хооронд харилцаа холбоо тогтоох янз бүрийн арга зам бий. Эдгээрээс аль нь хамгийн тохиромжтой вэ гэдэг нь хамгаалагчид юунд хүрэхийг зорьж байгаа болон цагдаагийн байгууллага дотор хэнтэй хамтарч байгаа вэ гэдгээс хамаардаг.

Цагдаагийн нэгж албан хаагчтай тухайлсан нэг асуудалд, тодорхой нэг хэргийг хэрхэн шийдвэрлэх талаар ярилцвал илүү үр дүнтэй байх болно. /баривчлагдсан иргэн хаана саатуулагдаж байгаа эсэх гэх мэт/ Хамгаалагчид хэнтэй ярилцаж байгаагаас хамаараад энэ мэт шууд яриа хэлэлцээрээр цагдаагийн зүй бус үйлдлийн талаар ярилцахад тохиромжтой байж болох юм.

Түүнчлэн цагдаагийн албан хаагчид болон тухайн асуудалд хамаарал бүхий холбогдох талуудыг нэг дор цуглуулан дугуй ширээний ярилцлага болон семинар зохион байгуулж болно. Иймэрхүү арга хэмжээ нь тодорхой сэдэв болон асуудлаар мэтгэлцээнийг өдөөж, оролцогчдын болон олон нийтийн дунд тухайн асуудлаарх ойлголтыг нэмэгдүүлэхэд тусална.

<sup>53</sup> Нээлттэй Нийгмийн Шударга ёсны төлөөх Санаачилга, Цагдаагийн байгууллагаас үндэсний цөөнхийг гэмт хэрэгт сэжиглэх явдлыг авч үзэх нь: Зогсоож, нэгжих явдлыг хэрхэн үр нөлөөтэй болгох стратегийн төсөл (2009 он).

Тухайлсан асуудлаар олон улсын болон үндэсний хэмжээний шинжээчдийг урьж хурал, семинар зохион байгуулах нь хууль сахиулах үйл ажиллагаанд хүний эрхийн хангах явдлыг (ялангуяа хууль сахиулах байгууллагын өөрийн) хэрхэн сайжруулах талаарх эрх баригчдын ойлголтыг сайжруулж чадна. Үүнийг үр дүнтэй болгохын тулд тухайн семинарт судлаачид, шинжээчдийн өгөх зөвлөмж, саналыг бодитоор хүлээн авч, зохих өөрчлөлт хийх эрмэлзэл бүхий цагдаагийн дээд тушаалын удирдлагуудыг оролцуулах шаардлагатай.

Хууль сахиулах байгууллагын албан тушаалтнуудтай хэлэлцүүлэг зохион байгуулах нь хүний эрх хамгаалагчдын хувьд шийдвэр гаргагч нартай цагдаагийн үйл ажиллагааны тодорхой аль нэг салбарын талаар ярилцах, эсхүл одоо хэрэгжиж байгаа бодлого, журам, заавруудын алдаа, тэдгээрийн зохицуулалтыг хэрхэн боловсронгуй болгох хэлэлцэх боломжийг олгоно.

Хэрвээ цагдаа нар хүний эрхийн зөрчлийн талаар хэлэлцэх чинхүү хүсэл зоригтой, үр дүнтэй яриа хэлэлцээр хийх хүсэлтэй байгаа бол хүний эрх хамгаалагчдын хувьд цагдааг зөвхөн буруутгаж, алдаа дутагдлыг нь шүүмжлэхийн оронд аль аль талдаа байгаа нийтлэг зүйл, нийтлэг ашиг сонирхлоо онцлон авч үзэх нь илүү үр дүнтэй гэж үзнэ. Цагдаа нар өөрсдөө хууль сахиулах үүргээ гүйцэтгэхдээ хүний эрх хамгаалагчид шиг байж, бэрхшээлтэй асуудлыг хэрхэн шийдвэрлэхэд анхаарлаа хандуулах нь ажлаа илүү үр дүнтэй гүйцэтгэхэд болон хамгаалагчдын зүгээс гаргаж тавьдаг зөвлөмжүүдийг анхааралдаа авах магадлалыг нэмэгдүүлнэ.

Хэрвээ цагдаа нартай ерөнхийдөө тааруу харилцаатай бол дайсагнасан хандлагатайгаар яриа хэлэлцээрт орох нь зөвхөн эсрэг үр дүнг л авчирна. Хүний эрхийг хамгаалагчид үйл ажиллагаа явуулахдаа цагдаад үргэлж хохирогчдын зөв байдаг, эсхүл хохирогчдод үргэлж цагдаагийн буруу байдаг гэсэн ойлголт төрүүлэхээс зайлсхийх хэрэгтэй. Үүний оронд, цагдаатай харилцахдаа, тэдний үзэл бодол болон тэдний ажилд тулгардаг сорилтуудыг ойлгоход бэлэн байгаа гэдгээ харуулах нь үр дүнтэй яриа хэлэлцээр хийх магадлалыг нэмэгдүүлнэ.



Голланд улс дахь үндэсний цөөнхийг зогсоож шалгадаг явдлыг зогсоохын тулд байгуулагдсан Ctrl Alt Delete хөдөлгөөний гишүүд цагдаа нартай Ctrl Alt Delete #5 арга хэмжээний үеэр ярилцаж байгаа нь, Амстердам Мэлвиг, Голланд улс, 2017 оны 12 сарын 11. Photo by Les Adu

Гэхдээ нөхцөл байдал үргэлж ийм байхгүй нь ойлгомжтой. Цагдаа хүний эрхийн үнэхээр ноцтой, илэрхий байдлаар зөрчсөн тохиолдолд хүний эрх хамгаалагчид дундын байр суурьтай (дүр эсгэж) байж чадахгүй тул шүүмжлэлтэй байр сууриа илэрхийлэх хэрэгтэй. Зарим улсад цагдаа нь дарангуйлагч засаглалын гар хөл дуртайяа болж, нийгмийн тодорхой бүлгийнхнийг, зарим үед, хүний эрх хамгаалагчдыг болон тэдний эрх ашгийг нь хамгаалж байгаа хүмүүсийг нухчин дарах нь байдаг. Энэ тохиолдолд хамгаалагчид цагдаагийн байгууллагатай ярилцах шаардлага байгаа эсэх, эсвэл ярилцаад ч үр дүнд хүрэхгүй, хүчин чармайлтаа гарзадсан хэрэг болох эсэхийг анхааралтай бодож үзэх ёстой.

Ямар ч тохиолдолд хүний эрх хамгаалагчдын үйл ажиллагаа, хүрэхээр эрмэлзэж буй зорилго нь ил тод байх ёстой. Үүнд цагдаагийн байгууллага эхнээсээ л тэднээс юуг хүсэж байгаа вэ гэдэг нь тов тодорхой байх явдал хамаарна. Цагдаатай үүсгэсэн харилцаа нь хүний эрхийг хамгаалагчид үйл ажиллагаагаа зогсоох, цагдааг бага шүүмжлэх, эсвэл цагдаагийн гаргасан хүний эрхийн зөрчил, зүй бус үйлдлийг буруушаахаа зогсоох үндэслэл болохгүй гэдгийг цагдаа нарт сайтар ойлгуулах нь чухал юм.

Түүнчлэн хамгаалагчид цагдаагийн ажил үүргийг гүйцэтгэхгүй гэдгээ цагдаа нарт ч, өөрсөдөө ч тодорхой ойлгуулах хэрэгтэй. Цагдаад юу хийхийг нь заах нь тэдний үүрэг биш бөгөөд цагдаагийн зүгээс ирэх иймэрхүү оролдлогуудаас сэрэмжтэй байх нь зөв. Үнэндээ бол, цагдаагийн үйл ажиллагааг шүүмжилсэн хүний эрх хамгаалагчдаас цагдаа нар “Тэгээд бид нар яах ёстой юм бэ?” хэмээн асуух нь түгээмэл байдаг бөгөөд энэ нь тэднийг цагдаагийн эсрэг турхирах гэсэн “урхины асуулт” байдаг гэдгийг сайтар санаж байх хэрэгтэй. Цагдаагийн үүрэгт ажил нь өдөр тутам хүнд хэцүү шийдвэр гаргах шаардлагатайболдог амаргүй ажил Дэг журмыг хэрхэн сахиулах, доод тушаалын ажилтнууд нь үүргээ хэрхэн гүйцэтгэх шийдвэрийг гаргах нь тушаал өгдөг албан тушаалтны үүрэг хариуцлагын асуудал мөн.

Хүний эрхийг хамгаалагчид цагдаатай хамтран ажиллах эрсдэлийг харгалзан үзэж тэдний үйл ажиллагаад аль болох бага оролцож, харин тэднийг хүний эрхийн хэрэгжилтийг сайтар хангах ажилдаа анхааран ажиллахыг шаардах нь зүйтэй. Хамгаалагчид хянан шалгагч, “хоточ нохой”-н үүрэг гүйцэтгэж, илрүүлсэн асуудлыг шийдвэрлэхэд шаардлагатай арга хэмжээ авахыг холбогдох үүрэг хүлээсэн хүмүүсээс шаардах хэрэгтэй. Гэхдээ, ямар зохистой арга хэмжээ авах, тэр нь ямар байх ёстой эсэх нь хамгаалагчдаас илүүтэйгээр цагдаагийн байгууллагын тогтоох ажил юм. Иймд хүний эрх хамгаалагчид цагдаа чиг үүргийг хэрэгжүүлэхээс зайлсхийвэл зохино.

Үүний адилаар, тухайн нөхцөлд байдалд зориулагдсан зааварчилгаа болон тоног төхөөрөмж хэрэглэх талаар гаргасан цагдаагийн шийдвэрийг ч “дэмжих” хэрэггүй.

2007 онд Германы Хэйлиндам хотод болсон Их 8-ын дээд хэмжээний уулзалт болон үүнийг эсэргүүцсэн жагсаал, цуглааныг хэрхэн зохицуулах бэлтгэл ажлыг хангах хүрээнд цагдаагийн байгууллагаас Эмнести Интернэшнлийн гишүүдийг эрсдэлт нөхцөлд ашиглагдах тусгайлан байгуулсан хорих газрын нөхцөл байдалтай танилцахыг урьсан байна. Байгууламжийг зорилгодоо сайн нийцсэн байна гэж үзжээ. Гэвч, хожим болсон баривчилгааны үеэр олон тооны хүн баривчлагдан саатуулагдсанаас 50 орчим хүнд зориулж барьсан байранд асуудал үүссэн байна. Эмнести Интернэшнлийн ажилтнууд хорих газрын байранд хэтэрхий олон хүн хорилоо хэмээн шүүмжилэхэд хариуд нь «та нар боломжийн байна гэж үзсэн шүү дээ» гэжээ.

Энэхүү жишээ нь байнга тохиолддог асуудлыг онцолж байгаа юм. Үүрэг гүйцэтгэх шийдвэр, сонголт нэг бол зөв зохистой, эсвэл хүндрэл бэрхшээлтэй, хүний эрхийг зөрчсөн, хор уршигтай байдлаар хэрэгждэг. Иймээс, хүний эрх хамгаалагчдын хамгийн зөв гэж бодож өгсөн зөвлөгөө нь хожим нь тэднийг хариуцлага хүлээхэд хүргэж болзошгүй урьдчилан тааварлашгүй, сөрөг үр дагаварт хүргэхийг үгүйсгэхгүй. Дахин хэлэхэд цагдаа нарт дэг журам хэрхэн сахиулах талаар зөвлөгөө өгөх нь хүний эрх хамгаалагчдын хийх ажил биш.

Хүний эрх хамгаалагчид цагдаа нарын “нүд хуурсан” байдлаар тэдэнтэй харилцах нөхцөл байдалд орохоос сэрэмжлэх нь зүйтэй. Цагдаа нар хүний эрхийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, эсвэл үр дүнтэй яриа хэлэлцээр хийх гэж оролдохоосоо илүүтэйгээр хүний эрхийг хамгаалагчидтай тогтоосон харилцаагаа үзүүлэн болгон ашиглах, өөрийн чиг үүргийг

хэрэгжүүлэхийн тулд хамгаалагчид болон олон нийтийн хүчин чармайлтыг буруугаар ашиглахыг үгүйсгэхгүй.

2012 онд Филиппин улсад, цагдаагийн газрын хүний эрхийн хэлтсээс, цагдаагийн газруудыг хүний эрхийг хангаж байгаа байдлаар нь байр эзлүүлж, сайн ажиллаж байгааг нь шагнах нэгэн төсөлд оролцохыг хүний эрхийн ТББ-уудаас хүсчээ. Юуны өмнө уг үйл ажиллагааны зорилгоор ашиглагдах 1000 гаруй шалгуур үзүүлэлтийн жагсаалтыг ТББ-ууд хэрхэн үнэлж байгаа талаар асууж, тэдгээрийг цагдаагийн газруудын үнэлэхдээ ашиглах боломжтой эсэх талаар санал авчээ. Цагдаагийн газруудын хүний эрхийг хүндэтгэх явдлыг урамшуулах нь сайн хэрэг боловч бодит хэрэгжилт болон хүний эрхийн ТББ-уудын дүгнэлтийн аль аль нь хоёр төрлийн бэрхшээл дагуулсан байна. Маш олон шалгуур үзүүлэлт хүний эрхийн олон улсын баримт бичгүүдийн талаарх ерөнхий мэдлэгт голлон анхаарснаас биш, баривчлагдсан хүнтэй хэрхэн харилцдаг вэ гэх мэт цагдаагийн ажилтнууд өдөр тутамдаа хүний эрхийг хангах талаар хэрхэн ажиллаж байгааг үнэлж чадаагүй байна. Энэ бол тухайн цагдаагийн газарт хүний эрхийн ноцтой зөрчил гардаг эсэхээс үл хамааран сайн үнэлгээ авах боломжтой гэсэн үг юм. Түүнчлэн, улсын нийт нутаг дэвсгэрийн хэмжээ болон үнэлгээнд хамрагдах цагдаагийн байгууллагын тооноос харахад оролцсон ТББ-үүд өөрсдийнх нь хийсэн үнэлгээний үр дүн үнэн эсэхийг хянах боломж маш тааруу байна. Энэ хоёр хүчин зүйл нийлээд, хэрвээ тухайн цагдаагийн газар сайн үнэлгээ авсан бол тэднийг хүний эрхийн зөрчилтэй холбогдсон хэмээн шүүмжлэх, мэдээлэх боломжийг ТББ-үүдэд хязгаарлаж болох талтай.<sup>54</sup>

Сургалтын байгууллагуудтай хамтрах үедээ хамгаалагчид сургалтын агуулга дахь хүний эрхтэй холбоотой хийдэл дутагдлын талаар санал бодлоо хэлэхдээ зохист хязгаарыг баримталвал зохино. Сургалтын агуулгыг өөрсдөө боловсруулах болон сургалт явуулах үүрэг хүлээх нь хүний эрх хамгаалагчид үйл ажиллагаагаараа дамжуулан хүрэхийг хүсч байгаа өөрчлөлтөндөө хүрч чадахгүй байх дараах эрсдлийг дагуулж мэднэ.

Юуны өмнө, мэргэжлийн зохих шаардлагыг хангасан, хангалттай сургаж бэлтгэгдсэн ажилтантай байх нь цагдаагийн байгууллагын өөрийн үүрэг хариуцлагын асуудал бөгөөд хэрэв хүний эрх хамгаалагчид энэхүү үүргийг цагдаагийн байгууллагын өмнөөс хүлээж, үүрэг гүйцэтгэдэг албан хаагчдад шууд сургалт явуулвал хожим өөрсдөд нь ноцтой сөрөг үр дагаврыг авчирч болзошгүй. Хэрэв цагдаагийн ажилтан ийм сургалтыг дүүргээд, ямар нэг байдлаар зүй бус, зохисгүй авир гаргавал сургалт явуулсан хамгаалагчдыг буруутгах нь лав. Энэ нь цагдаагийн байгууллагыг энэ талаар хүлээсэн үүрэг хариуцлагаасаа зайлсхийх боломжийг олгоод зогсохгүй, олон нийтийн өмнө хүний эрх хамгаалагчдын нэр хүндийг унагахад хүргэж болзошгүй.

Цаашилбал, хүний эрх хамгаалагчдын явуулдаг хүний эрхийн сургалт нь хичээлийн танхимаас гадуур цагдаагийн ажилтны зан үйлд тэр бүр шууд нөлөө үзүүлдэг гэж дүгнэхэд бэрхшээлтэй. Хүний эрхийн сургалт нь зөвхөн хүлээн зөвшөөрөгдсөн бодлого, заавар журамд нийцсэн, мөн дэг журам сахиулахад шаардлагатай бодит ур чадварыг хөгжүүлэх аргачлалтай уялдсан тохиолдолд л үр дүнтэй болно. Иймээс хүний эрхийн талаарх асуудлыг тусгайд нь салгаж авч үзэлгүйгээр сургалтын бүхий л агуулгад шингээж, уялдуулж өгөх нь зүйтэй. Ингэж чадвал цагдаагийн ажилтнууд өдөр тутамдаа үүрэг гүйцэтгэхдээ хүний эрхэд хүндэтгэлтэй хандах болно.<sup>55</sup>

Тухайлбал, хүнд хүч хэрэглэх болон хэрхэн баривчлах талаар сургалт явуулахдаа холбогдох хүний эрхийн анхаарах асуудлуудыг практик дасгал болон шийдвэр гаргах процесст багтаан авч үзэх ёстой.<sup>56</sup> Хэзээ буудах, эсвэл буудахгүй байх, хэнийг, хэрхэн гавлах (эсвэл гавлахгүй байх)

<sup>54</sup> Уг төсөл нь Филиппиний Үндэсний Цагдаагийн газрын хүний эрхийн хэлтийн дотоод асуудлуудаас болоод бүрэн хэрэгжиж чадаагүй байна.

<sup>55</sup> АЗХЭХБ, Хууль сахиулах байгууллагын ажилтнуудад хүний эрхийн боловсрол олгох удирдамж, Варшав, 2012 он, 16-р хуудас: “Хууль сахиулах байгууллагын ажилтнуудын хүний эрхийг хангах, хамгаалах, хөхиүлэн дэмжихэд гүйцэтгэх нэн чухал үүрэг хариуцлагын хүрээнд, мөрдөн байцаах, баривчлах, хүч болон галт зэвсэг хэрэглэх, олон нийттэй харилцах, мэдээлэх зэрэг сургалтын бүхий л хэсэгт хүний эрхийн асуудал салшгүй хэсэг нь байх ёстой. Хүний эрхийн сургалтыг үүрэг гүйцэтгэх үеийн бодит байдлаас салгахгүй байх нь чухал юм. Иймээс, хүний эрхийг дангаар нь тусдаа сэдэв болгохгүйгээр нэгдсэн, цогц байдлаар сургалтаа явуулах хэрэгтэй.” ТББ-уудын явуулдаг хүний эрхийн сургалтуудын талаарх шүүмжийг: Келемаже/Гревал, Хүний эрхийн зөрчлөөс сэргийлэх нь, Аюулгүй байдлыг хангах салбарын шинэчлэлд хүний эрхийн боловсролын үүргийг нэмэгдүүлэх нь, Хүний эрх бидний амьдралд сэтгүүл, цуврал #5, дугаар 2, 2013 он, 243, 247-р хуудас.

<sup>56</sup> Бинэрт, А., Үг ярианаас үйл ажиллагаанд: Хууль сахиулах байгууллагын албан хаагчдын хүч ба галт зэвсэг хэрхэн хэрэглэх тухайд хүний эрхийн хуулийг хэрхэн амьдралд хэрэгжүүлэх вэ, Аюулгүй байдал ба хүний эрх байгууллагын хэвлэл (2016 он) 200-220.



гэх зэргийг цагдаад хэлж өгөх нь хүний эрх хамгаалагчдын үүрэг биш учраас үүнээс зайлсхийх хэрэгтэй. Иймээс хамгаалагчид эдгээр асуудлыг сургалтын хөтөлбөрт оруулахад сургалтын байгууллагуудад туслахын тулд, улс орныхоо цагдаагийн өдөр тутмын үйл ажиллагааг ажиглаад, илрүүлсэн хүний эрхийн асуудлуудаар зөвлөгөө өгөхөөр тэдэнтэй яриа хэлэлцээр хийж болох юм. Гэхдээ, тодорхой сургалт зохион байгуулах нь цагдаагийн байгууллагын үүрэг хариуцлагад хэвээр үлдвэл зохино.

Хүний эрх хамгаалагчид тогтмол лекц унших, сургалтын агуулгыг хянах зэргээр сургалтын байгууллагуудтай байнга харилцахаас зайлсхийх хэрэгтэй. Иймэрхүү харилцаа нь хамгаалагчид болон сургалтын байгууллага хоорондоо харилцан хамааралтай болох эрсдэлийг үүсгээд зогсохгүй, хамгаалагчдын сургалтын байгууллага, цаашлаад цагдаагийн үйл ажиллагаанд шүүмжлэлтэй хандах чадварт сөргөөр нөлөөлж болзошгүй (жишээ нь, хамгаалагчид хүний эрхийн зөрчилд тэднийг буруутгавал цагдаагийн зүгээс хамгаалагчидтай үүсгэсэн харилцаа холбоогоо дуусгавар болгохыг хүсч болно). Түүнчлэн, хамгаалагчид хэрвээ хүлээсэн үүргээ биелүүлж чадахгүйд хүрвэл, цагдаагийн байгууллагатай хамтын ажиллагаа дуусгавар болсноос үүдэх асуудлуудад хариуцлага хүлээх эрсдэлтэй. Мөн иймэрхүү асуудлууд нь хүний эрхийн ноцтой зөрчилд хариуцлага хүлээхгүй байх гэх мэт жинхэнэ бэрхшээлтэй асуудлуудыг хэлэлцэхээс зайлсхийх замыг цагдаагийн дарга, удирдлагуудад гаргаж өгдөг.

Гэхдээ, хүний эрх хамгаалагчид зарим үед лекц унших, цагдаагийн байгууллагын зохион байгуулсан үйл ажиллагаанд оролцох гэх мэтээр харилцаа холбоогоо хадгалж байх хэрэгтэй. Энэ нь харилцаа холбоо тогтоох, хүний эрхийн ямар асуудлаар хэлэлцэж байгаа болон цагдаагийн байгууллага дотооддоо энэ талаар ямар байр суурьтай байгааг цагдаагийн сургагч багш нарын оролцоогүйгээр мэдэхэд тус болно.

## 6.5 Дүгнэлт, зөвлөмж

Цагдаагийн байгууллага нь хүний эрх хамгаалагчдын хувьд шууд харилцах чухал хамтрагч нь байж чадах юм. Хамтын ажиллагаа нь үр дүнтэй, хамгаалагчдын хүний эрхийг хамгаалах зорилгод хувь нэмрээ оруулж болох хэдий ч, цагдаагийн байгууллагатай ямар асуудлыг хэлэлцэж болох эсэхийг оновчтой тодорхойлж, мөн өөрсдийн стратегийг боловсруулахын тулд хамгаалагчид бүхий л нөхцөл байдлыг үнэлсэн, бүрэн дүүрэн ойлголт, мэдлэгтэй (өмнөх бүлгүүдэд өгүүлсэнчлэн, цагдаагийн үйл ажиллагааг зохицуулдаг дотоодын хууль тогтоомжийг оруулаад) байх нь чухал юм. Улс орны болоод тухайн нөхцөл байдлаас хамаараад, цагдаад шууд хандах нь зөв шийдвэр биш, аюултай ч байж болох бөгөөд хүний эрхийн тулгамдсан асуудалд анхаарлаа хандуулах зохистой арга зам биш байж болно.

- Цагдаагийн байгууллагатай шууд харилцахаар төлөвлөж байхдаа, тулгамдаж буй асуудлаар харилцаж чадах хамгийн тохирсон хамтрагч(д)-ыг олохын тулд хамгаалагчид цагдаагийн байгууллагын бүтцийн талаар ойлголттой болох хэрэгтэй. Хэлэлцүүлгийн үеэр хамгаалагчид хүний эрхийн хэрэгжилтийг хангахтай холбоотой алдаа, дутагдлын талаар ярихаас аль болохоор татгалзаж, цагдаа өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэх, шийдвэр гаргахад нь оролцох, зөвлөгөө өгөхөөс зайлсхийх хэрэгтэй.
- Хүний эрх хамгаалагчид тулгамдаж буй асуудалд болон хамгаалагчдын талаарх (үйл ажиллагаанд) цагдаагийн хандлагыг үнэлэх шаардлагатай. Энэ нь хүний эрхийн хэрэгжилтийг сайжруулах чинхүү хүсэл зориг цагдаагийн байгууллагад байгаа эсэхийг тандах, тэдний хандлагыг урьдчилан танин мэдэх, тэдэнтэй харилцахад гарч байж болзошгүй өрөөсгөл болон эмзэг асуудлуудыг тодорхойлох боломжийг хамгаалагчдад олгоно. Хэрвээ хүний эрх хамгаалагчид цагдаагийн илэрхий зохисгүй, бүр дайсагнасан хандлагатай тулгарвал, зөвхөн хүчин чармайлтаа гарздахаас сэргийлэхийн тулд төдийгүй, өөрсдийн болоод эрхийг нь хамгаалахаар тэмцэж байгаа хүмүүсийнхээ аюулгүй байдлын төлөө тухайн тулгамдаж буй хүний эрхийн асуудлыг өөр байдлаар гаргаж тавих талаар анхаарч үзэх хэрэгтэй.
- Хэрвээ цагдаагийн зүгээс үр дүнтэй яриа хэлэлцээр хийх чинхүү хүсэл эрмэлзэл байгаа тохиолдолд хүний эрх хамгаалагчид аль болохоор тэдний үзэл бодол, тулгардаг сорилт бэрхшээлийг нь ойлгохыг хичээх хэрэгтэй. Гэхдээ хамгаалагчид өөрсдийнхөө итгэж болох байдалд аюул учруулах, мөн «хоточ нохойн» чухал үүргээ найр тавьж өгөхөөс болгоомжилвол зохино. Тэдний оролцоо бодлого боловсруулах, цагдаагийн ажилтнуудад сургалт явуулах зэрэг цагдаагийн үүрэг хариуцлагыг өмнөөс нь хүлээх бус, алдаа дутагдлыг нь шүүмжлэхээр хязгаарлагдвал зохино.

## Төгсгөлийн үг ба зөвлөмжүүд

Хүний эрх хамгаалагчид хэв журам сахиулах асуудлаар ажиллаж байхдаа, эсвэл цагдаагийн байгууллагатай холбоо тогтоох үедээ боломжийг эрэлхийлэхээс гадна сорилт бэрхшээлийг ойлгож, зарим үндсэн асуудлуудыг марталгүй санаж явах хэрэгтэй.

**Хуулиа мэдэх:** Хүний эрх хамгаалагчид өөрт болон үйл ажиллагаа явуулахад хамааралтай дотоодын хууль тогтоомжийг мэддэг байх хэрэгтэй. Энэ нь хууль тогтоомжоор цагдаа ямар үүрэг хүлээдэг болохыг ойлгохоос гадна цагдаа ердийн дотоодын хууль тогтоомжийг зөрчих, эсхүл олон улсын хэм хэмжээнд нийцээгүй дотоодын хууль тогтоомжийг зөрчих зэргийн ялгааг зөвөөр ойлгох боломжийг олгоно.

**Хандлагыг ойлгох:** Хүний эрх хамгаалагчид өөрсдөд нь болоод үйл ажиллагаанд хандаж байгаа цагдаагийн хандлагын талаар ойлголттой байх хэрэгтэй. Энэ нь цагдаагийн бодлогын түвшиний асуудлыг хувь цагдаагаас үүдэн бий болж байгаа асуудлаас зааглахад туслах ба тухайн асуудлыг цагдаагийн байгууллагын хамт хэлэлцэж байгаа тохиолдолд, цагдаагийн байгууллага хэрхэн уг асуудлыг шийдвэрлэж байгаад үнэлэлт өгч болно.

**Хэрхэн харилцах вэ:** Хүний эрх хамгаалагчид цагдаагийн ажил үүргийн бодит байдал болон сорилт бэрхшээлүүдийг санаж явах хэрэгтэй. Энэ нь тэдэнд бодит байдалд нийцсэн, хууль зүйн үндэслэл бүхий мэдэгдэл хийх, үр дүнтэй зөвлөмж өгөх боломжийг олгоно. Цагдаагийн байгууллагын бүтцийн талаарх ойлголт нь хамгаалагчдад шийдвэр гаргах хангалттай эрх мэдэлтэй, өөрсдийн харилцах хүн (хүмүүс)-ээ тодорхойлж, харилцаа холбоо тогтооход тус болно. Цагдаатай харилцаж байх үедээ хамгаалагчид өөрсдийн итгэмжит байдалд аюул учруулах, цагдаагийн нөлөөнд автах, цагдаагийн үүрэг хариуцлагыг өмнөөс нь хүлээж, тэднээс хараат болохоос сэрэмжлэх хэрэгтэй.

Эцэст нь хэлэхэд, цагдаа болон хүний эрх хамгаалагчдын харилцаа нь тухайн улс орон болон нөхцөл байдлаас хамааран харилцан адилгүй байх бөгөөд хамгаалагчдын үйл ажиллагаанд эерэг болон сөрөг нөлөө үзүүлдэг. Зарим тохиолдолд, цагдаа нь хүний эрх хамгаалагчдыг аюулд өртүүлж мэдэх маш эрсдэлтэй байдал нөхцөл байдалд хүргэдэг. Гэхдээ, бусад олон тохиолдолд цагдаа эрсдэлийг бууруулах, тэр ч байтугай цагдаатай хамтран хүний эрхийн асуудлыг шийдвэрлэх ч боломжтой.

Цагдаа ба Хүний эрх Хөтөлбөрийн баг хамт олон цагдаагийн байгууллагатай амжилттай хамтран ажиллаж, хүний эрхийн асуудлыг шийдвэрлэж чадсан хүний эрх хамгаалагчдаас амжилтын түүхийг нь сонсохыг хүсч байна, бидэнтэй [phrp@amnesty.nl](mailto:phrp@amnesty.nl) хаягаар амжилтын түүхээ хуваалцаарай.

UIN.MN  
СУДАЛГААНЫ САН

**UIH.MN**  
СУДАЛГААНЫ САН

## Хүний эрх хамгаалагчдын ашиглах баримт бичгүүд

### Хүний эрх хамгаалагчдын асуудлаарх олон улсын хэм хэмжээ

- Африкийн Хүний Эрхийн Хамгаалах Комисс, Африк дахь хүний эрх хамгаалагчдын хамгаалах тухай тогтоол (2004 он), <http://www.achpr.org/sessions/35th/resolutions/69/>
- Европын Зөвлөл, Хүний эрх хамгаалагчдын эрхийг хамгаалах, тэдний үйл ажиллагаа дэмжих тухай Европын Зөвлөлийн Сайд нарын Комиссийн Тунхаглал (2008 он), [https://search.coe.int/cm/Pages/result\\_details.aspx?ObjectID=09000016805d3e52](https://search.coe.int/cm/Pages/result_details.aspx?ObjectID=09000016805d3e52)
- Европын Холбоо, Хүний эрх хамгаалагчдын талаарх ЕХ-ний удирдамж (2008 он), [https://eeas.europa.eu/sites/eeas/les/eu\\_guidelines\\_hrd\\_en.pdf](https://eeas.europa.eu/sites/eeas/les/eu_guidelines_hrd_en.pdf)
- Америк тивийн улс орнуудын байгууллага, Ерөнхий ассамблей, Америк тив дахь хүний эрх хамгаалагчид, Америк тивийн хүмүүсийн эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжихийн тулд ажиллаж байгаа хувь хүн, бүлэг, иргэний нийгмийн байгууллагуудыг дэмжих нь, тогтоол 1671 (1999 он), <http://www.oas.org/juridico/english/ga-res99/eres1671.htm>
- НҮБ-ын Ерөнхий Ассамблей, Нийтээр хүлээн зөвшөөрсөн хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, хөхиүлэн дэмжих хувь хүн, нийгмийн нэгж, байгууллагын эрх, үүргийн тухай тунхаглал, А/RES/53/144 (1998 он), <http://www.ohchr.org/Documents/Issues/Defenders/Declaration/declaration.pdf>

### Хүний эрх хамгаалагчдын аюулгүй байдлын талаарх баримт бичгүүд

- Цахим хил хязгаар байгууллага, Өөрийгөө хамгаалах камержуулалт, Цахим харилцаа холбоогоор аюулгүй байдлаа хангах тухай зөвлөмж, (огноогүй), <https://ssd.eff.org/en>
- Тэргүүн шугам дахь хамгаалагчид, Аюулгүй байдлын гарын авлага, Эрсдэлт нөхцөлд байгаа хүний эрх хамгаалагчдад зориулсан бодит аргачлалууд (2016 он), <https://www.frontlinedefenders.org/en/resource-publication/workbook-security-practical-steps-human-rights-defenders-risk>
- Тэргүүн шугам дахь хамгаалагчид, Тактикийн хамтарсан технологи – Цахим аюулгүй байдлын аргачлал болон тактикууд (огноогүй), <https://securityinabox.org/en/>
- Олон улсын хамгаалалт байгууллага, Хүний эрх хамгаалагчдыг хамгаалах шинэ хамгаалалтын гарын авлага (2009 он), <https://www.protectioninternational.org/wp-content/uploads/2012/04/Protection-Manual-3rd-Edition.pdf>
- Олон улсын хамгаалалт байгууллага, Ажиглалт хийх болон харилцан ажиглах, Хүний эрх хамгаалагчид болон тэдний байгууллагад (2014 он), [https://www.protectioninternational.org/wp-content/uploads/2015/10/Online-NO2\\_SURVEILLANCE-AND-COUNTER-SURVEILLANCE-FOR-HUMAN-RIGHTS-DEFENDERS-AND-THEIR-ORGANISATION-310315.pdf](https://www.protectioninternational.org/wp-content/uploads/2015/10/Online-NO2_SURVEILLANCE-AND-COUNTER-SURVEILLANCE-FOR-HUMAN-RIGHTS-DEFENDERS-AND-THEIR-ORGANISATION-310315.pdf)
- Хамгаалагчдыг хамгаалах нь, Тоон системийн хамгаалалтын туршлагауд (2017 он), <http://practicaldigitalprotection.com/#en>

### Дэлгэрүүлж унших баримт бичгүүд

- Нидерландын Эмнести Интернэшнл, Цагдаа ба хүний эрх хөтөлбөр, Хууль сахиулах байгууллагын албан хаагчдын хүч, ба галт зэвсэг хэрэглэхэд баримтлах НҮБ-ын үндсэн зарчмууд (2015 он), <https://www.amnesty.nl/actueel/use-of-force-guidelines-for-implementation-of-the-un-basic-principles-on-the-use-of-force-and-arms-by-law-enforcement-officials>
- Нидерландын Эмнести Интернэшнл, Цагдаа ба хүний эрх хөтөлбөр, Цагдаагийн хяналт (2015 он), Баримт бичгийн цуврал #2, <https://www.amnesty.nl/actueel/short-paper-series-no-2-police-oversight>

- Нидерландын Эмнести Интернэшнл (), Цагдаа ба хүний эрх хөтөлбөр, Жагсаал цуглааны үеэр дэг журам сахиулах нь, Баримт бичгийн цуврал #1 (2013 он), <https://www.amnesty.nl/actueel/short-paper-series-no-1-policing-assemblies>
  - Бинерт, А., Үг ярианаас үйл ажиллагаанд: Хууль сахиулах байгууллагын албан хаагчдын хүч болон галт зэвсэг хэрхэн хэрэглэх тухайд хүний эрхийн хуулийг хэрхэн амьдралд хэрэгжүүлэх вэ, Аюулгүй байдал ба хүний эрх байгууллагын хэвлэл (2016 он) 200-220. <http://booksandjournals.brillonline.com/content/journals/10.1163/18750230-02701002>
  - Олон улсын улаан загалмайн хороо, Зэвсэгт мөргөлдөөн, хүчирхийллийн бусад нөхцөл байдалд хүмүүнлэгийн болон хүний эрхийг хамгаалж буй хүмүүсийг хамгаалах ажилд тавих мэргэжлийн стандарт (2018 он), <https://shop.icrc.org/professional-standards-for-protection-work-carried-out-by-humanitarian-and-human-rights-actors-in-armed-conflict-and-other-situations-of-violence-2512.html>
  - НҮБ-ын хүний эрхийн дээд комиссарын газар, баримтат цуврал #29, Хүний эрх хамгаалагчид, Хүний эрх хамгаалах эрхийг хамгаалах нь (2004 он), <http://www.ohchr.org/Documents/Publications/FactSheet29en.pdf>
  - АЗХЭХБ, Тайван жагсаал цуглааныг хянах тухай гарын авлага (2011 он), <https://www.osce.org/odihr/82979?download=true>
  - АЗХЭХБ, Жагсаал цуглааны үеэр хэв журам сахиулах хүний эрхийн гарын авлага (2016 он), <https://www.osce.org/odihr/guidelines-on-the-protection-of-human-rights-defenders>
  - Олон улсын хамгаалалт байгууллага, Тусгай тайлан, Хүний эрхийг хамгаалагчдыг хамгаалах олон нийтийн бодлого (2017 он), <https://www.protectioninternational.org/en/node/1537>
  - НҮБ-ын Тусгай илтгэгч Майна Киай, Жагсаал цуглааныг зохицуулах 10 зарчим: Иргэний нийгмийн удирдамж (2017 он), <http://policehumanrightsresources.org/wp-content/uploads/2017/02/UN-Special-Rapporteur-10-Principles-for-the-proper-management-of-assemblies.pdf>
  - НҮБ-ын Тусгай илтгэгч Майна Киай, Жагсаал цуглааныг зохицуулах 10 зарчим: Хэрэгжилтээ хянах нь (2016 он), <https://www.ohchr.org/Documents/Issues/FAssociation/10PrinciplesProperManagementAssemblies.pdf>
- Хэв журам сахиулахтай холбоотой дотоодын болон олон улсын хүний эрхийн эрх зүйн баримт бичгүүд, олон улсад гарсан бүтээлүүдийг үзэхийг хүсвэл Цагдаа ба Хүний эрхийн баримт бичгийн сан: <http://policehumanrightsresources.org/>-д хандаарай.




## Нидерландын Эмнести Интернэшнл «Цагдаа ба Хүний эрх Хөтөлбөр»

Хэв журам сахиулах болон хүний эрхийн асуудал нь эрчимтэй хөгжиж байгаа судалгааны салбар юм. Хүний эрхийг хангах талаарх сүүлийн үеийн яриа хэлэлцээр нь төр, түүний байгууллагуудын хүний эрхийг зөрчиж байгаа сөрөг үйл ажиллагаанаас гадна төрийн эерэг үүрэг хариуцлагын асуудалд ч анхаарал хандуулах боллоо. Энэ нь цагдааг хүний эрхийг хамгаалагч гэж үзэх боломжийг олгоно. Түүнчлэн, хүний эрхийг зөвхөн цагдаа болон төрийн албан хаагчид зөрчдөггүй, төрийн бус тоглогчид ч зөрчдөг гэсэн ойлголт гарч ирэв. Цагдаа болон хүний эрх хамгаалагчдын аль аль нь аюулгүй, тайван нийгмийн төлөө тэмцэж байна. Энэхүү ойлголт нь цагдаа болон ТББ-үүдыг бие биенээ эсэргүүцэхээс илүүтэй хамтран ажиллах боломжийг нээж өгч байгаа юм.

Гэсэн хэдий ч, ТББ-үүд болон цагдаагийн хамтын ажиллагаа нь хүндрэл бэрхшээлээр дүүрэн байдаг. Ихэнхдээ цагдаагийн ажилтан хүний эрх хамгаалагчдаас өөр санаа бодолтой байх хандлагатай ба нэг асуудлын тухай өөр өөр байдлаар ярьж, шалтгаан ба үр дагаврын талаар өөр өөр дүгнэлт хийдэг. Энэ нь зарим тохиолдолд тэдний нийгэмд гүйцэтгэж байгаа харилцан адилгүй үүрэг, хариуцлагаас үүдэлтэй бол зарим тохиолдолд уламжлалт хэвшмэл ойлголттой холбоотой байдаг.

Цагдаа ба хүний эрх хөтөлбөр нь Эмнести Интернэшнл, бусад хүний эрхийн төлөө тэмцэгчдийн цагдаатай холбоотой асуудлуудыг илүү үр дүнтэй шийдвэрлэхийн тулд цагдаагийн байгууллагын тухай, мөн хэв журам сахиулахтай холбоотой ойлголтыг нэмэгдүүлэх зорилготой юм. Бид Цагдаа ба Хүний эрхийн асуудлаар хүний эрх хамгаалагчдад зориулсан сургалтыг санал болгохын хамт стратегийн хурал зөвлөгөөнийг удирдан явуулдаг.

Дэлгэрэнгүй мэдээллийг [www.amnesty.nl/policeandhumanrights](http://www.amnesty.nl/policeandhumanrights) цахим хуудаснаас авна уу.



Эмнести Интернэшнл нь 7 сая гаруй гишүүд дэмжигчидтэй бөгөөд дэлхий нийтээр хүний эрхийг эрхэмлэн дээдлэхийн төлөөх даан дэлхийн хөдөлгөөн юм.

Бидний зорилго Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал болон бусад олон улсын хүний эрхийн хэм хэмжээнд заасан бүхий л хүний эрхүүдийг хүн бүрт бүрэн эдлүүлэхэд оршино.

Бид аливаа засгийн газар, улс төрийн үзэл бодол, эдийн засгийн ашиг сонирхол болон шашин шүтлэгээс ангид, хараат бус бөгөөд гишүүд дэмжигчдийнхээ хандив, тусламж, татвараар санхүүждэг байгууллага юм.

ЭМНЕСТИ  
ИНТЕРНЭШНЛ

